

Улсын бүртгэлийн
Дугаар.....

Нууцын зэрэглэл: Б

Аравтын бүрэн
ангилалын код

Төсөл хэрэгжүүлэх гэрээний
дугаар: SSA_2017/72

**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ФИЛОСОФИЙН ХҮРЭЭЛЭН**

**“МОНГОЛЧУУДЫН ЁС СУРТАХУУН-ЭРХ ЗҮЙН ХӨГЖЛИЙГ ХАНГАХ
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛЖ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГЫГ
ИЖ БҮРЭН ТОДОРХОЙЛОХ НЬ”**

Суурь судалгааны төслийн тайлан

2017-2019

Гүйцэтгэгч: ШУА-ийн Философийн хүрээлэн

Удирдагч: Академич С.Нарангэрэл

Санхүүжүүлэгч байгууллага: Шинжлэх ухаан, технологийн сан

Захиалагч байгууллага: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам

Тайлан өмчлөгч: ШУА-ийн Философийн хүрээлэн
Улаанбаатар хот 15141. Чингэлтэй дүүрэг,
Баруун сэлбэ-15
Э-хаяг: info@ip.ac.mn
Утас: 33-08-46, 33-08-47
Факс: (976-11)-33-08-46

Улсын бүртгэлийн
дугаар: 015

Нууцын зэрэглэл: Б

Аравтын бүрэн
ангилалын код

Төсөл хэрэгжүүлэх гэрээний
дугаар:

SSA_2017/72

**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ФИЛОСОФИЙН ХҮРЭЭЛЭН**

**“МОНГОЛЧУУДЫН ЁС СУРТАХУУН-ЭРХ ЗҮЙН ХӨГЖЛИЙГ ХАНГАХ
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛЖ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГЫГ
ИЖ БҮРЭН ТОДОРХОЙЛОХ НЬ”**

Суурь судалгааны төслийн тайлан

2017-2019

Гүйцэтгэгч:

Содовсүрэнгийн Нарангэрэл (академич)
Дугарсүрэнгийн Батмөнх (доктор)
Уртнасангийн Батцэрэн (доктор)
Тожилын Алтансүвд
Мэндбаярын Долгорсүрэн (ЭША, докторант)
Толягийн Төмөрбаатар (ЭША, магистр)
Ёндонгийн Ундрал (ЭША, магистр)
Цогтсайханы Жаргал (ЭШДА, магистрант)
Пүрэвдоржийн Мягмарсайхан (ЭША, магистр)
Цэвээндоржийн Баянмөнх (ЭША, магистр)
Батсүхийн Лхагважаргал (ЭША, магистр)

Захиалагч байгууллага:

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам

Тайлан өмчлөгч:

ШУА-ийн Философийн хүрээлэн

Улаанбаатар
2019

РЕФЕРАТ

ШУА-ийн Философийн хүрээлэнгээс 2017-2019 онд *“Монголчуудын ёс суртахуун–эрх зүйн хөгжлийг хангах үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагыг иж бүрэн тодорхойлох нь”* суурь судалгааны төслийг хэрэгжүүлсэн.

Суурь судалгааны төслийн хүрээнд боловсролын салбарын ёс суртахууны өнөөгийн байдал, ерөнхий боловсролын хичээлийн хөтөлбөрт ёс суртахууны мэдлэг олгох талаар хэрхэн туссан болон цаашид хэрхэн боловсронгуй болгох асуудлыг тандан судлах зорилгоор *“Ёс суртахууны боловсрол”* экспертийн төвшний 19 асуулт бүхий социологийн судалгааны анхдагч хэрэглэгдэхүүн болох экспертийн анкетийн санал асуулгыг боловсруулж, Улаанбаатар хот болон Дундговь, Говьсүмбэр, Увс, Ховд, Дорнод аймгийн ерөнхий боловсролын сургуулийн 110 багш нараас асуулгын аргаар мэдээлэл авч, судалгааны үр дүнд шинжилгээ хийж зөвлөмж боловсруулав.

Монголчуудын ёс суртахуун–эрх зүйн хөгжлийг хангах үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагыг иж бүрэн тодорхойлох талаар тулгамдсан асуудлыг хэлэлцэн тодорхойлох зорилгоор төслийн удирдагч, академич С.Нарангэрэл *“Ёс суртахууныг шинжлэх ухааны үүднээс авч үзвэл...”* сэдэвт эрдэм шинжилгээний семинарыг 2018 оны 6-р сарын 13-ны өдөр зохион байгуулж, төрийн болон төрийн бус сургалт, эрдэм шинжилгээний байгууллагын эрдэмтэн судлаачид хэлэлцүүлэгт үнэтэй санал бодлоо илэрхийлж, үр дүнтэй болсон.

Ёс суртахууны онолын багц асуудлууд болон Монголын хуульчдын ёс зүйн өнөөгийн байдалд дүгнэлт хийж, ёс зүйн зангилаа асуудлуудыг тодорхойлох зорилгоор МУИС-ын Хууль зүйн сургууль, ШУА-ийн Философийн хүрээлэн, Монголын Хуульчдын Холбоотой хамтран 2019 оны 4-р сарын 26-ны өдөр *“Монгол Улс дахь хуульчдын ёс зүйн тулгамдсан асуудал”* сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулж, 4 илтгэл хэлэлцүүлж, хурлын илтгэлийн эмхтгэлийг хэвлэн нийтлүүлж, олон нийтийн хүртээл болгов. Өнөөгийн нийгмийн ёс зүйн асуудалд дүн шинжилгээ хийх, тулгамдсан асуудлыг тодруулж, шударга ёс, ёс зүйг нийгэмд төлөвшүүлэх зорилгоор Удирдлагын Академи, Стратеги Академи, ШУА-ийн Философийн хүрээлэнтэй хамтран *“Өнөөгийн монголын нийгмийн улс төрийн хариуцлага, ёс зүйн зангилаа асуудлууд”* сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг 2018 оны 10-р сарын 16-ны өдөр зохион байгуулж, 9 илтгэл хэлэлцүүлж, зөвлөмж гаргаж, шинэ санаа дэвшүүлж, төрийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд онол-арга зүйн хийгээд практик ач холбогдолтой хэрэглэгдэхүүн болсон.

Боловсролын салбарын ёс суртахууны өнөөгийн байдал, ерөнхий боловсролын хичээлийн хөтөлбөрт ёс суртахууны мэдлэг олгох талаар хэрхэн туссан болон цаашид хэрхэн боловсронгуй болгох зорилгоор Улаанбаатар хотын Ерөнхий боловсролын сургуулиуд болон их, дээд сургууль, хувийн өмчийн сургуулийн багш, нийгмийн ажилтан нарыг оролцуулан *“Монголчуудын ёс суртахууны боловсрол”* эрдэм шинжилгээний хэлэлцүүлгийг 2019 оны 5-р сарын 24-ний өдөр зохион байгуулж, ёс суртахууны нэр томъёог тодорхойлж нэгдмэл ойлголттой болох, ёс суртахууны дархлаа, сэтгэлгээг төлөвшүүлэх, багш мэргэжилтнүүдийг бэлтгэх, сэтгэлгээний боловсролын тухай хуулийн төсөл боловсруулах, ёс зүйн хөтөлбөр боловсруулан баталж хэрэгжүүлэх шаардлагатай байгааг онцолж, цаашид анхаарах олон чухал асуудлыг хэлэлцэж, *“Ёс суртахууны боловсрол”* экспертийн төвшний судалгааны онол-арга зүйн болон практик ач холбогдолтой хэрэглэгдэхүүн болов.

Суурь судалгааны төслийн үр дүн болгож төслийн гүйцэтгэгчид Монголчуудын ёс суртахуун–эрх зүйн хөгжлийг хангах үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх

шаардлагыг иж бүрэн тодорхойлох чиглэлээр нэг сэдэвт бүтээл-9, эрдэм шинжилгээний өгүүлэл-10, илтгэл-19, эмхэтгэл-2, гарын авлага-1, судалгааны тайлан-1-ийг тус тус бичиж нийтлүүлж, олон нийтийн хүртээл болгож, эрдэм шинжилгээний эргэлтэд орууллаа.

Түлхүүр үг, гол ойлголтууд

Ёс суртахуун, ёс зүй, эрх зүй, үндэсний хөтөлбөр

ГАРЧГИЙН МЭДҮҮЛЭГ

Удиртгал	6
Нэг. Үндсэн хэсэг	7
❖ Суурь судалгааны төслийн зорилго	
❖ Төсөл хэрэгжүүлэх үндэслэл, хэрэгцээ шаардлага	
❖ Нийгмийн болон шинжлэх ухааны ач холбогдол	
❖ Суурь судалгааны төслийн хүрээнд хийгдсэн ажил, явцын үр дүн, үр дүнгээс гарах зарим дэвшилтэт тал	
Хоёр. Суурь судалгааны төслийн онол, арга зүйн үндсийн тухай.....	8
Гурав. Судалгааны үр дүнгийн агуулга	10
❖ Экспертийн судалгааны тайлан	
❖ Эрдэм шинжилгээний бага хурал	
❖ Эрдэм шинжилгээний хэлэлцүүлэг	
❖ Эрдэм шинжилгээний семинар	
❖ Эрх зүйн баримт бичгийн шинжилгээ	
❖ Суурь судалгааны төслийн үр дүнд гарсан гол бүтээлүүд	
Хавсралт	46

УДИРТГАЛ

ШУА-ийн Философийн хүрээлэнгээс 2017-2019 онд “*Монголчуудын ёс суртахуун–эрх зүйн хөгжлийг хангах үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагыг иж бүрэн тодорхойлох нь*” суурь судалгааны төслийг хэрэгжүүлсэн. Энэхүү суурь судалгааны төслийн гол зорилго нь Монгол Улсын иргэдийг шударга, нинжин сэтгэлтэй, ёс жудагтай, үнэнч, нэр төртэй, ажилч хичээнгүй зэрэг ёс суртахууны эрхэм чанартай болгон төлөвшүүлэх онол, арга зүйн үндсийг боловсруулж, практик амьдралд хэрэгжүүлэх иж бүрэн арга хэмжээнүүдийг төлөвлөхөд оршино.

Монголчуудын ёс суртахуун–эрх зүйн хөгжлийг хангах үндэсний хөтөлбөр одоогоор байхгүй бөгөөд энэ сэдвийн хүрээнд зарим асуудлыг нь хэсэгчлэн судалсан байна. Харин суурь судалгааны төслийн хүрээнд уг асуудлыг иж бүрнээр нь судалсан ажил өнөөг хүртэл хийгдээгүй байна. Тиймээс Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж, дагаж мөрдөж буй хууль тогтоомж болон төрийн болон төрийн бус байгууллагуудын ёс зүйн дүрэм, журамд агуулгын шинжилгээ хийж, ёс суртахууны хэм хэмжээг ямар байдлаар тусгасан болохыг олж тодруулах, ёс суртахуунтай болгох, ялангуяа хуульчдын ёс зүйг төлөвшүүлэх, нийгмийн амьдралыг ёс суртахуунтай хуулиар удирддаг болгох зэргээр монголын нийгмийн амьдралын бүхий л салбар хүрээг хамарсан иж бүрэн шинжилгээ хийнэ. Иймээс ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарын эрдэмтэн, судлаачид “*Монголчуудын ёс суртахуун–эрх зүйн хөгжлийг хангах үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагыг иж бүрэн тодорхойлох нь*” суурь судалгааны төслийг 2017-2019 оны хугацаанд хэрэгжүүлэн гүйцэтгэсэн.

2017-2019 оны хугацаанд хэрэгжүүлсэн уг суурь судалгааны төслийн удирдагчаар академич С.Нарангэрэл, гүйцэтгэгчээр доктор Д.Батмөнх, У.Батцэрэн, Т.Алтансувд, магистр Ц.Баянмөнх, М.Долгорсүрэн, Ё.Ундрал, П.Мягмарсайхан, Ц.Жаргал нар ажилласан болно. Магистр Т.Төмөрбаатар, Б.Лхагважаргал нар чөлөө авсан болно.

НЭГ. ҮНДСЭН ХЭСЭГ

Суурь судалгааны төслийн зорилго

Монгол Улсын иргэдийг шударга, нинжин сэтгэлтэй, ёс жудагтай, үнэнч, нэр төртэй, ажилч хичээнгүй зэрэг ёс суртахууны эрхэм чанартай болгон төлөвшүүлэх онол, арга зүйн үндсийг боловсруулж, практик амьдралд хэрэгжүүлэх иж бүрэн арга хэмжээнүүдийг төлөвлөхөд энэхүү төслийн үндсэн зорилго чиглэгдэнэ.

Төсөл хэрэгжүүлэх үндэслэл, хэрэгцээ шаардлага

Монголчуудын ёс суртахуун–эрх зүйн хөгжлийг хангах үндэсний хөтөлбөр одоогоор байхгүй бөгөөд энэ сэдвийн хүрээнд зарим асуудлыг нь хэсэгчлэн судалсан байна. Харин суурь судалгааны төслийн хүрээнд уг асуудлыг иж бүрнээр нь судалсан ажил өнөөг хүртэл хийгдээгүй байна. Тиймээс Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж, дагаж мөрдөж буй хууль тогтоомж болон төрийн болон төрийн бус байгууллагуудын ёс зүйн дүрэм, журамд агуулгын шинжилгээ хийж, ёс суртахууны хэм хэмжээг ямар байдлаар тусгасан болохыг олж тодруулах, ёс суртахуунтай болгох, ялангуяа хуульчдын ёс зүйг төлөвшүүлэх, нийгмийн амьдралыг ёс суртахуунтай хуулиар удирддаг болгох зэргээр монголын нийгмийн амьдралын бүхий л салбар хүрээг хамарсан иж бүрэн шинжилгээ хийнэ.

Нийгмийн болон шинжлэх ухааны ач холбогдол

- Монгол Улсад ёс суртахууны эрхэм чанартай бие хүн, хамт олныг төлөвшүүлэх шинжлэх ухааны үндсийг боловсруулж ингэснээрээ Ёс суртахуунд суурилсан хуулиудтай болох асуудал юм. Монголын нийгмийн цаашдын хөгжил дэвшлийг хангах иж бүрэн нөхцлийг бүрдүүлэх ач холбогдолтой.
- Монгол Улсын гэр бүл, боловсрол, төрийн болон өөрөө удирдах ёсны бүх шатны байгууллага, соёл, урлаг, хэвлэл мэдээлэл, шашин, аж ахуй нэгж зэрэг монголын нийгмийн бүхий л хүрээнд ашиглах боломжтой.

Суурь судалгааны төслийн хүрээнд хийгдсэн ажил, явцын үр дүн, үр дүнгээс гарах зарим дэвшилтэт тал

- Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж, дагаж мөрдөж буй хууль тогтоомжийг ёс суртахуунтай болгох, ялангуяа хуульчдын ёс зүйг төлөвшүүлэх, нийгмийн амьдралыг ёс суртахуунтай хуулиар удирддаг болгох асуудлыг иж бүрэн судлан тодорхойлж, төслийн үр дүнд Монгол Улсын Их хурлын “Монголчуудын ёс суртахуун эрх зүйн хөгжлийг хангах хөтөлбөр”-ийн төсөл боловсруулна. Энэхүү хөтөлбөрийн төслийг Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам, Хууль Зүйн Яам, Хүн Ам Нийгмийн Хамгааллын Яам улмаар Засгийн Газар, Улсын Их Хуралд өргөн барьж, хэлэлцүүлнэ.

ХОЁР. СУУРЬ СУДАЛГААНЫ ТӨСЛИЙН ОНОЛ, АРГА ЗҮЙН ҮНДСИЙН ТУХАЙ

Суурь судалгааны төслийн хүрээнд тодорхой эрх зүйн баримт бичигт анализ хийх замаар Монголчуудын ёс суртахуун–эрх зүйн хөгжлийг хангах үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагыг иж бүрэн тодорхойлох, түүнийг боловсронгуй болгох арга зам, шийдлийг эрэлхийлсэн.

Суурь судалгааны төслийн хүрээнд боловсролын салбарын ёс суртахууны өнөөгийн байдал, ерөнхий боловсролын хичээлийн хөтөлбөрт ёс суртахууны мэдлэг олгох талаар хэрхэн туссан болон цаашид хэрхэн боловсронгуй болгох асуудлыг тандан судлахаар зорьсон билээ.

Ёс суртахуун бол юуны өмнө хувь хүний хүмүүжил ба төлөвшлийн гол чиг ноён нурууг илэрхийлнэ. Ёс суртахуунгүй гэдэг нь хүмүүжилгүй гэсэн үг. Ёс суртахуун бол хүний мөн чанар бөгөөд ёс зүйн судлагдахуун юм. Ёс суртахуун бол хүнийг сайн, муу гэж хэмжих шалгуур болдог. Ёс суртахуун гэдэг нь хүний мөн чанарыг, хүнлэг ёс, ертөнцийн юмсад хандах хэм хэмжээ. Бусдад өөрийгөө танин мэдүүлэх, илэрхийлэх, бусдын эрх ашгийг хүндэтгэх нийтээр тогтоосон хэм хэмжээ. Тиймээс ёс суртахууны боловсрол Монголын өнөөгийн нийгэмд судлах нэн шаардлагатай тулгамдсан чухал асуудал болоод олон жил болсон. Түүний гол шалтгаан нь эдийн засгийн системд шилжих явцад хүмүүс хоорондын харилцааны шинж чанар өөрчлөгдөж өнөө үед сурагчид нийгмийн ямар хэм хэмжээг баримталж чадаж байгаа эсэхийг судлах шаардлагатай юм.

Ёс зүйн ухааныг дан ганц философичид өмчилж ярьдаг байсан бол өнөөдөр хуульчид, багш, сэтгүүлчид, эмч гээд мэргэжлийн бүх салбарынхны ярьдаг амин чухал асуудал болжээ. Учир нь ёс суртахууны хариуцлага хүлээхэд хөөн хэлэлцэх хугацаа огт үйлчилдэггүй, өндөр зан суртахуунтай иргэдийн хувьд тийм ойлголт ч байхгүй. Үр дагавар нь гэм буруутанд маш хатуу тусч, он удаан жил үргэлжилж, муу нэрийг хусч хаяхыг оролдовч салдаггүй. Ялангуяа жудгаа алдсан, ёс зүйгүй этгээдийн нэгэнт сэвтсэн нэр төр, алдар хүнд нь хэдэн үеийг дамждаг, сайн нэрийг хүсч тэмүүлэвч үл олдох, хуулиас хатуу дэг журамтай, хэнээс ч үл хамаарч хэнд ч үл захирагдах, тийм л ёс журам үйлчилдэгийг их дээдэст түгээх шаардлагатай байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ёс суртахууны төлөвшилд сөрөг нөлөө үзүүлж буй агуулгатай мэдээ, мэдээлэл, кино, дүрс бичлэг хяналтгүй гаргадаг бөгөөд сэтгэлийн гэгээрэл, хүн чанар, ариун ёс журмыг өгүүлсэн зүйл бага оруулах хандлага ажиглагдсан. Энэ нь нийгмийн сүлжээний буруу хэрэглээ болон эцэг, эхчүүд хүүхдүүддээ хяналт тавьдаггүйгээс шалтгаалж байгаа. Энэ нь иргэдэд зан суртахууны хэм хэмжээ, зарчмыг харилцаа, үйлдэлдээ хэвшүүлэх нийгмийн орчин үгүйлэгдэж байгааг илэрхийлж байгаа юм.

Экспертийн судалгааны хүрээнд ЕБС дахь ёс суртахууны боловсролын байдал, түүнд нөлөөлж буй нийгмийн хүчин зүйлсийг тоймлон гаргах, сайжруулах арга замыг судласан.

Дэвшүүлж буй судалгааны зорилт:

1. ЕБС-ийн багш нарын ёс суртахууны талаарх ойлголтыг боловсруулах
2. ЕБС-ийн ёс суртахууны боловсролд нөлөөлж буй нийгмийн хүчин зүйлсийг тоймлон гаргах

3. Ёс суртахууны доголдол, доройтлыг арилгах арга замын талаар экспертийн саналыг авах

Судалгааны арга зүй, аргачлал: Судалгааг тоон судалгааны арга зүйгээр хэрэгжүүлнэ. Анкет, баримт бичиг аргаар мэдээлэл цуглуулна.

Анкетын арга:

1. Асуулгын арга – Улаанбаатар хот болон орон нутгийн ЕБС-ийн 100 гаруй багшийг онлайнаар анкетын аргыг ашиглаж тоон мэдээлэл цуглуулна.
2. Статистик болон судалгааны тоон мэдээлэлд анализ шинжилгээ хийнэ.

Судалгааны аргачлал: Тоон судалгааны асуулгыг урьдчилан бэлтгэсэн асуулгын дагуу явуулж, мэдээллийг онлайнаар авах болно. SPSS багц программаар нэгтгэн, мэдээллийг харьцаа, дундаж бодох, хэв маягчлал үүсгэх, харьцуулах зэргээр анхдагч шинжилгээ хийсний үндсэн дээр судалгааны тайлан бичнэ.

Шинжлэх ухааны судалгаа бол танин мэдэхүйн чиглэсэн зорилготой үйл ажиллагаа бөгөөд түүний үр дүнд ойлголт, хууль, онолын мөн чанар цэгцтэйгээр тайлбарлагддаг. Шинжлэх ухааны арга зүйн хувьд танин мэдэхүйн диалектик арга, түүхчлэх, харьцуулах, системчлэх, үүрэгчлэх, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, индукц, дедукц, ажиглалт, баримт бичиг, харьцуулалт, социологийн зэрэг тодорхой аргуудыг цогц болгон ашигласан.

Судалгааг тоон судалгааны арга зүйгээр явуулж баримт бичиг, асуулгын аргаар мэдээлэл цуглуулж, судалгааны үр дүнд шинжилгээ хийж, зөвлөмж боловсруулав.

Бидний судалгааны ажил ихэнхдээ өөрийн улсын эрх зүйн тогтолцоо, туршлага, практикт тулгуурлаж хийгдсэнээс гадна глобальчлалын өнөөгийн нөхцөлд улс орны дотоод дахь зохицуулалтыг гадаад орнуудтай, зарим тохиолдолд гадаад орны зохицуулалтыг аль нэг улсынхтай харьцуулж судлах шаардлага хэрэгцээ өндөрт тавигдаж байсан. Үүнийг харьцуулсан судалгааны үр дүнд аль нэг улс дахь зохицуулалтыг өөрчилж шинэчлэх, улс оронд ашиг тустай тогтолцоог нэвтрүүлэхийн ач холбогдлыг анхаарч үзсэн болно.

ГУРАВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН АГУУЛГА

Суурь судалгааны төслийн хүрээнд экспертийн судалгааны тайлан, нэг сэдэвт бүтээл, эмхэтгэл, гарын авлага, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл, санал, зөвлөмж, эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг, семинарын материал үр дүн болж гарсан.

Судалгааны тайлан

“Ёс суртахууны боловсрол” экспертийн судалгааны тайлан. УБ.,2019

Суурь судалгааны төслийн хүрээнд боловсролын салбарын ёс суртахууны өнөөгийн байдал, ерөнхий боловсролын хичээлийн хөтөлбөрт ёс суртахууны мэдлэг олгох талаар хэрхэн туссан болон цаашид хэрхэн боловсронгуй болгох, хүүхэд хүн болж төлөвших, тэдний ёс суртахуун, үнэт зүйл, эрхэм чанар бүрэлдэн тогтоход ямар хүчин зүйлс түлхүү нөлөөлж байгаа болон сурагчдад ёс суртахууны боловсролыг танхимаар олгохдоо ямар аргаар, хэрхэн олговол зохистой эсэх, ном, сурах бичгийн агуулга ямар түвшинд байгаа, ямар байвал зохих зэрэг асуудлыг тодруулах зорилгоор **“Ёс суртахууны боловсрол”** экспертийн судалгааг улсын болон хувийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн 110 багш, сурган хүмүүжүүлэгч нараас түүврийн дагуу тоон судалгааны мэдээллийг 5 судлаачийн бүрэлдэхүүнтэй зохион байгуулж, асуулгын аргаар мэдээлэл авч, асуулгын нэгдсэн тоон үр дүнд үндэслэж, шинж чанараас хамааран тархалтаар нь харьцуулсан шинжилгээ, урвуу болон шууд хамаарлын шинжилгээ, 2 болон 3 хүчин зүйлийн харьцуулсан шинжилгээ, график шинжилгээ зэргийг хийж үр дүнд анализ хийж, зөвлөмж боловсруулсан.

Судалгааг тоон судалгааны арга зүйгээр явуулж баримт бичиг, асуулгын аргаар мэдээлэл цуглуулав. Судалгааны стандартыг тодорхойлох, мэдээлэл цуглуулах, боловсруулах үйл ажиллагааг дараах үе шатаар хэрэгжүүлсэн болно. Үүнд:

Баримт бичиг, цуглуулах үе шат – Судлагдсан байдал, хэрэгцээ шаардлагыг тодруулах зорилгоор судалгаанд шаардлагатай хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг, тоон мэдээлэл, урьд өмнө хийгдэж байсан судалгааны үр дүн, тайлан, мэдээлэлтэй танилцав.

Бэлтгэл үе шат–Судалгааны арга, аргачлал, стандартыг тодорхойлж, судалгааны үндсэн хэрэглэгдэхүүнийг боловсруулав.

Туршлагажилтын үе шат– Судалгааны багийн гишүүдэд судалгааны талаарх мэдээлэл, зааварчилгаа өгөв.

Мэдээлэл цуглуулах үе шат – Багийн гишүүд асуулгын аргаар мэдээлэл цуглуулав.

Боловсруулж, бэлтгэх үе шат–Судалгааны мэдээллийг аргачлалын дагуу боловсруулав.

Үр дүнг тооцох үе шат– Судалгааны үр дүнг тооцож нэгдсэн тайлан бичив.

Үр дүнг танилцуулах үе шат–Судалгааны үр дүнд тулгуурлан зөвлөмж боловсруулсан.

“Ёс суртахууны боловсрол” экспертийн судалгаа хийж, баримт бичгийн судалгааны аргаар *Монголчуудын ёс суртахуун–эрх зүйн хөгжлийг хангах үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагыг иж бүрэн тодорхойлох талаар* онолын үзэл баримтлал, судалгааны баримт бичиг, эрх зүйн акт, ном зохиол, бусад эх сурвалжид дүн шинжилгээ хийв.

Экспертийн судалгааг улсын болон хувийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн 110 багш нараас асуулгын аргаар мэдээлэл авч, харьцуулалт хийж нэгтгэн дүгнэж судалгааны хуримтлагдсан мэдээлэлд анализ хийн судалгааны тайлан бичиж, зөвлөмж боловсруулсан болно. Судалгааны тайлан нь:

- Судалгааны арга зүй
- Судалгааны тайлан
- Дүгнэлт, зөвлөмж гэсэн гурван бүлэгтэй.

Нэгдүгээр бүлэгт судалгааны зорилго, зорилт, объект, зохион байгуулалт, арга зүй, аргачлал зэргийг тусгасан.

Хоёрдугаар бүлэгт цуглуулсан мэдээлэл болон *Монголчуудын ёс суртахуун–эрх зүйн хөгжлийг хангах үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагыг иж бүрэн тодорхойлох талаар* онолын үзэл баримтлал, судалгааны баримт бичиг, эрх зүйн акт, ном зохиол, бусад эх сурвалжийг нэгтгэн, харьцуулалт, дүн шинжилгээ хийв.

Гуравдугаар бүлэгт судалгааны мэдээллийг нэгтгэн дүгнэж дүгнэлт бичив.

Судалгаанд оролцсон шинжээчид дээрх асуудалтай холбогдуулан дараах зүйлүүдийг боловсронгуй болгох, сайжруулах шаардлага байна гэж үзсэн.

Шинжээчдийн илэрхийлсэн саналыг дүгнэн үзэхэд Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад ёс суртахууны боловсрол, төлөвшлийг ямар байдлаар олгох нь үр дүнтэй гэж бодож байна вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 57.1 хувь нь эцэг, эхчүүд хүүхдэд ёс суртахууны үлгэр дууриалал болох гэж хариулсан байхад, сурагчид хэнийг илүүтэй үлгэр дуурайл болгодог вэ? гэсэн асуултад судалгаанд хамрагсдын 66.4 хувь нь эцэг, эх гэсэн хариултыг сонгосон байна.

Сурагчдад ёс суртахууны боловсрол, мэдлэг олгоход тусгайлсан сурах бичиг ашиглах шаардлага бий юу? гэсэн асуултад судалгаанд хамрагсдын 53 хувь нь маш их шаардлагатай тусгайлсан сурах бичиг хэрэгтэй байна гэсэн хариултыг сонгосон байна. Судалгаанаас харахад Ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд, ахлах анги тус бүрт ёс зүйн боловсрол, мэдлэг олгох тусгайлсан сурах бичиг ашиглах нэн шаардлагатай байна.

Ёс суртахууны чиглэлээр Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрт ашиглагдаж буй сурах бичгийн агуулгыг үнэлнэ үү? гэсэн асуултад судалгаанд хамрагсдын 19.3 хувь нь дунд зэрэг гэж үнэлсэн байна. Судалгааны дүнгээс харахад Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрт ёс суртахууны чиглэлээр ашиглагдаж байгаа сурах бичгийн агуулгыг анги тус бүрээр нь баяжуулж, төрөлжүүлэн сайжруулах хэрэгтэй байна.

Эрдэм шинжилгээний бага хурал

Суурь судалгааны төслийн хүрээнд ёс суртахууны онолын багц асуудлууд болон Монголын хуульчдын ёс зүйн өнөөгийн байдалд дүгнэлт хийж, ёс зүйн зангилаа асуудлуудыг тодорхойлох зорилгоор МУИС-ын Хууль зүйн сургууль, Монголын Хуульчдын Холбоотой хамтран 2019 оны 4-р сарын 26-ны өдөр “*Монгол Улс дахь хуульчдын ёс зүйн тулгамдсан асуудал*” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулж, 4 илтгэл хэлэлцүүлж, хурлын илтгэлийн эмхэтгэлийг хэвлэн нийтлүүлж, олон нийтийн хүртээл болгож, онол-арга зүйн болон практик ач холбогдолтой хэрэглэгдэхүүн болсон.

Эрдэм шинжилгээний хурлаар хэлэлцүүлсэн илтгэлийн агуулга, санал, дүгнэлтийг товч дурдвал,

- ❖ Ёс суртахууны онолын багц асуудлууд
- ❖ Ёс суртахуун хуулийн амин сүнс болохын учир
- ❖ Хуульчдын мэргэжлийн ёс зүйн агуулга
- ❖ Монголын хуульчдын ёс зүйн өнөөгийн байдалд хийх дүгнэлт
- ❖ Монголын хуульчдын ёс зүйн зангилаа асуудлууд
- ❖ Хуульчдын ёс зүйн дагаж мөрдөж буй хэм хэмжээнд хийсэн шинжилгээ
- ❖ Хуульчдын ёс зүйн хэм хэмжээг төгөлдөржүүлэх үндсэн асуудал

Тус эрдэм шинжилгээний хуралд төслийн удирдагч, академич С.Нарангэрэл *Монголын хуульчид ёс зүйгээ сахидаг юм уу?*” (Онол-практикийн зангилаа асуудал), төслийн багийн гишүүн, доктор /Ph.D/ Д.Батмөнх “*Монголын хуульчдын ёс зүйн талаархи олон нийтийн үнэлэмж*” илтгэл тус тус хэлэлцүүлэв.

Эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэлийн санал, дүгнэлтээс багцалж авч үзэхэд хуульчийн ёс зүй нь олон шинжлэх ухааны (*философи, квантын физик, тархи судлал, генетик, сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх зүй, түүх, шашин судлал, хууль зүй судлал, ардын аман зохиол зэрэг*) уулзварт судлагддаг ёс суртахуун судлалын ухаан болохыг энэ хурлын үр дүн баттай харууллаа. Дагаж мөрдөж буй хуульчийн ёс зүйн дүрмийг эрс шинэчлэх шаардлага үүдсэнийг мөн нотлов. Монголын хуульчдын мэргэжлийн нэр хүнд ямар байх нь тэдний ёс зүйгээс шууд шалтгаална гэсэн дүгнэлтийг хурлын үр дүн гаргав. Энэхүү эрдэм шинжилгээний хуралдаан монголын хуульчдын ёс зүйд эрс шинэчлэлт хийх явдал зайлшгүй чухал болохыг харууллаа.

Эрдэм шинжилгээний хурлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчилан таниулж, илтгэлийн эмхэтгэлийг хэвлэн нийтлүүлж, олон нийтийн хүртээл болгосон.

Эрдэм шинжилгээний бага хурлаас гаргасан санал, зөвлөмж

- ❖ Хуульчдад ёс суртахууны боловсрол олгох
- ❖ Монголын хуульчдын ёс зүйн хөтөлбөр боловсруулан баталж хэрэгжүүлэх
- ❖ Ёс суртахууны боловсролын нэгдсэн төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх
- ❖ Хуульчдын ёс суртахууны боловсролыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр баталж хэрэгжүүлэх
- ❖ Монголын хуульчдын ёс суртахуун, ёс зүйн талаар эрс шинэчлэлт хийх
- ❖ Монголын хуульчдын ёс зүйн нандин өв нь XIII зууны үеэс бий болж, өнөөг хүртэл уламжлагдан хөгжүүлэх
- ❖ Монголын хуульчдын ёс зүйн нандин өв, үнэт зүйлийг хууль дээдлэх ёс, үнэнч шударга ёс, ард түмний эрх ашгийг хамгаалан нэг ч хүнийг хилсдүүлэхгүй байх

- явдал буюу хүний эрхийг дээдлэх явдал хэмээн үзэж болох ба энэхүү үнэт зүйл нь эрх зүйн үнэт зүйлтэй уялдуулах
- ❖ Хуульчдын ёс зүйн үнэт зүйл нь эрх зүйн үнэт зүйлтэй салшгүй холбоотой болохын хувьд орчин үед хуульчдын ёс зүйн үнэт зүйлийг хуульчдын үйл ажиллагаагаар илрэх, хэрэг, маргааныг шийдвэрлэх арга хэрэгсэл хэмээн үзэх болсоныг эрх зүйн ухамсарын хүрээнд төлөвшүүлэх
 - ❖ Хүний эрх, эрх чөлөөг хангах, хууль дээдлэх, шударга ёсны зарчмууд нь орчин үеийн хуульчдын ёс зүйн үнэт зүйлийн ойлголтын хүрээнд хуульчдын өдөр тутмын үйл ажиллагаагаар илрэх, хэрэг, маргааныг шийдвэрлэх арга хэрэгсэл болохыг хуульчдийн үйл ажиллагаанд хэвшүүлсэнээр хүний эрх, эрх чөлөөг хамгаалах механизм бүрдүүлэх
 - ❖ Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа, шийдвэр нь шударга ёсны илэрхийлэл мөн гэдгийг итгүүлэн үнэмшүүлэх аргументыг олох чадварыг хуульчдад эзэмшүүлэх
 - ❖ Хуульчдийн ёс зүйн болон мэргэжлийн хариуцлагыг өндөржүүлж, хариуцлага хүлээх эрх зүйн орчинг сайжруулж, амьдралд бодитой хэрэгжүүлэх
 - ❖ Нийгмийн ёс суртахуун бие даасан институци болж чадвал улс төр, эдийн засаг, хууль эрх зүйн олон талын сөрөг нөлөөлөлд үл автан дархлаатай болж өнөөгийн хүмүүсийн зан үйлдлийн олон зөрчлийг ёс суртахууны хүрээнд зохицуулах
 - ❖ Ёс зүйн сургалт, сургалт судалгааны ажлын хүрээг өргөжүүлж эрчимжүүлэх
 - ❖ Бүх нийтийн ёс зүйн боловсрол өсч, ёс суртахууны хорио цээр, зөвшөөрсөн хэм хэмжээний нийгмийн учир холбогдлын мөн чанарыг олон нийт ухааран ойлгуулах
 - ❖ Ёс суртахуунтай амьдрах итгэл үнэмшилтэй болгох
 - ❖ Ёс зүйн олон ургальч философийн сургалт, судалгаа эрчимтэй явуулж, сурталчилах, өнөөгийн монгол хүний зан үйлдлийн олон хувилбарт үзэгдлүүдийг тал бүрээс нь тайлбарлаж олон нийтийн хүртээл болгох
 - ❖ Сургалт сурталчилгаа, судалгааны үр дүнд нийгмийн ёс суртахуун институцчлэгдэх үйл явцыг эрчимжүүлэх
 - ❖ Монгол хүний ахуй амьдралын хэв ёс болон тогтсон хөөрөг зөрүүлэн мэндлэх, гал голомт эрхэмлэх, үүдэн хоймор шүтэх, өрх, нохой эрхэмлэх зэрэг шүтлэг, зан үйлийн том нэгж, хэлбэр болон тогтоох
 - ❖ Монгол хүний ертөнцийг үзэх язгуур үзэл сэтгэлгээний нэгэн том ай, ёс суртахууны чухал хэмжүүр болгох
 - ❖ Хуульч болоод гүн ухаантан бол бурхантай адил гэдэг санаа нь философийн амин сүнс нь ёс зүй дээр тулгуурлаж байдагтай шууд холбоотой билээ. Ямарч мэргэжлийн албан хаагч эхлээд хүн төрхөө олох, хүн болох, хүн байх, хүн ёсийг эзэмших шаардлага тавигддаг. Энэ бол А үсэг бөгөөд А үсэгээ мэдэхгүйгээр Б-ийн тухай ярьсанаас хамаг алдаа, завхрал гарч байна. Хуульчид маань хүн төрөлхтний хийгээд монголчуудын ёс суртахууны үнэт зүйлсийг хир мэддэг, түүнийг ажил, амьдралдаа хэрхэн баримталж, хэрэгжүүлдэг, хүнтэй харьцахдаа яах ёстой, бие хэрхэн авч явах, хэлэх хэлэхгүй үг, хэл яриа, үйл ажиллагаагаа байнга хянаж, алдаа гаргахгүй, хохирол гаргахгүй, хариуцлагатай байж, иргэн хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад бүхий л амь амьдралаа зориулах эрхэм үүрэгтэй, шилдэг иргэд билээ.
 - ❖ Хамгийн өндөр соёл, ёс суртахуун, зан суртахуун, төлөвшил, хандлага, харилцааг эзэмшсэн хүн хуульч байх ёстой билээ. Ийм болохын тулд би хэн бэ? гэдэг дээр манай

хуульчид өөртөө дүгнэлт өгч, бусдын шүүмжлэлийг найрсагаар хүлээн авч, цаг тухайд засаж, алдаа нь дээрээ суралцаж, хөгжих нийгмийн шаардлага буй болжээ. Энэ нь хуульч мэргэжлийн нэр хүндийг өндөрт өргөж явах, тэрхүү мэргэжлээр иргэд бахархах, тийм мэргэжилтэй болохыг залуус хүсэн тэмүүлдэг болтол нь уг салбарынхан үлгэр жишээчээр ажиллах хэрэгтэй. Энд хүн ганцхан харилцаа нь дээрээ алддаг гэдгийг манай хуульчид мэдэрч ажиллах нь чухал байна. Логикгүй сэтгэнэ гэдэг нь ёс суртахуунгүй асуудал болно гэдгийг бас анхаарах нь зүйтэй.

- ❖ Орчин үеийн дараах нийгэм бол үйлчилгээний технологитой нийгэм болсон тул хуульчид иргэдэд үйлчилэхэд ёс суртахууны онолын мэдлэг, практик мэдрэмж, харилцаа хандлагаа шинэчлэх нийгмийн шинэ хэрэгцээ шаардлага тавигдаж байна. Манай хуульчид ёс суртахууны философи, эрхийн философийн үзэл баримтлалууд, түүний ёс зүйн агууламж юунд оршиж буйг нээх суурь судалгааны төсөлт ажил боловсруулж, ёс суртахууны философи-эрхийн философийн зааг дээрх судалгааны шинэ талбарыг нээж, энэхүү эрдэм судлалын ажилд хөрөнгө оруулалтыг бодлогоор хийж, үр дүнг нь тайлагнах нь зүйтэй гэж үзлээ.
- ❖ Мэргэжлийн хэм хэмжээ гэж юу вэ? гэдгийг ойлгох нь чухал бөгөөд Аристотель яагаад “*Бүх юм хэм хэмжээтэй*” гэж үзэж байсаны логикийг манай хуульчид нээх шаардлагатай байна.
- ❖ Бид зөвхөн хууль гэж явцуурахгүйгээр эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийж, дээр дурдсан салбаруудын ёс зүйн нэгдмэл шаардлага, мэргэжлийн ёс зүйн ойлголт, зарчим хэм хэмжээ, зан суртахуун, үнэт зүйлийг хамтын хүчээр тодорхойлж, практик дээр тулгуурласан онол боловсруулах шаардлагатай байна. Ингэхдээ түүхэн болон түүхэн бус ард түмнүүдийн хууль сахиулах байгууллагуудын эрх зүйн орчинг судалж, харьцуулан шинжлэх нь илүү үр өгөөжтэй байх нь магад.
- ❖ Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, журмын шинэчлэлт хийхдээ ёс зүйн хэм хэмжээг нарийвчлан тусгах, хяналтын хэлбэрүүдийг өргөжүүлэх, боловсронгуй болгох
- ❖ Хуульчийн үйлчилгээний соёлын чухал нэг хэсэг бол хуульч хүн хүнлэг, энэрэнгүй, нигүүлсэнгүй, нинжин сэтгэл гаргаж үйлчлүүлэгтэйгээ харилцах эрхэм чанарыг төлөвшүүлэх
- ❖ Хууль, эрх зүйн салбарт хуульчийн үнэт зүйл болох хуульчийн үйлчилгээний соёлыг нэвтрүүлж ажиллах
- ❖ Хуульчийн үйлчилгээний соёлын стандартыг бий болгож, мөрдүүлж, нэвтрүүлэн ажиллах
- ❖ Хуульчийн орчин үеийн шинэ үнэт зүйлийг гаргах
- ❖ Мэдээллийн үнэт зүйлийг төлөвшүүлэх
- ❖ Үйлчилгээний нийгэм болон програмчлагдсан нийгмийг төлөвшүүлэх

Суурь судалгааны төслийн хүрээнд өнөөгийн нийгмийн ёс зүйн асуудалд дүн шинжилгээ хийх, тулгамдсан асуудлыг тодруулж, шударга ёс, ёс зүйг нийгэмд төлөвшүүлэх зорилгоор Удирдлагын Академи, Стратеги Академи, ШУА-ийн Философийн хүрээлэнтэй хамтран “**Өнөөгийн монголын нийгмийн улс төрийн хариуцлага, ёс зүйн зангилаа асуудлууд**” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг 2018 оны 10-р сарын 16-ны өдөр зохион байгуулж, 9 илтгэл хэлэлцүүлж, зөвлөмж гаргаж, шинэ санаа дэвшүүлж, төрийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд онол-арга зүйн хийгээд практик ач холбогдолтой хэрэглэгдэхүүн болов.

Хуралд хэлэлцүүлсэн илтгэлүүдийг нэгтгэн авч үзэхэд:

- ❖ Хувь хүний ёс зүйн хариуцлага
- ❖ “Монголчуудын ёс суртахуун” үндэсний хөтөлбөрийн шинжлэх ухааны үндэслэгээ
- ❖ Шударга ёсыг төлөвшүүлэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн гүйцэтгэх үүрэг, ач холбогдол
- ❖ Төрийн албан хаагчийн баримтлах хууль дээдлэх зарчим, түүний ёс зүйн төлөвшилд нөлөөлөх нь
- ❖ Ёс зүйн зохицуулалтад тавих хяналтыг боловсронгуй болгох арга зам
- ❖ Ёс зүйн хэм хэмжээ ба олон нийтийн санаа бодол
- ❖ Улс төрийн соёлд намын гишүүдийн гүйцэтгэх үүрэг
- ❖ Ёс зүйн хариуцлагын асуудалд улс төрийн намын санхүүжилт холбогдох нь
- ❖ Өнөөгийн монголын нийгмийн ёс суртахууны төлөв байдал, түүнийг сайжруулах арга замын асуудалд

Хурлаар хэлэлцүүлсэн илтгэлийн санал, дүгнэлтээс тоймлон авч үзэхэд монголын нийгмийн улс төрийн харилцаа, төрийн албаны тогтолцоог бүхэлд нь эрүүлжүүлэх, эрин цагийн шаардлагад нийцсэн шинэ дэг журмыг тогтооход чиглэсэн улс төрийн болон төрийн албаны хариуцлага, ёс зүйн цогц бодлогыг боловсруулан үе шаттай хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Монголчуудын эртнээс уламжилж ирсэн шударга ёс, ичих нүүр, жудаг, нинжин сэтгэл, нэр төр, ах захаа хүндлэх ёсон, эелдэг, зочломтгой нийтэч зан, тэсвэр тэвчээр, ам, ажил нь зөрдөггүй чанар зэргийг багтаасан “*Би монгол хүн*” хэмээх бахархлыг сэргээхэд чиглэсэн “*Монголчуудын ёс суртахуун*” үндэсний хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Ёс суртахууныг хамгаалж бэхжүүлэхэд чиглэсэн эрх зүйн шинэчлэлийг цаг алдалгүй дэс дараатай зохион байгуулах, энэ хүрээнд ажиллаж амьдрах соёлыг төлөвшүүлж, хэвших нэн шаардлагатай байна гэж үзсэн байна.

Эрдэм шинжилгээний хурлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчилан таниулж, илтгэлийн эхтгэлийг хэвлэн нийтлүүлж, олон нийтийн хүртээл болгосон.

Эрдэм шинжилгээний бага хурлаас гаргасан зөвлөмж

“Өнөөгийн Монголын нийгмийн улс төрийн хариуцлага, ёс зүйн зангилаа асуудлууд” сэдэвт эрдэм шинжилгээний бага хуралд хэлэлцүүлсэн илтгэлүүд, хуралд оролцож үг хэлсэн эрдэмтэн, судлаачид, төр засгийн ажилтанууд, нам, иргэний нийгмийн төлөөллийн дэвшүүлсэн санааг үндэс болгон тус бага хуралд оролцогсад энэхүү зөвлөмжийг санал нэгдэж сайшаан дэмжив.

Монголын нийгэм өөдрөг үзэл санаанд тулгуурлаж, ёс зүйн соёлыг нийгэмд төлөвшүүлж, өөрийгөө ариусгаснаар ёс зүйн доройтлыг арилгаж, учирсан бэрхшээлийг амжилттай даван туулж чадах тул хуралд оролцогсад:

Өндөр соёлтой, ёс суртахууны хариуцлага сайтай нийгмийг цогцлоохын үүднээс төр, засгийн удирдах байгууллагууд, улс төрийн бүх хүчнүүд, төрийн бус байгууллагууд, сонирхсон хувь хүмүүс дараах зорилтуудыг ойрын үед хэрэгжүүлэхийн төлөө хамтран ажиллахыг зөвлөн уриалж байна.

1. Монголын нийгмийн улс төрийн харилцаа, төрийн албаны тогтолцоог бүхэлд нь эрүүлжүүлэх, эрин цагийн шаардлагад нийцсэн шинэ дэг журмыг тогтооход чиглэсэн улс төрийн болон төрийн албаны хариуцлага, ёс зүйн цогц бодлогыг боловсруулан үе шаттай хэрэгжүүлэх
2. Монголчуудын эртнээс уламжилж ирсэн шударга ёс, ичих нүүр, жудаг, нинжин сэтгэл, нэр төр, ах захаа хүндлэх ёсон, эелдэг зочломтгой, нийтэч зан, тэсвэр тэвчээр, ам, ажил нь зөрдөггүй чанар зэргийг багтаасан “*Би Монгол хүн*” хэмээх бахархалыг сэргээхэд чиглэсэн “*Монголчуудын ёс суртахуун*” үндэсний хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх
3. Ёс суртахууныг хамгаалж бэхжүүлэхэд чиглэсэн эрх зүйн шинэчлэлийг цаг алдалгүй дэс дараатай зохион байгуулах, энэ хүрээнд ажиллаж амьдрах соёлыг төлөвшүүлж хэвших

Боловсролын салбарын ёс суртахууны өнөөгийн байдал, ерөнхий боловсролын хичээлийн хөтөлбөрт ёс суртахууны мэдлэг олгох талаар хэрхэн туссан болон цаашид хэрхэн боловсронгуй болгох зорилгоор Улаанбаатар хотын Ерөнхий боловсролын сургуулиуд болон их, дээд сургууль, хувийн өмчийн сургуулийн багш, нийгмийн ажилтан нарыг оролцуулан *“Монголчуудын ёс суртахууны боловсрол”* эрдэм шинжилгээний хэлэлцүүлгийг 2019 оны 5-р сарын 24-ний өдөр зохион байгуулж, ёс суртахууны нэр томъёог тодорхойлж нэгдмэл ойлголттой болох, ёс суртахууны дархлаа, сэтгэлгээг төлөвшүүлэх, багш мэргэжилтнүүдийг бэлтгэх, сэтгэлгээний боловсролын тухай хуулийн төсөл боловсруулах, ёс зүйн хөтөлбөр боловсруулан баталж хэрэгжүүлэх шаардлагатай байгааг онцолж, цаашид анхаарах олон чухал асуудлыг хэлэлцэж, *“Ёс суртахууны боловсрол”* экспертийн төвшний судалгааны онол-арга зүйн болон практик ач холбогдолтой хэрэглэгдэхүүн болов.

Төслийн удирдагч, академич, МУИС-ийн Эмерит профессор С.Нарангэрэл *“Монголчуудад ёс суртахууны боловсрол олгох зарим асуудал”* эрдэм шинжилгээний үндсэн илтгэл тавьж хэлэлцүүлэг өрнүүлэв. Академич С.Нарангэрэл илтгэлдээ *“ерөнхий боловсролын ёс суртахууны сургалт нэгдүгээр ангиас XII анги хүртэл тасралтгүй явагдах учиртай. I-IV ангид “Ёс суртахууны цагаан толгой” гэсэн хичээл заавал орж, сурах бичиг нь монгол ардын ёс суртахууны холбогдол бүхий зүйр, цэцэн үг, үлгэр туульс, домог, хялбаршуулсан бэсрэг өгүүлэл зэргээс бүрдэж, шаардлагатай заримыг нь цээжлүүлж, утга агуулгыг ойлгуулах ёстой. V-IX ангид “Ёс суртахууны өгөгдөл” гэсэн хичээл заавал орж, сурагчдад шударга, эр зориг, ичгүүр, жсудаг, үүрэг ба хариуцлага, нинжин сэтгэл, нэр төр, үнэн, итгэл, тэсвэр, тэвчээр, хайр хүндлэл, эе эв, эс шуналдах, эс атаархах, эелдэг найрсаг зочломтгой ёс, ах захаа хүндлэх, эс урван тэрслэх зэрэг ёс суртахууны өгөгдлийг ой тойнд нь шингээх шаардлагатай. Сурах бичиг нь хичээлийн нэртэйгээ адилхан байна. X-XII ангид “Ёс зүйн үндэс” гэсэн хичээл заавал оруулж, багш сурган хүмүүжүүлэгчийн, эмчийн, хуульчийн, төрийн албан хаагчийн, инжнэнерийн, эрдэм шинжилгээний ажилтны, сэтгүүлчийн, бизнесмены, үйлчилгээний ажилтны, лам санваартны, цэргийн албан хаагчийн зэрэг ажил мэргэжлийн ёс зүйн наад захын шаардлагыг ойлгуулж чадах болно. Ийм л нөхцөлд ёс суртахуунлаг иргэн төлөвших гэгээрлийг буй болгож чадна”* гэдгийг онцоллоо.

Ёс суртахууны хичээл, ёс суртахууны боловсрол өнөөгийн нийгэмд нэн шаардлагатай тулгамдсан чухал асуудал гэдгийг хэлэлцүүлэгт оролцогчид онцолж байв. Ёс зүйн ухааныг дан ганц философичид өмчилж ярьдаг байсан бол өнөөдөр хуульчид, багш, сэтгүүлчид, эмч гээд мэргэжлийн бүх салбарынханы ярьдаг амин чухал асуудал болжээ. Учир нь ёс суртахууны хариуцлага хүлээхэд хөөн хэлэлцэх хугацаа огт үйлчилдэггүй, өндөр зан суртахуунтай иргэдийн хувьд тийм ойлголт ч байхгүй. Үр дагавар нь гэм буруутанд маш хатуу тусч, он удаан жил үргэлжилж, муу нэрийг хусч хаяхыг оролдовч салдаггүй. Ялангуяа зудгаа алдсан, ёс зүйгүй этгээдийн нэгэнт сэвтсэн нэр төр, алдар хүнд нь хэдэн үеийг дамждаг, сайн нэрийг хүсч тэмүүлэвч үл олдох, хуулиас хатуу дэг журамтай, хэнээс ч үл хамаарч хэнд ч үл захирагдах, тийм л ёс журам үйлчилдэгийг их дээдэст түгээх шаардлагатай байна. Монгол төрийн хууль нь ёс суртахууныг хамгаалж баталгаажуулахад чиглэгдэж ирсэн. Гадаадын зарим улс оронд зан суртахууныг хуулиар зохицуулдаг.

Хэлэлцүүлгээр Монголчуудын хувьд Ерөнхий сайдаар ахлуулсан ёс суртахууны үндэсний зөвлөл байгуулж ажиллах шаардлага байгааг онцлон анхаарч олон талаас нь бодож тунгаах цаг иржээ. Ёс зүйн хөтөлбөр боловсруулан баталж хэрэгжүүлэх шаардлагатай. Энэхүү хөтөлбөрт бидний үзэж байгаагаар ёс суртахууны боловсролын

зорилт, (агуулга, тогтолцоо, удирдлага, зохион байгуулалт, боловсролын харилцаанд оролцогчдын эрх ба үүрэг, хариуцлагыг тодорхойлох), нэр томъёо, (“ёс суртахууны боловсрол”, “ёс суртахуун”, “ёс зүй”, “зан суртахуун”, “ёс суртахууны өгөгдөл”, “ёс суртахууны чадвар” зэрэг нэр томъёог тайлбарлах) ёс суртахууны боловсролын талаар БСШУСЯ-ны хүлээх үүргийг тодорхойлох ёстой. Хөтөлбөрт ёс суртахууны боловсролын нэгдсэн төлөвлөгөөний тухай заах бөгөөд ёс суртахууны боловсролыг хүртээмжтэй болгохын тулд ёс суртахууны боловсролын ерөнхий төлөвлөгөөг (Цаашид “Ерөнхий төлөвлөгөө” гэнэ) ёс суртахууны боловсролын зөвлөлийн хэлэлцүүлгийн үндсэн дээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын асуудал хариуцсан засгийн газрын гишүүний тушаалаар батлах бөгөөд дөрвөн жил тутамд шинэчлэнэ.

Ерөнхий төлөвлөгөөнд дараахь асуудлыг тусгана:

- ❖ ёс суртахууны боловсролын зорилго;
- ❖ ёс суртахууны боловсролын агуулга;
- ❖ ёс боловсролын зөвлөл байгуулж ажиллуулах;
- ❖ ёс зүйн нийтлэг дүрмийг боловсруулах;
- ❖ ёс зүйн хичээлийн жишиг дүрмийг боловсруулах;
- ❖ ёс суртахууны боловсролын сургагч багшийг бэлтгэх;
- ❖ ёс суртахууны асуудлаар судалгаа шинжилгээний ажил хийх;
- ❖ ёс суртахууны асуудлаар онол, практикийн хурал, хэлэлцүүлэг зохион байгуулах;
- ❖ ёс суртахууны боловсролын санхүүжилт, менежемент;

Байгууллагууд жил бүр ёс суртахууны боловсролыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө жил бүр боловсруулан баталж ажиллана.

Хэлэлцүүлэгт оролцсон багш, эрдэмтэн, судлаачид ёс суртахууны нэр томъёог тодорхойлж нэгдмэл ойлголттой болох, ёс суртахууны дархлаа, сэтгэлгээг төлөвшүүлэх, багш мэргэжилтнүүдийг бэлтгэх, сэтгэлгээний боловсролын тухай хуулийн төсөл боловсруулах шаардлагатай байгааг онцолж, цаашид анхаарах олон чухал асуудлыг хөндөн санал бодлоо солилцов. Эцэст нь тэмдэглэхэд ёс суртахуун, ёс зүйн талаар эрс шинэчлэлт хийх цаг болсон гэдгийг онцолж байв.

Эрдэм шинжилгээний хэлэлцүүлгээс гарсан зөвлөмж

- I-IV ангид “*Ёс суртахууны цагаан толгой*” гэсэн хичээл заавал орж, сурах бичиг нь монгол ардын ёс суртахууны холбогдол бүхий зүйр, цэцэн үг, үлгэр туульс, домог, хялбаршуулсан бэсрэг өгүүлэл зэргээс бүрдэж, шаардлагатай заримыг нь цээжлүүлж, утга агуулгыг ойлгуулах
- V-IX ангид “*Ёс суртахууны өгөгдөл*” гэсэн хичээл заавал орж, сурагчдад шударга, эр зориг, ичгүүр, жудаг, үүрэг ба хариуцлага, нинжин сэтгэл, нэр төр, үнэн, итгэл, тэсвэр, тэвчээр, хайр хүндлэл, эе эв, эс шуналдах, эс атаархах, эелдэг найрсаг зочломтгой ёс, ах захаа хүндлэх, эс урван тэрслэх зэрэг ёс суртахууны өгөгдлийг ой тойнд нь шингээх
- X-XII ангид “*Ёс зүйн үндэс*” гэсэн хичээл заавал оруулж, багш сурган хүмүүжүүлэгчийн, эмчийн, хуульчийн, төрийн албан хаагчийн, инженерийн, эрдэм шинжилгээний ажилтны, сэтгүүлчийн, бизнесмены, үйлчилгээний ажилтны, лам санваартны, цэргийн албан хаагчийн зэрэг ажил мэргэжлийн ёс зүйн наад захын шаардлагыг ойлгуулах
- Ерөнхий сайдаар ахлуулсан ёс суртахууны үндэсний зөвлөл байгуулж ажиллах
- Ёс зүйн хөтөлбөр боловсруулан баталж хэрэгжүүлэх
- Ёс суртахууны боловсролын ерөнхий төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэх
- Ёс суртахууны боловсролыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө жил бүр боловсруулан баталж хэрэгжүүлэх
- Ёс суртахууны нэр томъёог тодорхойлж нэгдмэл ойлголттой болох
- Ёс суртахууны дархлаа, сэтгэлгээг төлөвшүүлэх
- Багш мэргэжилтнүүдийг бэлтгэх
- Сэтгэлгээний боловсролын тухай хуулийн төсөл боловсруулах
- Ёс суртахуун, ёс зүйн талаар эрс шинэчлэлт хийх

Эрдэм шинжилгээний семинар

Монголчуудын ёс суртахуун–эрх зүйн хөгжлийг хангах үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагыг иж бүрэн тодорхойлох талаар тулгамдсан асуудлыг хэлэлцэн тодорхойлох зорилгоор төслийн удирдагч, академич С.Нарангэрэл “*Ёс суртахууныг шинжлэх ухааны үүднээс авч үзвэл...*” сэдэвт эрдэм шинжилгээний семинарыг 2018 оны 6-р сарын 13-ны өдөр зохион байгуулж, төрийн болон төрийн бус сургалт, эрдэм шинжилгээний байгууллагын эрдэмтэн судлаачид хэлэлцүүлэгт үнэтэй санал бодлоо илэрхийлж, үр дүнтэй болсон.

Монголчууд дэлхийд гайхагдсан өндөр ёс суртахууны уламжлалтай байсан нь алдуурсаар өнөөдөр манай дэлхийн хамгийн ёс суртахуунгүй ард түмнээр ад үзэгдэх болов. Монголчууд ёс суртахуунаа сэргээхэд үндэсний хэмжээнд, төрийн бодлогын түвшинд, монгол хүн бүрийн өдөр тутмын амьдралд онцгой анхаарах цаг үетэй тулгарав. Хэрэв энэ асуудлыг үл тоомсорлож, зөвхөн мөнгө, эдийн засаг бүхнийг шийдвэрлэнэ гэж үзвэл Монгол Улсын оршин тогтнохуйд шууд нөлөөлөх аюул заналхийлэл учирч байна. Ёс суртахууныг монголчуудын өдөр тутмын амьдралд, нийгмийн бүх хүрээнд тэргүүн зэрэгт тавьсан нөхцөлд л сая Монгол улсын оршин тогтнохуй багтай болно. Хэрэв монголын нийгэмд ёс суртахууны ялзрал цаашид үргэлжлээд байвал “*ичих нүүр*”, “*жудаг*”, “*нинжин сэтгэл*”, “*нэр төр*” гэсэн ухагдахууныг огт мэдэхгүй бүхэл бүтэн үе гарч ирж байгаа учраас дурдсан хөтөлбөр зайлшгүй шаардлагатай байна. Судрын чуулганд Чингис хаан монголчуудын дунд хөвгүүн нь монголчууд эцгийнхээ сургаалыг дагадаггүй, дүү нь ахынхаа үгийг тоодоггүй, эр нь эхнэртээ итгэдэггүй, эхнэр нь эрийнхээ хэлснийг дагадаггүй, хадам нь бэрээ хайрладаггүй, бэр нь хадмаа ойшоодоггүй, багачуул нь томчуулынхаа сургамжийг хайхардаггүй явдал газар авсныг таслан зогсоосон гэж тэмдэглэн үлдээсэн байдаг.

“*Монголчуудын ёс суртахуун*” үндэсний хөтөлбөрийн төслийг шинжлэх ухааны үндэстэй боловсруулж, өргөн олон түмний саналыг тусгаж, УИХ хэлэлцэн батлах нь улс орны хөгжил дэвшлийг мэдэгдэхүйц урагшлуулах болно.

Социализмын үед монголчууд тодорхой чиг хандлагагүй, ёс суртахууны бүдэг бадаг ерөнхий үг цээжилж явсан учраас өрнөдийн мэдээллийн түрэмгийллийн эсрэг сөрөн зогсож чадаагүй юм. Ардчиллын жилүүдэд нийгэмд хуулиар хориглоогүй бүхнийг зөвшөөрнө гэсэн томъёололд сохроор итгэснээс болж, нэгэн үеийнхний өвөө эмээ, эцэг эхээсээ мэдэж авсан ёс суртахууны үндэсний өв уламжлал хөсөр хаягдахад хүрч байна. Тэгэхдээ нэр төр, жудаг, нинжин сэтгэлээ арай л тавиад туучаагүй байгаа дээрээ ёс суртахууныг дээдлэх явдлыг монгол төрийн бодлого болгоход “*Монголчуудын ёс суртахуун*” үндэсний хөтөлбөрийн зорилго оршино.

Энэхүү хөтөлбөр нь монголчуудын эртнээс уламжилж ирсэн шударга ёс, ичих нүүр, жудаг, нинжин сэтгэл, нэр төр, ах захаа хүндлэх ёсон, эелдэг зочломтгой нийтэч зан, тэсвэр тэвчээр, ам ажил нь зөрдөггүй чанарыг сэргээхэд оршино. Үүгээрээ “*Би Монгол хүн*” хэмээх бахархлыг дахин сэргээн буй болгоход энэхүү хөтөлбөрийн үндсэн зорилго чиглэгдэнэ.

“*Монголчуудын ёс суртахуун*” үндэсний хөтөлбөр нь гэр бүл, боловсрол, оюун санаа, эдийн засаг, төр засаг, хууль гэсэн нийгмийн амьдралын бүхий л хүрээг хамарна.

Ёс суртахуунлаг хүмүүн төлөвших нэн чухал анхдагч орчин нь гэр бүл мөн. Үеэс үед уламжлагдан дамжиж ирсэн өвөг дээдсийн алтан сургаал, ёс суртахууны үнэт уламжлалыг хүүхэд багачуудад өвлүүлэх асуудлыг Монгол төрийн бодлогын түвшинд тавина. Үр хүүхдээ өвөг дээдэс ба үндэсний уламжлалынхаа үнэ цэнийг мэдэрдэг, амьдралд ухаалаг ханддаг, үнэнч шударга байдал, нэр төрөө эрхэмлэдэг, бусдыг хайрлан хамгаалж тусалдаг, анд найзаа зөв сонгож, дотно нөхөрлөдөг, бусдын итгэлийг даадаг, өгөөмөр сэтгэл гаргадаг, эгэл жирийн амьдралд дасан зохицдог, бусдад эелдэг найрсаг

ханддаг, хэлсэн амандаа хүрч чаддаг, шунал, хорон муу санааг жигшдэг болгоход тогтвортой (*салж сарниагүй*) гэр бүл л онцгой үүрэг гүйцэтгэнэ. Хүүхдийн ёс суртахууны төлөвшилд эцэг эхийн хувийн үлгэр дууриалал онцгой чухал гэж үзнэ.

Орчин үеийн шинжлэх ухаан-техникийн зарим хэрэгсэл (*телевиз, компьютер, гар утас зэрэг*) эцэг эх ба үр хүүхдийн хооронд хөндийрөл буй болгож, үл ойлголцол, хүнийсгэл үүсэхэд хүргэж байгааг анхаарч, түүний сөрөг нөлөөллөөс сэрэмжлэхэд анхаарал хандуулах шаардлага үүссэн байна. Эцэг эхчүүд үр хүүхдүүддээ ёс суртахууны тухай үлгэр, домог, туульс, зүйр цэцэн үгс байнга ярьж өгч, утга учрыг нь тайлбарлан таниулж байх ёстой.

Гэр бүл цуцлалт, хүүхдийн болон гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан нөхцлийг шинжлэх ухааны үндэстэй тогтоож, тэдгээрээс урьдчилан сэргийлэх асуудлыг Монгол төрийн бодлогын түвшинд авч үзнэ.

Хуулийн дээр ёс суртахуун тавигдах ёстой. Хуулийн амин сүнс угтаа ёс суртахуун юм. Хууль тогтоогчдын үндсэн зорилго нь ёс суртахууныг хамгаалах, бэхжүүлэхэд чиглэгдсэн хууль батлахад оршино. Хуульчдыг сонгон шалгаруулах, тэднийг шилж сонгоход ёс суртахууныг тэргүүн зэргийн шалгуур болгоно.

Төр түвшин байх нь засгийн эрх баригчдын ёс суртахуун, тэдний нэр хүндээс шууд хамааралтай. Ёс суртахуунлаг засаг нэр хүндтэй байна. Засаг нэр хүндтэй байх тусмаа төр тогтвортой түвшин бат байна. Их нэр хүндтэй аваас хүүхэд эцэгтээ хандах лугаа адил ард түмэн засгаа хүндэлнэ. Нэр хүндтэй засаг ёс суртахуунлаг хүмүүсээ хамгаалах үүргээ, тэднийг төрийн албанд татах явдлыг тэргүүн зэрэгт тавина.

Улс төрийн нам бол сонгуульд оролцохын тулд байгуулагдсан бүтэц юм. Хэрэв тухайн нам эх орон, ард түмний төлөө нэгэн үзүүрт сэтгэлээр хүчин зүтгэгсдийг өрсөлдүүлэхээр сонгуульд нэрийг нь дэвшүүлж чадсан тохиолдолд төрийг илааршуулах нэг ёсны эм юм. Эрүүл болсны дараа эмийн хэрэг байхгүй болдогтой нэгэн адил улс төрийн нам засгийн эрхийг авах зорилгоо биелүүлсний дараа үйл ажиллагаагаа зогсоох шаардлагатайг харуулна. Үүний тулд улс төрийн намыг хатуу гишүүнчлэлгүй болгох ёстой. Намыг толгой дээрээ гаргасан нийгэм мөхлөө дуудсантай яг ижил болно. Хэрэв нам тэмцэж байгаа үедээ дэмжигчдээ зовлон үүрүүлж байдаг бол ялсан үедээ ямба эдлүүлнэ. Хувиа бодсон бэртэгчид ашиг завшаан харж намд ирэх нь бодит зүйл. Ялсан нам руу аялдан дагалдагчид хийгээд албан тушаалтны донтнууд хуйларцгаана. Албан тушаалын төлөө намын дотоодод нанчилдаан зохион байгуулж, хор найруулан эрх тушаалд шунагчид олширсны балгаар нам ёс суртахууны хувьд амархан ялзарна. Дарга нарын өмнө нугасгүй бялдуулагчид ялж, нэр төрөө эрхэмлэгч ёс суртахуунлаг нь ямагт ялагдана. Адгийн этгээд толгой дээр гарч, өөрийгөө хамгаалуулахын тулд өөртэйгээ адилханыг хажуу хавиргандаа татдаг. Ялангуяа салиа нь арилаагүй залуусыг ёс суртахууны хувьд ялзруулна. Ялсан намд ашиг завшаан харсан бүлэглэл үүсдэг нь зүй тогтол. Ингээд намын эгэл жирийн дэмжигчид ба намын дарга нарын хооронд үл ойлголцлын хэрэм босно.

Сонгууль мөнгөний өрсөлдөөн болгон хувирч, мөнгийг ёс суртахуунаас дээгүүр тавьдаг хүмүүсийг засгийн эрхэнд гаргаад байвал улс оронд сэтгэл тэнүүн, аз жаргалтай амьдрал авчрахгүй. Ядуурал, ажилгүйдлыг аль болохоор багасгаж, ард олныг соён гэгээрүүлэх ажлыг өрнүүлэх нь сонгогчдыг саналаа худалдахаас сэрэмжлэх нөхцөл болно.

Төрийн албыг улс төрөөс хараат бус, мэргэжлийн, тогтвортой болгож, төрийн албан хаагчдын ёс зүйг өндөржүүлнэ. Төрийн албан хаагчдыг шат дараалан дэвшүүлэн ажиллуулах журамд шилжинэ.

Эрдэм шинжилгээний семинараас гарсан зөвлөмж

- ❖ Ёс суртахууныг дээдлэх явдлыг монгол төрийн бодлого болгох
- ❖ Үеэс үед уламжлагдан дамжиж ирсэн өвөг дээдсийн алтан сургаал, ёс суртахууны үнэт уламжлалыг хүүхэд багачуудад өвлүүлэх
- ❖ Үр хүүхдээ өвөг дээдэс ба үндэсний уламжлалынхаа үнэ цэнийг мэдэрдэг, амьдралд ухаалаг ханддаг, үнэнч шударга байдал, нэр төрөө эрхэмлэдэг, бусдыг хайрлан хамгаалж тусалдаг, анд найзаа зөв сонгож, дотно нөхөрлөдөг, бусдын итгэлийг даадаг, өгөөмөр сэтгэл гаргадаг, эгэл жирийн амьдралд дасан зохицдог, бусдад эелдэг найрсаг ханддаг, хэлсэн амандаа хүрч чаддаг, шунал, хорон муу санааг жигшдэг болгох
- ❖ Орчин үеийн шинжлэх ухаан-техникийн зарим хэрэгсэл эцэг эх ба үр хүүхдийн хооронд хөндийрөл буй болгож, үл ойлголцол, хүнийсгэл үүсэхэд хүргэж байгааг анхаарч, түүний сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх
- ❖ Эцэг эхчүүд үр хүүхдүүддээ ёс суртахууны тухай үлгэр, домог, туульс, зүйр цэцэн үгс байнга ярьж өгч, утга учрыг нь тайлбарлан таниулах
- ❖ Гэр бүл цуцлалт, хүүхдийн болон гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан нөхцлийг шинжлэх ухааны үндэстэй тогтоож, тэдгээрээс урьдчилан сэргийлэх асуудлыг Монгол төрийн бодлогын түвшинд авч үзэх
- ❖ Хуулийн дээр ёс суртахуун тавигдах
- ❖ Хууль тогтоогчид ёс суртахууныг хамгаалах, бэхжүүлэхэд чиглэгдсэн хууль батлах
- ❖ Хуульчдыг сонгон шалгаруулах, тэднийг шилж сонгоход ёс суртахууныг тэргүүн зэргийн шалгуур үзүүлэлт болгох
- ❖ Нэр хүндтэй засаг ёс суртахуунлаг хүмүүсээ хамгаалах үүргээ, тэднийг төрийн албанд татах явдлыг тэргүүн зэрэгт тавих
- ❖ Улс төрийн намыг хатуу гишүүнчлэлгүй болгох
- ❖ Олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг өрнүүлэх, сонгогчдыг саналаа худалдахаас урьдчилан сэргийлэх
- ❖ Төрийн албыг улс төрөөс хараат бус, мэргэжлийн, тогтвортой болгож, төрийн албан хаагчдын ёс зүйг өндөржүүлэх
- ❖ Төрийн албан хаагчдыг шат дараалан дэвшүүлэн ажиллуулах журамд шилжих
- ❖ Монголчуудын ёс суртахууны сэргээлтийн үндэсний хөтөлбөрийн төсөл боловсруулах

Эрх зүйн баримт бичгийн шинжилгээ

Суурь судалгааны төслийн ажлыг хийж гүйцэтгэх хуваарийн дагуу судалгааны багийн уулзалтыг 3 удаа зохион байгуулж сэдвийн удирдагчаас чиглэл авсаны дагуу төсөлд холбогдох мэдээлэл, эх сурвалж цуглуулах, мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн. Мэдээллийн сан бүрдүүлэх ажлын хүрээнд төрийн албаны бүхий л шатны байгууллагын ёс зүйн дүрэм, журам, олон нийтийн болон шашны, боловсролын байгууллагуудын ёс зүйн журам мөн түүнчлэн монгол улсад хүчин төгөлдөр үйлчилж буй 657 хууль тогтоомж, түүнтэй нийцүүлэн гаргасан эрх зүйн хэм хэмжээний актуудыг цуглуулж, эдгээр баримт бичгүүдэд контент анализ хийсэн.

Эрх зүйн баримт бичгийг дараах чиглэлээр агуулгын хувьд ангилан судлав.

- Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиуд болон түүнтэй нийцүүлэн гаргасан хэм хэмжээний акт, дүрэм, журам
- Төрийн улс төрийн, захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм
- Шашин, сүм хийдийн байгууллагуудын үйл ажиллагаандаа баримтлаж буй ёс зүйн дүрэм, журам
- Ёс суртахуун, зан суртахууны чиглэлээр гаргасан нэг сэдэвт бүтээл, гарын авлага, судалгааны тайлан

Төслийн багийн гишүүд төслийн хүрээнд ёс суртахуунтай холбоотой экспертийн судалгааны материал болох *Төрийн албаны тухай хууль*, *Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүй*, *Шүүгчийн ёс зүй*, *Хуульчийн ёс зүй*, төрийн 18 байгууллагуудын ёс зүйн журам, мөн түүнчлэн Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж, түүнтэй нийцүүлэн гаргасан хэм хэмжээний актуудыг цуглуулж, тэдгээр баримт бичгүүдийг нэгтгэн үзэж, бүлэг, зүйлд тусгагдсан хэм хэмжээнүүд, тэдгээрийн ижил тал, онцлог зохицуулалтад харьцуулалт болон контент анализ хийсэн.

Төслийн багийн гишүүд уг суурь судалгааны төслийн хүрээнд хууль тогтоомж, суурь судалгаа, бодлогын судалгааны тайлан, ёс суртахуунтай холбогдсон ном зохиол, Монголын нууц товчоо, Сударын чуулган, С.Нарангэрэл. Чингис хааны ёс суртахууны паштир, Хуулийн амин сүнс буюу */Чингис хааны гэрээс/* зэрэг баримт бичиг, цахим эх сурвалж зэргийг эмхэтгэж, мэдээллийн сан бүрдүүлж баримт бичгийн судалгааг хийж, экспертийн судалгааны хэрэглэгдэхүүн болгов.

Үндэсний хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлын хүрээнд дараах салбаруудын үндэсний хөтөлбөрийг цуглуулав. Үндэсний хөтөлбөрийг ангилан авч үзэхэд:

- ❖ Байгаль орчин, аялал жуулчлал, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын үндэсний хөтөлбөр
- ❖ Төрийн албаны үндэсний хөтөлбөр
- ❖ Боловсролын салбарын үндэсний хөтөлбөр
- ❖ Төрийн албан хаагчидтай холбоотой үндэсний хөтөлбөр
- ❖ Хууль, хэвлэл мэдээллийн салбарын үндэсний хөтөлбөр
- ❖ Гадаад харилцаа, соёл урлаг, бизнесийн салбарын үндэсний хөтөлбөр
- ❖ Улс төрийн салбарын үндэсний хөтөлбөр
- ❖ Барилга хот, байгуулалтын салбарын үндэсний хөтөлбөр
- ❖ Батлан хамгаалахын салбарын үндэсний хөтөлбөр
- ❖ Эрчим хүч, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын үндэсний хөтөлбөр
- ❖ Зам, тээврийн салбарын үндэсний хөтөлбөр

- ❖ Спортын салбарын үндэсний хөтөлбөр
- ❖ Шинжлэх ухаан, техник, технологи, инновацийн салбарын үндэсний хөтөлбөр
- ❖ Эрүүл мэндийн салбарын үндэсний хөтөлбөр
- ❖ Эдийн засгийн салбарын үндэсний хөтөлбөр
- ❖ Хөдөлмөр, нийгмийн хамгаалалын салбарын үндэсний хөтөлбөр
- ❖ Шашины салбарын үндэсний хөтөлбөр

Эдгээр салбарын үндэсний хөтөлбөрт контент анализ хийж Монголчуудын ёс суртахуун–эрх зүйн хөгжлийг хангах үндэсний хөтөлбөрийн төсөл боловсруулах хэрэглэгдэхүүн болгосон.

“МОНГОЛЧУУДЫН ЁС СУРТАХУУН” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ТӨСӨЛ

I. НЭР ТОМЬЁО

Хөтөлбөр - үйл ажиллагааны агуулга ба тодорхой төлөвлөлт.

Ёс суртахуун – аливаа хүмүүний эрхэм нандин зан чанарын цогц.

Ёс суртахуун заяагдмал – ёс суртахууны өгөгдөл ямар ч хүмүүнд үүсмэл бус түүний төрмөл чанар.

Ёс суртахууны өгөгдөл – шударга, эрэмгий зориг, ичгүүр, хариуцлага, жудаг, нинжин сэтгэл, нэр төр, үнэн, итгэл, тэсвэр тэвчээр, хайр, хүндлэл, эв эе, өгөөмөр, хамтач, эс шуналдах, эс хонзогнох, эелдэг, найрсаг зан, урвашгүй чанар.

Ёс суртахууны ялзрал - шударга бус, аймхай хулчигар, ичгүүр сонжуургүй, хариуцлагагүй, хүний мөсгүй, харгис хэрцгий, нэр төрөө барах, худал хуурмаг, заль мэх, гол гаргах, хэлсэн амандаа хүрэхгүй байх, тэвчээргүй, хайрлах сэтгэлгүй, ах захгүй, талцал хуваагдал хагарал, өглөгч тусч бус, нийтэч бус, шунал, хонзогнол, атаархал, хүйтэн ялдам бус зан, урван тэрслэлт зэрэг шинжүүдийн хурц илрэл.

Ёс зүй – тодорхой ажил мэргэжлийн ёс суртахууны цогц.

II. АЛДААГАА ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ НЬ

Монголчуудын гайхамшигт өвөг дээдэс монгол хүний ёс суртахууныг алдууралгүй байлгах, ёс суртахууны ялзралыг газар авахуулалгүй, таслан зогсоож байх талаар агуу ухааныг буй болгон уламжлуулж ирсэн байна. Дэлхийд дахин буй болоогүй хамгийн том эзэнт улс гүрнийг цогцлоож, манай гариг дээр 140 жилийн монголын амар амгаланг тогтоосон нь нутаг дэвсгэр, баялаг бус харин монголчуудын ёс суртахууны, оюун санааны татах хүч байсан гэдгийг ухаарах цаг болжээ. Чингис хаан түүнийг шууд залгамжлагчид байлдан дагуулалт, аян дайнаар бус ёс суртахууныхаа татах хүчээр дэлхийн эзэнт гүрнийг буй болгосон ажээ.

Харамсалтай нь уламжлан үргэлжлүүлэх ёстой байсан эл их ухааныг их хаан суурийн төлөө өөр хоорондоо тэмцэлдэж, Чингис хааны хичээнгүйлэн захисан эе эвээ бусниулсны улмаас талцал, хагарал, хуваагдал буй болгосноос хэд хэдэн харийн гүрний хараат болсоор байгаад орхигдуулан мартах болсон алдаагаа хүлээн зөвшөөрөх ёстой болсон байна. (Энэ талаар С.Нарангэрэл Монголчуудын зан суртахууны гарваль., Улаанбаатар, 2010; С.Нарангэрэл Чингис хааны сүр хүч., Улаанбаатар, 2013; С.Нарангэрэл Чингис хааны ёс суртахуун-эрх зүйн шастир., Улаанбаатар, 2014; С.Нарангэрэл Хуулийн амин сүнс буюу Чингис хаан, Монголчууд., Улаанбаатар, 2018 зэрэг бүтээлээс тодруулж үзнэ үү)

Үе үеийн эрх баригчид монголчуудыг манжид ч, социализмд ч, ардчилалд ч мухар сохроор итгүүлэх гэсний улмаас ёс суртахуунаа дээдэлж ирсэн язгуур үзэл санаагаа алдсан нь Монгол улсын нийгэм-эдийн засаг, оюун санааны өнөөгийн гүн гүнзгий хямралын үндсийн үндэс болжээ. Монголчуудыг эдийн засаг бус харин ёс суртахуун аварна гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой.

III. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

Монголчууд дэлхийд гайхагдсан өндөр ёс суртахууны уламжлалтай байсан нь алдуурсаар өнөөдөр манай дэлхийн хамгийн ёс суртахуунгүй ард түмнээр ад үзэгдэх болов. Монголчууд ёс суртахуунаа сэргээхэд үндэсний хэмжээнд, төрийн бодлогын түвшинд, монгол хүн бүрийн өдөр тутмын амьдралд онцгой анхаарах цаг үетэй тулгарав.

Хэрэв энэ асуудлыг үл тоосорлож, зөвхөн мөнгө, эдийн засаг бүхнийг шийдвэрлэнэ гэж үзвэл Монгол улсын оршин тогтнохуйд шууд нөлөөлөх аюул заналхийлэл учирч байна. Ёс суртахууныг монголчуудын өдөр тутмын амьдралд, нийгмийн бүх хүрээнд тэргүүн зэрэгт тавьсан нөхцөлд л сая Монгол улсын оршин тогтнохуй баттай болно. Хэрэв монголын нийгэмд ёс суртахууны ялзрал цаашид үргэлжлээд байвал “ичих нүүр”, “жудаг”, “нинжин сэтгэл”, “нэр төр” гэсэн ухагдахууныг огт мэдэхгүй бүхэл бүтэн үе гарч ирж байгаа учраас дурдсан хөтөлбөр зайлшгүй шаардлагатай байна. Судрын чуулганд Чингис хаан монголчуудын дунд хөвгүүн нь монголчууд эцгийнхээ сургаалыг дагадаггүй, дүү нь ахынхаа үгийг тоодоггүй, эр нь эхнэртээ итгэдэггүй, эхнэр нь эрийнхээ хэлснийг дагадаггүй, хадам нь бэрээ хайрладаггүй, бэр нь хадмаа ойшоодоггүй, багачуул нь томчуулынхаа сургамжийг хайхардаггүй явдал газар авсныг таслан зогсоосон гэж тэмдэглэн үлдээсэн байдаг.

“Монголчуудын ёс суртахуун” үндэсний хөтөлбөрийн төслийг шинжлэх ухааны үндэстэй боловсруулж, өргөн олон түмний саналыг тусгаж, УИХ хэлэлцэн батлах нь улс орны хөгжил дэвшлийг мэдэгдэхүйц урагшлуулах болно.

IV. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Социализмын үед монголчууд тодорхой чиг хандлагагүй, ёс суртахууны бүдэг бадаг ерөнхий үг цээжилж явсан учраас өрнөдийн мэдээллийн түрэмгийллийн эсрэг сөрөн зогсож чадаагүй юм. Ардчиллын жилүүдэд нийгэмд хуулиар хориглоогүй бүхнийг зөвшөөрнө гэсэн томъёололд сохроор итгэснээс болж, нэгэн үеийнхний өвөө эмээ, эцэг эхээсээ мэдэж авсан ёс суртахууны үндэсний өв уламжлал хөсөр хаягдахад хүрч байна. Тэгэхдээ нэр төр, жудаг, нинжин сэтгэлээ арай л тавиад туучаагүй байгаа дээрээ ёс суртахууныг дээдлэх явдлыг монгол төрийн бодлого болгоход “Монголчуудын ёс суртахуун” үндэсний хөтөлбөрийн зорилго оршино.

Энэхүү хөтөлбөр нь монголчуудын эртнээс уламжилж ирсэн шударга ёс, ичих нүүр, жудаг, нинжин сэтгэл, нэр төр, ах захаа хүндлэх ёсон, эелдэг зочломтгой нийтэч зан, тэсвэр тэвчээр, ам ажил нь зөрдөггүй чанарыг сэргээхэд оршино. Үүгээрээ “Би Монгол хүн” хэмээх бахархлыг дахин сэргээн буй болгоход энэхүү хөтөлбөрийн үндсэн зорилго чиглэгдэнэ.

V. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ

4.1. Хөтөлбөрийн хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ:

Зорилт 1. Сайн ба муу, шударга ёс, үүрэг, нинжин сэтгэл, нэр төр, аз жаргал зэрэг ёс суртахууны эрхэм чанарын үндсэн ухагдахуунуудыг зөв, эерэг талаас нь ойлгуулж, итгэл үнэмшил төлөвшүүлэх

Зорилт 2. Үнэнч байх, хүнлэг, энэрэнгүй байх, хөдөлмөрч хичээнгүй байх, хамтач байх, нийгэм хамт олны үйлсэд бие сэтгэлээ зориулдаг байх, байгаль орчныг дээдлэн хамгаалдаг байх, эх оронч байх зэрэг ёс суртахууны зарчмуудыг баримталдаг болгож, сэтгэлд нь суулгах

Зорилт 3. Хүнийг хүндлэх, дээдлэх, хайрлах, туслах ёс суртахуун, эрх зүйн хэм хэмжээг баримтлах хүсэл сэтгэлийг төрүүлэх, өдөр тутмын амьдралдаа баримталдаг болох

Зорилт 4. Үр хүүхэд, гэр бүл, хувь хүн, нийгмийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа ухамсарлах чадвартай болох

Зорилт 5. Харилцааны соёл эзэмшүүлэх, хувь хүн, нийгмийн бүхий л давхаргын хүмүүстэй харилцах чадвартай болох

Зорилт 6. Нийгэмд өөрийн байр суурийг олох, амьдралаа төлөвлөх, зохион байгуулах, зохицуулах, авч явах чадвартай болох

Зорилт 7. Ёс суртахуунтай, оюунлаг, хүнлэг “зөв хүн”-иргэн төлөвшүүлэх

Зорилт 8. Ёс суртахууны эрхэм чанарт суурилсан хуулиудтай болох

Зорилт 9. Ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэх

VI. ХӨТӨЛБӨРИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

“Монголчуудын ёс суртахуун” үндэсний хөтөлбөр нь гэр бүл, боловсрол, оюун санаа, эдийн засаг, төр засаг, хууль гэсэн нийгмийн амьдралын бүхий л хүрээг хамарна:

1. Гэр бүлээс төрийн ёс эхэлнэ.

Ёс суртахуунлаг хүмүүн төлөвших нэн чухал анхдагч орчин нь гэр бүл мөн. Үеэс үед уламжлагдан дамжиж ирсэн өвөг дээдсийн алтан сургаал, ёс суртахууны үнэт уламжлалыг хүүхэд багачуудад өвлүүлэх асуудлыг Монгол төрийн бодлогын түвшинд тавина. Үр хүүхдээ өвөг дээдэс ба үндэсний уламжлалынхаа үнэ цэнийг мэдэрдэг, амьдралд ухаалаг ханддаг, үнэнч шударга байдал, нэр төрөө эрхэмлэдэг, бусдыг хайрлан хамгаалж тусалдаг, анд найзаа зөв сонгож, дотно нөхөрлөдөг, бусдын итгэлийг даадаг, өгөөмөр сэтгэл гаргадаг, эгэл жирийн амьдралд дасан зохицдог, бусдад эелдэг найрсаг ханддаг, хэлсэн амандаа хүрч чаддаг, шунал, хорон муу санааг жигшдэг болгоход тогтвортой (салж сарниагүй) гэр бүл л онцгой үүрэг гүйцэтгэнэ. Хүүхдийн ёс суртахууны төлөвшилд эцэг эхийн хувийн үлгэр дууриалал онцгой чухал гэж үзнэ.

Орчин үеийн шинжлэх ухаан-техникийн зарим хэрэгсэл (телевиз, компьютер, гар утас зэрэг) эцэг эх ба үр хүүхдийн хооронд хөндийрэл буй болгож, үл ойлголцол, хүнийсгэл үүсэхэд хүргэж байгааг анхаарч, түүний сөрөг нөлөөллөөс сэрэмжлэхэд анхаарал хандуулах шаардлага үүссэн байна. Эцэг эхчүүд үр хүүхдүүддээ ёс суртахууны тухай үлгэр, домог, туульс, зүйр цэцэн үгс байнга ярьж өгч, утга учрыг нь тайлбарлан таниулж байх ёстой.

Гэр бүл цуцлалт, хүүхдийн болон гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан нөхцлийг шинжлэх ухааны үндэстэй тогтоож, тэдгээрээс урьдчилан сэргийлэх асуудлыг Монгол төрийн бодлогын түвшинд авч үзнэ.

2. Боловсрол ёс суртахуунлаг хүн болгох үйл явц

Боловсрол бол элдэв мэдээллийн цуглуулга бус харин монголын эртний уламжлалын дагуу өвөг дээдсийнхээ агуу их ухаанаас суралцаж, түүнд суурилан амьдралаа тодорхойлж, цаашдынхаа хувь заяаныхаа зүг чиг, эрч хүчийг олж авах явдал мөн.

Бүх шатны сургуульд ёс суртахууны талаар заавал үзэх дараахь хичээл, түүний хөтөлбөр, сурах бичгийг буй болгоно:

Сургуулийн өмнөх боловсролын шатанд “Ёс суртахууны А үсэг” хичээлийн хөтөлбөр, гарын авлага буй болгоно. Агуулга нь сайн хүн болох анхны мэдэгдэхүүн байна.

Ерөнхий боловсролын сургуульд:

Бага ангид “**Ёс суртахууны монгол цагаан толгой**” хичээлийн хөтөлбөр, сурах бичгийг буй болгоно. Агуулга нь ёс суртахууны талаарх монгол ардын зүйр цэцэн үг, үлгэр туульс, домог зэргээс бүрдэнэ. (Академич С.Нарангэрэлийн зохиосон “Ёс суртахууны монгол цагаан толгой” хэмээх сурах бичгийн нэгэн хувилбар 2015, 2018 онд хэвлэгдэн нийтийн хүртээл болжээ)

Дунд ангид “**Ёс суртахууны агуулга**” хичээлийн хөтөлбөр, сурах бичгийг буй болгоно. Агуулга нь ёс суртахууны үндсэн шинжийн хүмүүжил олгоход чиглэгдэнэ.

Ахлах ангид “**Ёс зүйн үндэс**” хичээлийн хөтөлбөр, сурах бичгийг буй болгоно. Агуулга нь мэргэжлийн ёс зүйн суурь хүмүүжил олгоход чиглэгдэнэ.

Их дээд сургуульд мэргэжлийнх нь чиглэлийн ёс зүйн хичээл, сурах бичгийг буй болгоно.

Ахисан түвшиний боловсролын сургалтад мэргэжлийнхээс гадна шинжлэх ухааны ёс зүй, эрдэмтний ёс зүйн судлагдахууныг буй болгоно.

Бүх шатны сургуулийн багш нарын өдөр тутмын үйл ажиллагаанд багшийн ёс зүйг чанд сахиулахад анхаарна (*Багшийн ёс зүйн дүрмийг шинэчилнэ*).

3. Ёс суртахууны төлөвшилд ажил мэргэжлийн ёс зүй нэн чухал

Манай улсад мэргэжлийн ёс зүйн олон дүрэм бий. Тэдгээрийг дараахь байдлаар ангилж болохоор байна:

Улс төрчийн ёс зүй – Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм.

Төрийн албан хаагчийн ёс зүй – Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн дүрэм.

Багшийн ёс зүй - Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багшийн ёс зүйн дүрэм, Их дээд сургууль, коллежийн багшийн ёс зүйн дүрэм.

Эмч, эмнэлгийн ажилтны ёс зүй – Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, Эм зүйч, эм найруулагчийн ёс зүйн хэм хэмжээ.

Хуульчийн ёс зүй – Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм, Шүүгчийн ёс зүйн дүрэм, Шүүхийн ёс зүйн хорооны дүрэм, Шүүхийн ажилтны ёс зүйн дүрэм, Прокурорын ёс зүйн дүрэм, Нотариатчийн ёс зүйн дүрэм, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм, Арбиторчийн ёс зүйн дүрэм.

Цагдаагийн ёс зүй – Цагдаагийн албан хаагчийн сахилгын дүрэм.

Улсын байцаагчийн ёс зүй – Гаалийн улсын байцаагчийн ёс зүйн дүрэм, Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийг ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрэм, Нийгмийн даатгалын байцаагчийн дүрэм, Оюуны өмч, улсын бүртгэлийн байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм, Стандарчилал, хэмжил зүйн газрын албан хаагчийн ёс зүйн дүрэм, Үндэсний татварын албаны ажилтны ёс зүйн дүрэм, Статистикийн байгууллагын ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэм, Төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм.

Банкны ёс зүй – Банкуудын ёс зүйн дүрэм.

Худалдааны ёс зүй – Хүнсний олон улсын худалдаанд баримтлах ёс зүй.

Нягтлан бодогчийн ёс зүй – Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм.

Сэтгүүлчийн зүйн дүрэм – Монголын сэтгүүлчдийн ёс зүйн зарчим, Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим, Монголын үндэсний радио, телевизийн ажиллагсдын ёс зүйн дүрэм.

Эрдэмтний ёс зүй – Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн дүрэм.

Дипломатын ёс зүй – Дипломат ажилтны сахилгын тусгай дүрэм.

Спортын ёс зүй – Монголын чөлөөт бөхийн холбооны ёс зүйн дүрэм.

Цэргийн албан хаагчийн зүй – Цэргийн нийтлэг дүрэм, Дотоодын цэргийн албан хаагч ёс зүйн дүрэм. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчийн ёс зүйн дүрэм.

Тагнуулчийн ёс зүй – Тагнуулын байгууллагын албан хаагчийн ёс зүйн дүрэм.

Архитектурын ёс зүй – Архитекторын ёс зүйн хэм хэмжээ.

Ёс зүйн эдгээр дүрэмд судалгаа хийж үзэхэд мэргэжлийн ёс зүйн үндсэн шаардлагыг хангаагүй, ёс суртахууны нийтлэг эрхэм чанарыг орхигдуулсан, энд тэндээс хэсэг бусгаар хуулбарлаж хэлбэрдсэн байдал ажиглагдав. Монголын нийгэмд зайлшгүй шаардлагатай гэр бүлийн ёс зүй, бизнесийн ёс зүй, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн ёс зүй, эрдэмтний ёс зүй, спортын ёс зүй зэрэг олон ёс зүйн хийдэл гарсан байна. Энэ учраас ёс зүйн дүрмийг бүхэлд нь шинэтгэх, тэдгээрийг амьдралд хэрэгжүүлэх сайтар бодож боловсруулсан хөшүүргийг буй болгох шаардлагатай болжээ.

4. Ёс суртахуунд оюуны хүрээний ач холбогдол

4.1 Ёс суртахууны төлөвшил төрөлх хэлээс эхэлнэ.

Төрөлх монгол хэл, бичиг үсгээ сайтар мэдэхгүй бол Монгол улсын иргэд оюун ухааны үндэсний ой санамжгүй болох учраас төрийн бодлогын хэмжээнд авч үзнэ.

4.2 Ёс суртахуунд олон нийтийн мэдээллийн хэрэгслийн нөлөөлөл

Ёс суртахуунд туйлаас харш тухайлбал, садар самуун, хүчирхийллийг сурталчилсан, гүтгэлэг тараасан, үндэстэн ястныг хооронд нь үзэн ядан дайсагнуулсан мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тараан түгээхийг хориглох, цагдалт (цензур) нэн даруй тогтоох шаардлагатай. Ингэх эрх зүйн үндэс нь Монгол улс 1997 онд нэгдэн орсон Утга зохиол, урлагийн бүтээлийг хамгаалах тухай Бернийн конвенцид “Энэхүү конвенцийн дагуу эрх бүхий байгууллага уг эрхийг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн бол аливаа бүтээлийг тараах, тоглох, үзүүлэхэд хууль тогтоомжоор буюу журмаар хяналт тавих, эсхүл хориглоход Холбооны гишүүн аль ч улсын засгийн газрын эрхийг ямар нэгэн байдлаар хөндөхгүй” гэж заасан явдал юм.

4.3 Ёс суртахуун ба утга зохиол, урлаг

Манай улсын урлаг, соёлын төлөөлөгчид мөнгө олох гэж үхэн хатан зүтгэх болсноор ёс суртахууныг эрхэмлэн дээдлэх бус гагцхүү ашиг олох чиг хандлага нэгэнт тогтсоныг засаж залруулах шаардлагатай болжээ. Ёс суртахууны холбогдолтой уран зохиол, яруу найраг, дуу хөгжим, кино, жүжиг, дүрслэх урлагийн бүтээл, телевизийн нэвтрүүлэг туурвихад онцгой анхаарч, сайн бүтээлийг төрөөс санхүүжүүлнэ. Монгол ардын ёс суртахууны үлгэр туульс, зүйр цэцэн үгийг эмхтгэл гаргаж нийтийн хүртээл болгоно. Урьд нь хэвлэгдсэн ёс суртахууны холбогдолтой бүтээлүүдийг түүвэрлэн эмхтгэж нийтийн хүртээл болгох арга хэмжээ авна.

Монголчуудын ёс суртахууны талаар олон нийтийн сонирхол анхаарал татахуйц сургамжтай, чансаатай бүтээл туурвих нь монголын уран бүтээлчдийн нэр төрийн хэрэг мөн.

4.4 Ёс суртахуун ба шажин шүтлэг

Ард түмэн чиг баримжаагаа алдаж, оюун санаа нь мохсон учраас тэд итгэл үнэмшлээ алджээ. Ёс суртахууны уг сурвалж шажинд үргэлж байсаар ирсэн бөгөөд шажнаас өөр юунд ч байхгүй. Түүхэн шажин шүтлэг бол ямар ч уламжлалт улс оршин тогтнохуйн үндэс суурь мөн. Шажин шүтлэгийг ёс суртахууныг тогтоогч, хамгаалагч оюун санааны хүчирхэг хэрэглүүр хэмээн үзнэ. Нэр төр, жудаг, нандин чанар, үүрэг хариуцлагыг дээдэлдэг учраас сүсэг бишрэл хүнийг хөдөлгөгч хүч болдгийг умартаж болохгүй. Харин лам санваартан ёс суртахууны номлогч байх атал шажин шүтлэгийг ёс суртахуунгүй зан үйлийг өөгшүүлэх, мөнгө олох хэрэгсэл болгон ашиглахыг хатуу хориглох шаардлагатай. Талын нэг тарсан сүм дуган үйлдсэн нүгэл хилэнцээ мөнгөөр цайруулах “түшиц” газар болгож байгааг таслан зогсоох ёстой.

5. Ёс суртахуун л төрийг түвшин болгоно.

Төр түвшин байх нь засгийн эрх баригчдын ёс суртахуун, тэдний нэр хүндээс шууд хамааралтай. Ёс суртахуунлаг засаг нэр хүндтэй байна Засаг нэр хүндтэй байх тусмаа төр тогтвортой түвшин бат байна. Их нэр хүндтэй аваас хүүхэд эцэгтээ хандах лугаа адил ард түмэн засгаа хүндэлнэ. Нэр хүндтэй засаг ёс суртахуунлаг хүмүүсээ хамгаалах үүргээ, тэднийг төрийн албанд татах явдлыг тэргүүн зэрэгт тавина.

Улс төрийн нам бол сонгуульд оролцохын тулд байгуулагдсан бүтэц юм. Хэрэв тухайн нам эх орон, ард түмний төлөө нэгэн үзүүрт сэтгэлээр хүчин зүтгэгсдийг өрсөлдүүлэхээр сонгуульд нэрийг нь дэвшүүлж чадсан тохиолдолд төрийг илааршуулах нэг ёсны эм юм. Эрүүл болсны дараа эмийн хэрэг байхгүй болдогтой нэгэн адил улс төрийн нам засгийн эрхийг авах зорилгоо биелүүлсний дараа үйл ажиллагаагаа зогсоох шаардлагатайг харуулна. Үүний тулд улс төрийн намыг хатуу гишүүнчлэлгүй болгох ёстой. Намыг толгой дээрээ гаргасан нийгэм мөхлөө дуудсантай яг ижил болно. Хэрэв нам тэмцэж байгаа үедээ дэмжигчдээ зовлон үүрүүлж байдаг бол ялсан үедээ ямба эдлүүлнэ. Хувиа бодсон бэртэгчид ашиг завшаан харж намд ирэх нь бодит зүйл. Ялсан нам руу аялдан дагалдагчид хийгээд албан тушаалтны донтнууд хуйларцгаана. Албан тушаалын төлөө намын дотоодод нанчилдаан зохион байгуулж, хор найруулан эрх тушаалд шунагчид олширсны балгаар нам ёс суртахууны хувьд амархан ялзарна. Дарга нарын өмнө нугасгүй бялдуулагчид ялж, нэр төрөө эрхэмлэгч ёс суртахуунлаг нь ямагт ялагдана. Адгийн этгээд толгой дээр гарч, өөрийгөө хамгаалуулахын тулд өөртэйгээ адилханыг хажуу хавиргандаа татдаг. Ялангуяа салиа нь арилаагүй залуусыг ёс суртахууны хувьд ялзруулна. Ялсан намд ашиг завшаан харсан бүлэглэл үүсдэг нь зүй тогтол. Ингээд намын эгэл жирийн дэмжигчид ба намын дарга нарын хооронд үл ойлголцлын хэрэм босно.

Сонгууль мөнгөний өрсөлдөөн болгон хувирч, мөнгийг ёс суртахуунаас дээгүүр тавьдаг хүмүүсийг засгийн эрхэнд гаргаад байвал улс оронд сэтгэл тэнүүн, аз жаргалтай амьдрал авчрахгүй. Ядуурал, ажилгүйдлыг аль болохоор багасгаж, ард олныг соён гэгээрүүлэх ажлыг өрнүүлэх нь сонгогчдыг саналаа худалдахаас сэрэмжлэх нөхцөл болно.

Төрийн албыг улс төрөөс хараат бус, мэргэжлийн, тогтвортой болгож, төрийн албан хаагчдын ёс зүйг өндөржүүлнэ. Төрийн албан хаагчдыг шат дараалан дэвшүүлэн ажиллуулах журамд шилжинэ.

Монгол төрийн бодлого ямар байх ёстойг бодож боловсруулах гэж, гаднаас хуулбарлах гэж зовох онцын шаардлагагүй бөгөөд энэ нь Чингис хаанаас багшдаа бичсэн захидалд тусгагдсан юм: “**Хаан миний бие умар зүгийн их хээр талд аж төрөн сууж, чигч шударгыг эрхэмлэн тогтоогоод, бүрэлгэн сүйтгэхийг хориглон зогсоож, идэх хоол, өмсөх хувцсаа адуучин үхэрчинтэй хуваалцан, ард иргэдийг үр хүүхэдтэйгээ адил үзэж, цэрэг дайчид, эрдэмтэн мэргэдийг ах дүүгээн мэт хүндэлж, эе эвийг эрхэмлэж, энэрэл хишгээ түгээмүй**” гэж бичсэн байна.

6. Ёс суртахууныг зах зээл мохоодог

Монголын ард түмний сайн сайхны төлөө бус дан ганц ашгийн төлөө чиглэгдсэн зах зээлийн эрхшээлд улс орны эдийн засаг бүхэлдээ орсон явдал ёс суртахуун хүмүүний хамгийн үнэт зүйл байхаа больж, мөнгийг бүхнээс дээр гаргав. Асар их мөнгө шударга ёс, ямар ч хуулийг салам цохих болжээ. Ашгийн төлөө эх орны нөөц баялгийг махчин мэт цөлмөж, хэрэглээний үзэл газар авав. Нөгөө талаас оюун санааны хоосрол, хувиа бодсон үзэл, хайхрамжгүй явдал цадгаа алдав. Зах зээл гэр бүл, хувь хүнийг сүйдлэх болов. Монголын хүн амын нэг хэсэг нь өр зээлэнд баригдан сэтгэл санаагаар унаж, заримдаа амьд явахад хэцүү болж, нөгөө хэсгийг нь “хар” мөнгө мансуурал, хэрээс хэтэрсэн тансаглал, аль муу муухай зүйлтэй холбогдуулж байна.

Хүн ам түүний дотор хөдөлмөрийн чадвар бүхий хэсэг цөөн, хэдхэн төрлийн экспортын бараатай манай улсын хувьд улс орныхоо онцлогт тохирсон ард түмнийхээ эрэлт хэрэгцээг чанартай хангасан эдийн засгийн загварыг буй болгохгүй бол монгол улсын цаашид оршин тогтнох эсэх нь эргэлзээтэй болж болзошгүй.

Эдийн засгийг ард түмний сайн сайхны төлөө болгоход хэрэглэгчдийг хуурч мэхэлсэн, гол гаргаж луйвардсан бол худалдаа, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох гол үндэслэл гэж үзэх нь чухал ач холбогдолтой.

7. Хуулийн амин сүнс ёс суртахуун

Хуулийн дээр ёс суртахуун тавигдах ёстой. Хуулийн амин сүнс угтаа ёс суртахуун юм.

Хууль тогтоогчдын үндсэн зорилго нь ёс суртахууныг хамгаалах, бэхжүүлэхэд чиглэгдсэн хууль батлахад оршино.

Хуульчдыг сонгон шалгаруулах, тэднийг шилж сонгоход ёс суртахууныг тэргүүн зэргийн шалгуур болгоно.

VII. ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДАХ ЭТГЭЭД

Хөтөлбөрт хамрагдах этгээд нь УИХ, Ерөнхийлөгч, Засгийн газар, орон нутгийн засаг захиргаа, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, хуулийн байгууллага, төрийн бус байгууллага, хуулийн этгээд, аж ахуйн нэгж, иргэд байх бөгөөд тэдгээрийн ёс суртахууны талаар хүлээх үүргийг тодорхой болгоно.

VIII. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

8.1. Хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

8.1.1. ёс суртахууны эрхэм чанарын сургалт, сурталчилгааны агуулгыг бэлтгэх, түгээх нэгдсэн арга зүйг боловсруулах

8.1.2. иргэдэд ёс суртахууны эрхэм чанарын талаарх мэдлэг, ойлголтыг түгээх, ёс суртахуун шаталсан сургалтын тогтолцоог бүрдүүлэх

8.1.3. олон нийтийн ёс суртахууны боловсролыг дээшлүүлэх чиглэлээр төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх;

8.1.4. ёс суртахууны сургалт, сурталчилгаанд орон нутгийн засаг захиргааны байгууллагууд, бусад холбогдох этгээдийн оролцоог нэмэгдүүлэх;

8.1.5. ёс суртахууны сургалт, сурталчилгаа, судалгааны ажилд төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангах;

8.1.6. иргэдийн ёс суртахууны боловсролыг дээшлүүлэх, хүний ёс суртахууны хандлага, дадлыг төлөвшүүлэх нөлөөллийн арга хэмжээг тогтмол зохион байгуулах;

8.1.7. бүх нийтийн ёс суртахууны мэдлэгийг дээшлүүлэхэд үүрэн холбооны аж ахуйн нэгж, хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг хариуцлагыг өндөржүүлж, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагын ёс суртахууны мэдээлэл, сурталчилгааны ажилд оролцохыг бүх талаар дэмжих;

8.1.8. тодорхой түвшний ёс суртахууны мэдлэг эзэмшсэн хамт олон болж, үүнийгээ түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн санал, санаачилга өрнүүлэх арга хэмжээг зохион байгуулах;

8.2. Хөтөлбөрийн 2 дугаар зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

8.2.1. үнэнч байх, хүнлэг, энэрэнгүй байх, хөдөлмөрч хичээнгүй байх, хамтач байх, нийгэм хамт олны үйлсэд бие сэтгэлээ зориулдаг байх, байгаль орчныг дээдлэн хамгаалдаг байх, эх оронч байх зэрэг ёс суртахууны үнэт зарчмуудыг олон нийтэд хэвшүүлэх арга хэмжээг зохион байгуулах

8.3. Хөтөлбөрийн 3 дугаар зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

8.3.1. хүнийг хүндлэх, дээдлэх, хайрлах, туслах ёс суртахуун, эрх зүйн хэм хэмжээг баримтлах хүсэл сэтгэлийг төрүүлэх, өдөр тутмын амьдралдаа баримталдаг болгох, ухамсарлуулан ойлгуулах

8.4. Хөтөлбөрийн 4 дүгээр зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

8.4.1. иргэний хувийн төлөвшил, ур чадвараа хөгжүүлэн уламжлалт их, бага таван ухаанаас суралцан амьдралд хэрэглэх чадвартай болгох

8.4.2. хувь хүн өөрөө өөрийнхөө өмнө болон гэр бүл, байгууллага, нийгмийн өмнө хүлээх үүрэг, хариуцлагаа ухамсарлах чадвартай болгох

8.5. Хөтөлбөрийн 5 дугаар зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

8.5.1. харилцааны соёлыг эзэмшиж, өөрийн амьдралын хэрэглээ болгох

8.5.2. нөхцөл байдлыг мэдэрч баг, хамт олны дунд биеэ зөв авч явдаг хэвшилтэй болгох

8.6. Хөтөлбөрийн 6 дугаар зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

8.6.1. хувь хүн хамтын амьдралын харилцаанд орох замаар нийгмийн гишүүн болох тухай зөв төсөөлөх, хувь хүнийг хүндэтгэх, соёлоос суралцаж, алхам тутамдаа хэрэглээ болгох

8.6.2. хүмүүс хамтын амьдралын дэг журмаа хэрхэн тогтоож, сахидаг талаар зөв төсөөлөлтэй болгох, түүнийг даган мөрдөж хэрэгжүүлдэг байх дадалтай болгох

8.7. Хөтөлбөрийн 7 дугаар зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

8.7.1. сайн үйл хийх, бүтээх сэтгэлтэй болгох

8.7.2. итгэл үнэмшилтэй, үнэнч байх өөрийн амьдралын хэвшил хэрэглээ, дадал болгох

8.7.3. энгийн даруу, эелдэг, эвч, туйлбартай, итгэлтэй, хүлээцтэй, уриалгахан байх занг өөрийн болгон хүн чанартай нэгэн гэдгээ үйлдэл бүрээрээ бусдад үлгэрлэн үзүүлэх

8.7.4. иргэний үүргээ биелүүлдэг, хариуцлага хүлээдэг, нийгмийн амьдралд оролцдог хэвшилтэй болгох

8.8. Хөтөлбөрийн 8 дугаар зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

8.8.1. олон нийтийн эрх зүйн ухамсрыг төлөвшүүлэх, төрийн албан хаагчдад эрх зүйн хөгжил, соёлыг эзэмшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг төрийн бүх шатны байгууллагаас зохион байгуулна.

8.8.2. бүх нийтийн эрх зүйн сургалтын тогтолцоог бүрдүүлж, эрх зүйн сургалтыг ерөнхий боловсролын болон их, дээд сургуулиудад тодорхой хэлбэр, чиглэлээр зохион байгуулж явуулах, иргэдийн эрх зүйн мэдлэг, боловсрол, соёлыг дээшлүүлэх нь төрийн бүх шатны байгууллага, аж ахуйн нэгж, бусад байгууллагын нэн чухал үүрэг болгон иргэд, байгууллагаас хуулийг сахин биелүүлэх үндсэн нөхцөлийг бүрдүүлэх;

8.8.3. хууль тогтоомжийг олон нийтэд тайлбарлан таниулах, сурталчлах, түүний биелэлтийг зохион байгуулах ажлыг төрийн захиргааны бүх шатны байгууллага хэрэгжүүлэх

8.8.4. хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах

8.8.5. ёс суртахуун, эрх зүйн хөгжлийн үзэл санааг түгээн дэлгэрүүлэх, хууль тогтоомжийг тайлбарлан таниулах, энэ талаархи олон улсын гэрээ, үндэсний хууль тогтоомжийн хэрэгжилтийг тогтмол судлах арга хэмжээ авч, хууль тогтоомжийг боловсронгуй болгоно.

8.8.6. хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, яам, Засгийн газрын бусад байгууллага, бүх шатны Засаг даргын шийдвэр ёс суртахууны эрхэм чанарт хэрхэн нийцэж байгаад дүн шинжилгээ хийх ажлыг тогтмол зохион байгуулж, хууль тогтоомжид шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах арга хэмжээ авах

8.9. Хөтөлбөрийн 9 дүгээр зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

8.9.1. нийтийн албаны ёс зүйн үлгэрчилсэн дүрмийг батлах, ёс суртахууны зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, тайлагнах, хэлэлцүүлэх ажлыг хэвшүүлэх;

8.9.2. нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс суртахуунтай холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх;

8.9.3. төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх;

8.9.4. төрийн үйлчилгээний шударга, ил тод, нээлттэй байдлын талаархи судалгааг тогтмол хийж, үр дүнг тайлагнах

8.9.5. өргөдөл, гомдол, мэдээлэл өгөх ил тод, нээлттэй суваг ажиллуулах, өргөдөл, гомдол, мэдээллийг цахим хэлбэрээр гаргах, шийдвэрлэх, хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлэх;

8.9.6. төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах.

8.9.7. шүүх эрх мэдлийн байгууллагыг улс төрийн нам, бүлгээс хараат бус ажиллах, шүүгч, прокурорыг сонгон шалгаруулах, томилох үйл явцыг улс төрийн оролцоо, нөлөөллөөс ангид, шударга, ил тод явуулах чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;

8.9.8. авлига, албан тушаалын гэмт хэргийн шийдвэрлэлтийн мэдээлэлд дүгнэлт хийх тогтолцоог бүрдүүлэх, энэ талаархи эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;

8.9.9. хувийн хэвшил дэх авлигын эрсдэлийг бууруулах, өрсөлдөөний шударга байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх

8.9.10. картель, шударга бус өрсөлдөөнийг хязгаарласан эрх зүйн орчинг сайжруулах;

8.9.11. хэвлэл мэдээллийн байгууллагын мэдээлэл олж авах, түгээх эрхийг баталгаажуулах;

8.9.12. хэвлэл мэдээллийн байгууллагын бие даасан, хараат бус байдал, хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах эрх зүйн орчинг бүрдүүлэх;

8.9.13. төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд ёс суртахуун, эрх зүйн хөгжлийн аливаа нийтлэл, нэвтрүүлэг, зар сурталчилгаа, мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэхтэй холбоотой үйл ажиллагааг ил тод, нээлттэй явуулах;

8.9.14. төрийн өндөр албан тушаалтны ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг сайжруулж, хариуцлага тооцох тогтолцоог бий болгох, авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн, зөрчил гаргасан төрийн өндөр албан тушаалтны эрхийг түдгэлзүүлэх, огцруулах, эгүүлэн татах эрх зүйн орчинг бүрдүүлэх;

8.9.15. төрийн бодлого, шийдвэр гаргахад нийгмийн сонирхлын бүлэг, иргэн оролцох, нөлөөлөх эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

8.9.16. улс төрийн хариуцлагыг дээшлүүлэх, ил тод байдлыг хангахад иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх.

8.9.17. авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх;

8.9.18. боловсролын байгууллага болон гэр бүлээр дамжуулан ёс суртахуунтай, шударга иргэнийг төлөвшүүлэх зорилгоор олон талт арга хэмжээ зохион байгуулах, ёс суртахуун болон эрх зүйн хөгжлийн боловсрол олгох агуулгыг бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөр, стандартад тусгах;

8.9.19. ёс суртахуун болон эрх зүйн хөгжлийн сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах, ёс суртахууны хандлагыг бий болгоход чиглэсэн сургалтыг үе шаттай зохион байгуулах, цахим сүлжээг ашиглах;

IX. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

Хөтөлбөрийг санхүүжүүлэхэд шаардлагатай зардлыг УИХ улсын төсвөөс гаргана.

X. ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН

Монголын нийгэм бүхэлдээ ёс суртахуунжиж, мөнгөний дээр түүнээс илүү үнэ цэнэтэй хүмүүний ёс суртахуун байдгийг ухааруулж, эх орондоо аз жаргалтай, сэтгэл тэнүүн аж төрөх оюун санааны нөхцөл бүрэлдэнэ.

XI. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

11.1. Төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг дараа оны 1 дүгээр сард багтаан хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

11.2. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээг хийх бөгөөд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг дараа оны I улиралд багтаан Засгийн газарт танилцуулна.

11.3. Шаардлагатай тохиолдолд Үндэсний зөвлөл хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш 18 сараас доошгүй хугацааны дараа үр дүнд суурилсан явцын үнэлгээ, хөндлөнгийн үнэлгээ хийлгэж болно.

11.4. Хөтөлбөрийн 1, 2 дугаар үе шат хэрэгжиж дуусах хугацаанаас 6 сарын өмнө үр дүнд суурилсан эцсийн үнэлгээ хийлгэж, тайланг Үндэсний зөвлөлөөр хэлэлцэн үр дүнг Засгийн газарт танилцуулна.

Суурь судалгааны төслийн үр дүнд гарсан гол бүтээлүүд

1. Нарангэрэл С. *“Ёс суртахууны Монгол цагаан толгой”* /нэмж засварласан 2 дахь хэвлэл/. нэг сэдэвт бүтээл. Уб., 2018

Ёс суртахууны боловсрол олгоход чиглэгдсэн ёс суртахууны эрхэм сайхан зан чанар болох найрсаг зан, жудаг, шударга ёс, эр зориг, ичгүүр, нинжин сэтгэл, нэр төр, тэвчээр, эв эеийг энгийн ойлгомжтой хэлбэрээр илэрхийлсэн. Энэ бүтээлд өнөө үед гарч буй ёс суртахууны нийтлэг зарим алдаа, зөрчил, Чингис хааны үеийн түүхэн баримтад түшиглэсэн ёс суртахууны сургамжит үйл явдлууд, хүүхэд бүр насан туршдаа санаж явах ёс суртахууны дүгнэлт, сургамжийг нэгтгэн бичсэн.

2. Нарангэрэл С. *“Хуулийн амин сүнсний эрэлхийлэл” (Чингис хааны гэрээс)*. /нэмж засварласан 3 дахь хэвлэл/. Жиком пресс. нэг сэдэвт бүтээл. Уб., 2018

Товч агуулга: Монголчууд эрт дээр үеэс асар өндөр ёс суртахуунтай ард түмэн байсаар ирсэн билээ. Ялангуяа Чингис хааны өвөг дээдэс болон Их Хаадууд ёс суртахууныг дээдэлж, ёс суртахууны эрхэм чанараар дэлхийг татаж 140 жил Монголын амар амгаланг тогтоож байжээ. Гэвч Их хаад болон Бага хаадын хагаралдаан болж Монгол Улс тархай, бутархай болсон, 220 жил Манжийн нөлөөнд орж үндэсний эрх мэдлээ алдсан, Зөвлөлтийн нөлөөнд орж ард түмэн хоёр нүүртэй болсон зэргээс монголчууд ёс суртахууны язралд орсоор иржээ. Сүүлийн 30 жилд монголчууд барууны нөлөөнд автаж, мөнгийг тансаг хэрэглээ болгож, ёс суртахууны доройтол улам ихэссээр байна. Монголчууд ёс суртахууныг дээдэлсэн тохиолдолд энэ байдлаас гарч хөгжил дэвшлийн замд орж, дэлхийн бахархалтай ард түмэн, үндэстэн болж, сэтгэл тэнүүн амьдрах орчин нөхцөл бүрдэх юм. Хүмүүний ёс суртахууны заяагдмал чанар хэмээхүй дор монголчууд хуулийг дээдэлж төрт ёсны уламжлал хийгээд ёс суртахууны мөн чанарыг нийгмийн хөгжлийн өнөөгийн чиг хандлагатай уялдуулан тайлбарлахыг хичээсэн, Чингис хааны хуульт төр, уламжлалт ёс заншил, ухаант ёс суртахууны үндэс угсааг дээдлэн тодруулсанд эл бүтээлийн гол онцлог, шинжлэх ухааны ач холбогдол оршино. Энэхүү бүтээл нь хуульчид, хууль зүй судлалаар суралцагсад төдийгүй хууль тогтоогчид, улс төрчид, төрийн албан хаагчид заавал унших номд зүй ёсоор тооцогдоно.

3. Нарангэрэл С. *“Монголчуудын ёс суртахуун: сэргэлт, ялзрал, эргэн сэргээлт”*. нэг сэдэвт бүтээл. Уб., 2020

“Монголчуудын ёс суртахуун–эрх зүйн хөгжлийг хангах үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагыг иж бүрэн тодорхойлох нь” суурь судалгааны төслийн үр дүнг нэгтгэн илэрхийлсэн бүтээл.

4. ШУА-ийн ФХ, МУИС-ийн Хууль зүйн сургууль, Хуульчдын холбоо. *“Монгол Улс дахь хуульчдын ёс зүйн тулгамдсан асуудал”* сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэл. Уб., 2019

ШУА-ийн Философийн хүрээлэнгээс санаачлан МУИС-ын Хууль зүйн сургууль, Монголын Хуульчдын Холбоотой хамтран 2019 оны 4-р сарын 26-ны өдөр *“Монгол Улс дахь хуульчдын ёс зүйн тулгамдсан асуудал”* сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулав. Тус эрдэм шинжилгээний хуралд төслийн удирдагч, академич С.Нарангэрэл *Монголын хуульчид ёс зүйгээ сахидар юм уу?* (Онол-практикийн зангилаа асуудал), төслийн багийн гишүүн, доктор /Ph.D/ Д.Батмөнх *“Монголын хуульчдын ёс зүйн талаархи олон нийтийн үнэлэмж”* илтгэл тус тус хэлэлцүүлэв. Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэлийг хэвлэн нийтлүүлж, олон нийтийн

хүртээл болгосон. Уг бүтээлийг академич С.Нарангэрэл, доктор, дэд профессор Д.Батмөнх нар редакторласан.

5. ШУА-ийн ФХ. МАН. **Өнөөгийн Монголын нийгмийн улс төрийн хариуцлага, ёс зүйн зангилаа асуудал.** Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэл.Уб.,2018

Удирдлагын Академи, Стратеги Академи, ШУА-ийн Философийн хүрээлэнтэй хамтран “*Өнөөгийн монголын нийгмийн улс төрийн хариуцлага, ёс зүйн зангилаа асуудлууд*” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг 2018 оны 10-р сарын 16-ны өдөр зохион байгуулсан. Төслийн удирдагч, академич С.Нарангэрэл эрдэм шинжилгээний бага хуралд “*Монголчуудын ёс суртахуун үндэсний хөтөлбөрийн шинжлэх ухааны үндэслэгээ*”, төслийн багийн гишүүн, доктор Д.Батмөнх “*Шударга ёсыг төлөвшүүлэхэд хэвлэл мэдээллийн хэрэгсэлийн гүйцэтгэх үүрэг, ач холбогдол*” илтгэлийг эрдэм шинжилгээний бага хуралд тус тус хэлэлцүүлсэн. Эрдэм шинжилгээний бага хуралд 9 илтгэл хэлэлцүүлж, илтгэлийн эмхэтгэлийг хэвлэн нийтлүүлж, олон нийтийн хүртээл болгов.

6. ШУА-ийн ФХ. МАН-ын ёс зүйн хороо. **Ёс зүйн тулгамдсан асуудал.** гарын авлага Уб.,2020

Нийгмийг соён гэгээрүүлэх зорилгоор ёс зүйн тулгамдсан асуудал болон тайлбар толь бүхий гарын авлага.

7. Ц.Жаргал, Ц.Баянмөнх, М.Долгорсүрэн, Ё.Ундрал. **“Ёс суртахууны боловсрол”** экспертийн судалгааны тайлан.Уб.,2020

Суурь судалгааны төслийн хүрээнд боловсролын салбарын ёс суртахууны өнөөгийн байдал, ерөнхий боловсролын хичээлийн хөтөлбөрт ёс суртахууны мэдлэг олгох талаар хэрхэн туссан болон цаашид хэрхэн боловсронгуй болгох, хүүхэд хүн болж төлөвших, тэдний ёс суртахуун, үнэт зүйл, эрхэм чанар бүрэлдэн тогтоход ямар хүчин зүйлс түлхүү нөлөөлж байгаа болон сурагчдад ёс суртахууны боловсролыг танхимаар олгохдоо ямар аргаар, хэрхэн олговол зохистой эсэх, ном, сурах бичгийн агуулга ямар түвшинд байгаа, ямар байвал зохих зэрэг асуудлыг тодруулах зорилгоор “**Ёс суртахууны боловсрол**” экспертийн судалгааг улсын болон хувийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн 110 багш, сурган хүмүүжүүлэгч нараас түүврийн дагуу тоон судалгааны мэдээллийг 5 судлаачийн бүрэлдэхүүнтэй зохион байгуулж, асуулгын аргаар мэдээлэл авч, асуулгын нэгдсэн тоон үр дүнд үндэслэж, шинж чанараас хамааран тархалтаар нь харьцуулсан шинжилгээ, урвуу болон шууд хамаарлын шинжилгээ, 2 болон 3 хүчин зүйлийн харьцуулсан шинжилгээ, график шинжилгээ зэргийг хийж үр дүнд анализ хийж, хийж зөвлөмж боловсруулсан.

Судалгааны тайлан нь:

- Судалгааны арга зүй
- Судалгааны тайлан
- Дүгнэлт, зөвлөмж гэсэн гурван бүлэгтэй.

Нэгдүгээр бүлэгт судалгааны зорилго, зорилт, объект, зохион байгуулалт, арга зүй, аргачлал зэргийг тусгасан.

Хоёрдугаар бүлэгт цуглуулсан мэдээлэл болон *Монголчуудын ёс суртахуун–эрх зүйн хөгжлийг хангах үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагыг иж*

бүрэн тодорхойлох талаар онолын үзэл баримтлал, судалгааны баримт бичиг, эрх зүйн акт, ном зохиол, бусад эх сурвалжийг нэгтгэн, харьцуулалт, дүн шинжилгээ хийв.

Гуравдугаар бүлэгт судалгааны мэдээллийг нэгтгэн дүгнэж дүгнэлт бичив. Мөн судалгааны үр дүнд тулгуурлан зөвлөмж боловсруулсан.

Суурь судалгааны төслийн үр дүн нь Монгол Улсад ёс суртахууны эрхэм чанартай бие хүн, хамт олныг төлөвшүүлэх шинжлэх ухааны үндсийг тодорхойлж, Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж, дагаж мөрдөж буй хууль тогтоомжийг ёс суртахуунтай болгох, ялангуяа хуульчдын ёс зүйг төлөвшүүлэх, нийгмийн амьдралыг ёс суртахуунтай хуулиар удирддаг болгох асуудлыг иж бүрэн судалж, Монголчуудын ёс суртахуун эрх зүйн хөгжлийг хангах хөтөлбөр, сэдэвт бүтээл, эмхэтгэл, гарын авлага, санал, зөвлөмжийг боловсруулж, олон нийтийн хүртээл болгосон. Ёс суртахуунд суурилсан хуулиудтай болж, Монголын нийгмийн цаашдын хөгжил дэвшлийг хангах иж бүрэн нөхцлийг бүрдүүлэх ач холбогдолтой. Монгол Улсын гэр бүл, боловсрол, төрийн болон өөрөө удирдах ёсны бүх шатны байгууллага, соёл, урлаг, хэвлэл мэдээлэл, шашин, аж ахуй нэгж зэрэг монголын нийгмийн бүхий л хүрээнд ашиглах боломжтой байна.

Суурь судалгааны төслийг гүйцэтгэх, санхүүжүүлэх гэрээгээр хүлээсэн төслийг гүйцэтгэх ажил, үр дүнгийн даалгаврыг хангалттай сайн гүйцэтгэж хэрэгжүүлсэн.

Суурь судалгааны төслийг гүйцэтгэх, санхүүжүүлэх гэрээгээр хүлээгээгүй үүрэг бөгөөд төслийн гүйцэтгэгч нар өөрсдийн санал санаачилгаар өнөөгийн нийгмийн ёс зүйн асуудалд дүн шинжилгээ хийх, тулгамдсан асуудлыг тодруулж, шударга ёс, ёс зүйг нийгэмд төлөвшүүлэх зорилгоор “*Өнөөгийн монголын нийгмийн улс төрийн хариуцлага, ёс зүйн зангилаа асуудлууд*” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулж, эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэл болон зөвлөмжийг хэвлэн нийтлүүлж, олон нийтийн хүртээл болгов. Төслийн гүйцэтгэгч нар өөрсдийн санал санаачилгаар “*Ёс зүйн тулгамдсан асуудал*” гарын авлага хэвлэн нийтлүүлж, олны хүртээл болгов.

Суурь судалгааны төслийн үр дүн болгож төслийн гүйцэтгэгчид Монголчуудын ёс суртахуун–эрх зүйн хөгжлийг хангах үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагыг иж бүрэн тодорхойлох чиглэлээр нэг сэдэвт бүтээл-9, эрдэм шинжилгээний өгүүлэл-10, илтгэл-19, эмхэтгэл-2, гарын авлага-1, судалгааны тайлан-1-ийг тус тус бичиж нийтлүүлж, олон нийтийн хүртээл болгож, эрдэм шинжилгээний эргэлтэд орууллаа.

**ТӨСЛӨӨР ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН КАЛЕНДАРЧИЛСАН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Д /д	Төслийн хүрээнд гүйцэтгэх тодорхой үе шатны ажлын нэр	Эхлэх дуусах хугацаа (Он, сар)	Тухайн шатны үр дүн
1	<p>Баримт бичгийн судалгаа</p> <p>-Хууль тогтоомж, сонин сэтгүүл, судалгааны тайлан зэрэг холбогдох эх сурвалж, баримт бичгүүдийг эмхэтгэх</p> <p><i>(Шаардлагатай баримт материалыг хувилж авах, худалдаж авах гэх мэт)</i></p>	2017.01-2017.05 сар	<p>Суурь судалгааны төслийн ажлыг хийж гүйцэтгэх хуваарийн дагуу төслийн багийн уулзалтыг 3 удаа зохион байгуулж төслийн удирдагчаас чиглэл авсаны дагуу төсөлд холбогдох мэдээлэл, эх сурвалж цуглуулах, мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн. Мэдээллийн сан бүрдүүлэх ажлын хүрээнд төрийн албаны бүхий л шатны байгууллагын ёс зүйн дүрэм, журам, олон нийтийн болон шашны, боловсролын байгууллагуудын ёс зүйн журам мөн түүнчлэн Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй 657 хууль тогтоомж, түүнтэй нийцүүлэн гаргасан эрх зүйн хэм хэмжээний актуудыг цуглуулж, эдгээр баримт бичгүүдэд контент анализ хийсэн.</p>
2	<p>Уулзалт, хэлэлцүүлэг</p> <p>Судлаач, эрдэмтдийг оролцуулан уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах</p>	2017.10 сар	<p>Төслийн гүйцэтгэгч нар төслийн ажлын хүрээнд Академич С.Нарангэрэлийн “<i>Ёс суртахууныг шинжлэх ухааны үүднээс авч үзвэл...</i>” сэдэвт эрдэм шинжилгээний семинарын бэлтгэл ажлыг хангаж, Олон улсын харилцааны хүрээлэн, Геоэкологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнуудад мэдээлэл түгээж, хүрээлэн болон МУИС-ийн хууль зүйн сургуулийн вэбсайтад байршуулж, facebook болон социал ертөнцөөр сурталчилж, Шүүхийн ерөнхий зөвлөл, ШУА-ийн Философийн хүрээлэн, Геэкологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнуудад 2018 оны 6-р сарын 13-ны өдөр зохион байгууллаа. Эрдэм шинжилгээний семинараар Монголчуудын ёс суртахуун – эрх зүйн хөгжлийг хангах үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагыг иж бүрэн тодорхойлох талаар тулгамдсан асуудлыг хэлэлцэн тодорхойлов. Удирдлагын Академи, Стратеги Академи, ШУА-ийн Философийн хүрээлэнтэй хамтран “<i>Өнөөгийн монголын нийгмийн улс төрийн хариуцлага, ёс зүйн зангилаа асуудлууд</i>” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг 2018 оны 10-р сарын 16-ны өдөр зохион байгуулсан.</p>

			Төслийн удирдагч, академич С.Нарангэрэл эрдэм шинжилгээний бага хуралд “Монголчуудын ёс суртахуун үндэсний хөтөлбөрийн шинжлэх ухааны үндэслэгээ”, төслийн багийн гишүүн, доктор Д.Батмөнх “Шударга ёсыг төлөвшүүлэхэд хэвлэл мэдээллийн хэрэгсэлийн гүйцэтгэх үүрэг, ач холбогдол” илтгэлийг эрдэм шинжилгээний бага хуралд тус тус хэлэлцүүлсэн. Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэлийг хэвлэн нийтлүүлж, олон нийтийн хүртээл болгов.
3	Экпертийн түвшний социологийн судалгааны үндсэн хэрэглэгдэхүүн боловсруулах	2018.01-2018.05 сар	Боловсролын салбарын ёс суртахууны өнөөгийн байдал, ерөнхий боловсролын хичээлийн хөтөлбөрт ёс суртахууны мэдлэг олгох талаар хэрхэн туссан болон цаашид хэрхэн боловсронгуй болгох асуудлыг тандан судлах зорилгоор “Ёс суртахууны боловсрол” экспертийн төвшний 19 асуулт бүхий социологийн судалгааны анхдагч хэрэглэгдэхүүн болох экспертийн анкетийн санал асуулгыг төслийн багийн гишүүд ЭШДЭА Ц.Жаргал, Ё.Ундрал, М.Долгорсүрэн, ЭШДаА Ц.Баянмөнх нар хамтран боловсруулав.
4	Мэдээлэл цуглуулах	2018.05-2018.07 сар	“Ёс суртахууны боловсрол” анкетийн болон чанарын судалгааг Улаанбаатар хот болон Дундговь, Говьсүмбэр, Увс, Ховд, Дорнод аймгийн ерөнхий боловсролын сургуулийн 110 багш нараас авсан.
5	Судалгааны мэдээлэл боловсруулах, тайлан бичих	2018.10 сар	Шинжээчийн судалгааны тоон болон чанарын мэдээллийг нэгтгэн боловсруулж, судалгааны үр дүнд тулгуурлан урвуу болон шууд хамаарлын шинжилгээ, 2 болон 3 хүчин зүйлийн харьцуулсан шинжилгээ, график шинжилгээ зэргийг хийж, “Ёс суртахууны боловсрол” экспертийн судалгааны тайлан бичив.
6	Дугуй ширээний ярилцлага зохион байгуулах	2018.9 сар	Боловсролын хүрээлэн, МУИС-ийн Нийгмийн ухааны сургууль, Соёл урлагийн их сургууль, МУБИС-ийн Багшийн сургууль, Насан туршийн боловсролын үндэсний төв, Сургуулийн нийгмийн ажилтаны холбоо, Мэргэжил дээшлүүлэх институци, Нийслэлийн Ерөнхий боловсролын 23, 50, 51 дүгээр сургууль, Олонлог, Монгени, Сант сургуулийн багш, нийгмийн ажилтан нарыг оролцуулан “Монголчуудын ёс суртахууны боловсрол” эрдэм шинжилгээний хэлэлцүүлгийг 2019 оны 5-р сарын 24-ний өдөр зохион байгуулав. Хэлэлцүүлгийн илтгэгч, төслийн удирдагч,

			академич С.Нарангэрэл “Монголчуудын ёс суртахууны боловсрол” сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн бөгөөд эрдэм шинжилгээний хэлэлцүүлгийн мэдээ мэдээллийг бэлтгэн хүрээлэнгийн веб хуудсанд байршуулж, олны хүртээл болгов.
7	Хөтөлбөрийн боловсруулах төсөл	2019.01-06 сар	Төслийн багийн гишүүд суурь судалгааны төслийн хүрээнд Монгол Улсын хэмжээнд гаргасан нийгэм, улс төр, төр, эдийн засаг, шашин, соёл урлаг, хэвлэл мэдээлэл, батлан хамгаалах, төрийн алба, хууль, бизнесийн салбаруудын төсөл, үндэсний хөтөлбөрүүдийг цуглуулж, архивлан авч мэдээллийн сангийн бүрдүүлэлт бий болгосон. Монголчуудын ёс суртахуун–эрх зүйн хөгжлийг хангах үндэсний хөтөлбөрийн төсөл боловсруулж, загвар гаргах ажлыг гүйцэтгэж, төслийн удирдагч, академич С.Нарангэрэл “Монголчуудын ёс суртахуун үндэсний хөтөлбөрийн шинжлэх ухааны үндэслэгээ” сэдэвт эрдэм шинжилгээний илтгэлийг “Өнөөгийн монголын нийгмийн улс төрийн хариуцлага, ёс зүйн зангилаа асуудлууд” сэдэвт эрдэм шинжилгээний бага хуралд хэлэлцүүлсэн.
8	Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах	2019.9 сар	ШУА-ийн Философийн хүрээлэнгээс санаачлан МУИС-ын Хууль зүйн сургууль, Монголын Хуульчдын Холбоотой хамтран 2019 оны 4-р сарын 26-ны өдөр “Монгол Улс дахь хуульчдын ёс зүйн тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулав. Эрдэм шинжилгээний бага хурлын талаарх мэдээг хүрээлэнгийн вэб хуудсанд байршуулж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчиллаа. Тус эрдэм шинжилгээний хуралд төслийн удирдагч, академич С.Нарангэрэл <i>Монголын хуульчид ёс зүйгээ сахидаг юм уу?</i> (Онол-практикийн зангилаа асуудал), төслийн багийн гишүүн, доктор /Ph.D/ Д.Батмөнх “Монголын хуульчдын ёс зүйн талаархи олон нийтийн үнэлэмж” илтгэл тус тус хэлэлцүүлэв. Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэлийг хэвлэн нийтлүүлж, олны хүртээл болгосон.
9	Төслийн үр дүнг нэгтгэн нэг сэдэвт бүтээл хэвлүүлэх	2019.12 сар	Төслийн удирдагч, академич С.Нарангэрэл төслийн үр дүнг нэгтгэн “Монголчуудын ёс суртахуун: сэргэлт, ялзрал, эргэн сэргээлт” нэг сэдэвт бүтээлийг бичиж олон нийтийн хүртээл болгов.

ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН ДААЛГАВАР

/Техникийн даалгавар/

д/д	Төслөөр бий болох үр дүн	Тоо хэмжээ	Үр дүнгийн биелэлт
1	Уулзалт, ярилцлага, хэлэлцүүлэг зохион байгуулах	1	<p>Төслийн удирдагч, академич С.Нарангэрэл “Ёс суртахууныг шинжлэх ухааны үүднээс авч үзвэл...” сэдэвт эрдэм шинжилгээний семинарыг Олон улсын харилцааны хүрээлэн, Шүүхийн ерөнхий зөвлөл, ШУА-ийн Философийн хүрээлэн, Геоэкологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнуудад зохион байгуулсан. Эрдэм шинжилгээний семинараар Монголчуудын ёс суртахуун – эрх зүйн хөгжлийг хангах үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагыг иж бүрэн тодорхойлох талаар тулгамдсан асуудлыг хэлэлцэн тодорхойлов.</p> <p>Удирдлагын Академи, Стратеги Академи, ШУА-ийн Философийн хүрээлэнтэй хамтран “Өнөөгийн монголын нийгмийн улс төрийн хариуцлага, ёс зүйн зангилаа асуудлууд” сэдэвт эрдэм шинжилгээний 2018 оны 10-р сарын 16-ны өдөр зохион байгуулсан бага хуралд төслийн удирдагч, академич С.Нарангэрэл эрдэм шинжилгээний бага хуралд “Монголчуудын ёс суртахуун үндэсний хөтөлбөрийн шинжлэх ухааны үндэслэгээ”, төслийн багийн гишүүн, доктор Д.Батмөнх “Шударга ёсыг төлөвшүүлэхэд хэвлэл мэдээллийн хэрэгсэлийн гүйцэтгэх үүрэг, ач холбогдол” илтгэлийг тус тус хэлэлцүүлсэн. Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэл болон зөвлөмж, санал, чиглэлийг хэвлэн нийтлүүлж, олон нийтийн хүртээл болгов.</p>
2	Экспертийн судалгаа авах	1	<p>“Ёс суртахууны боловсрол” анкетийн судалгааг Улаанбаатар хот болон Дундговь, Говьсүмбэр, Увс, Ховд, Дорнод аймгийн ерөнхий боловсролын сургуулийн 110 багш нараас авсан.</p>
3	Эрдэм шинжилгээний сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж, нийтлүүлэх	5	<p>2017-2019 онд төслийн хүрээнд төслийн багийн гишүүд эрдэм шинжилгээний сэтгүүлд 10 өгүүлэл нийтлүүлж, олны хүртээл болгосон.</p>

4	ОУ-ын болон дотоодын эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлэх	3	Төслийн хүрээнд 2017-2019 онд төслийн багийн гишүүд ОУ-ын болон дотоодын эрдэм шинжилгээний хуралд 19 эрдэм шинжилгээний илтгэлийг хэлэлцүүлж, хэвлэн нийтлүүлж, олон нийтийн хүртээл болгов.
5	Нэг сэдэвт бүтээл	1	Төслийн багийн гишүүд нэг сэдэвт бүтээл 9 хэвлэн нийтлүүлж, олон нийтийн хүртээл болгосон.
6	Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах	1	Төслийн хүрээнд эрдэм шинжилгээний бага хурал 2 удаа зохион байгуулж, хурлын илтгэлийн эмхэтгэл болон санал, зөвлөмжийг хэвлэн нийтэлж, олны хүртээл болгов.
7	“Монголчуудын ёс суртахуун-эрх зүйн хөгжлийг хангах хөтөлбөр” боловсруулах	1	Төслийн багийн гишүүд Монголчуудын ёс суртахуун-эрх зүйн хөгжлийг хангах үндэсний хөтөлбөрийг боловсруулж, төслийн удирдагч, академич С.Нарангэрэл <i>Өнөөгийн монголын нийгмийн улс төрийн хариуцлага, ёс зүйн зангилаа асуудлууд</i> ” сэдэвт эрдэм шинжилгээний бага хуралд <i>“Монголчуудын ёс суртахуун үндэсний хөтөлбөрийн шинжлэх ухааны үндэслэгээ”</i> сэдэвт эрдэм шинжилгээний илтгэлийг хэлэлцүүлж, үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулж, хэвлэн нийтлүүлж, олны хүртээл болгов. Үндэсний хөтөлбөрийг төслийн үр дүн болох <i>“Монголчуудын ёс суртахуун: сэргэлт, ялзрал, эргэн сэргээлт”</i> нэг сэдэвт бүтээлд хэвлэн нийтлүүлж олон нийтийн хүртээл болгосон.
Хураангуй: Улс төрийн лидерийн имиж бүрдүүлэх үйл явц нь улс төрийн ажил хэрэг, улс төрийн соёл, улс төрийн ёс суртахуун, ёс зүй, сонгуулийн кампанит ажил зэрэг нийгэм-улс төрийн олон хүчин зүйлтэй холбогддог. Сонгуульд нэр дэвшигчид өөрийн улс төрчийн имижийг бүрдүүлэх үйл ажиллагааг сонгуулийн кампанийн технологийн салшгүй бүрдэл хэмээн үзэж, түүнд онцгой анхаарал хандуулдаг ч гэлээ сонгуулийн үйл явцын өрнөлтийн онцлог нөхцөл байдал; улс төрийн лидерийн хувийн соёл, зан чанар, ёс суртахуун зэрэг хүчин зүйлтэй холбогдуулан тус тусын имижийг бүрдүүлэх үйл явцын технологийг бие биенээсээ ялгаа онцлогтойгоор сонгон хэрэгжүүлдэг. Улс төрийн нийтлэг жишгээс үзвэл улс төрийн лидерийн имиж бүрдэлт харилцан хамааралт олон шатлалт нарийн нийлмэл үзэгдэл болох нь илэрхий. Энэ тухайд энэхүү өгүүлэлд тодорхой авч үзэх болно. Ингэхдээ зохиогч 2013 онд болж өнгөрсөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн

кампанийн жишээн дээр суурилан тухайн сонгуульд намуудаас нэр дэвшсэн улс төрчид имижээ хэрхэн яаж бүрдүүлсэн, ямар арга технологийг голлон хэрэгжүүлж, үр дүнд хүрсэн тухайд зарим зүйлийг тодруулан авч үзэх болно.

Улс төр судлалд “имиж” гэсэн нэр томъёо нь ХХ зууны улс төрийн судлалд зонхилгогч парадигм болон хэлбэршиж байсан “үйл байдлын онол” буюу “бихевиорист арга зүйн” хөгжилтэй холбогдон улс төрд шинэ тутам орж ирсэн ойлголт гэж үздэг ч түүний онол, үзэл санааны уг үндэс нь нэн эрт үеэс гаралтай гэж судлаачид үздэг. Манай улсын хувьд ч гэсэн энэ ойлголтыг сонгодог агуулгаар нь нэршиж заншаагүй ч, төрт ёсны үндэсний уламжлал соёлын хөгжилтэй холбогдуулан өргөн хэрэглэж байсан түүхэн баримтууд байдаг.

“Имиж”, “улс төрийн имиж”, “улс төрийн лидерийн имиж” гэсэн нэр томъёоны хоорондын харилцан хамаарал, нэвчин уусах жам ёс, чиг хандлага зэргийг судлан тогтоох нь улс төрийн имиж судлалын анхаарлын төвд байх учиртай асуудал хэмээн үзэж байна. Имиж нь улс төрийн орчинд илрэхдээ улс төрд идэвхтэй оролцон тоглогч хувь хүн, улс төрийн лидерийн болон институцийн улс төрийн үйл



ШУДАРГА

ЁС

Мэдээлэл, онол, аргагүйн улирал тутмын цуврал

2018 (15)





МОНГОЛЧУУДЫН УЛС ТӨРИЙН СОЁЛ БА НИЙГМИЙН ЁС ЗҮЙ

Монгол Улсын Шинжлэх Ухааны академийн
Философийн хүрээлэнгийн, Улс төр, эрх зүйн
салбарын эрдэм шинжилгээний гэдг ажилтан,
У.Батцэрэн, Доктор (Ph.D);
Монголын үндэсний их сургууль, Хууль зүйн
сургууль, Докторант Б.Мөнхгөл

Түлхүүр үгс: ёс суртахуун, ёс зүй, ёс заншил, улс төрийн соёл, ардчилал, манипуляци, коммуникаци, улс төрийн имиж, улс төрч.

Хураангуй: Ёс суртахуун, ёс зүй бол улс төрийн соёлын чухал бүрэлдэхүүн элемент билээ. Монголын улс төрийн соёл нь ардчиллын жилүүдэд шинэчлэгдэн өөрчлөгдсөөр байгаа хэдий ч нийгэмд мөрдөгдөх ёстой суурь үнэт зүйлс нь хэвээр оршиж иргэдийн улс төрийн хандлага, чиг баримжааг тодорхойлсоор байна. Үүнтэй холбогдуулан өнөөгийн улс төрчид улс төрийн үйл байдлыг улс төрийн соёлын хандлагын үүднээс ёс суртахуун, ёс зүйн шалгуураар авч үзэхэд анхаарал төвлөрүүлж байна. Үүний нэгэн тод жишээ бол Монгол Улсын Шинжлэх Ухааны академийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарт “Монголын улс төрийн үйл явцын хөгжилд улс төрийн соёлын гүйцэтгэх үүрэг”, “Монголчуудын ёс суртахуун – эрх зүйн хөгжлийг хангах үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагыг иж бүрэн тодорхойлох нь” сэдэвт суурь судалгааны төслийг гүйцэтгэж байна. Улс төрчийн хувийн соёл, зан чанар, ёс суртахуун зэрэг нь түүний улс төрийн имижийг тодорхойлж улмаар олон

нийтийн сэтгэл зүйд буюу нийгэмдээ нөлөөлдөг.

Монголын улс төрийн хөгжил, тогтвортой байдал, улс төрчдийн шударга байдал, иргэдийн ухамсар нь ардчилсан улс төрийн соёлын төлөвшлөөс шууд хамаарна. Иймд эл өгүүлэлд улс төрийн амьдралын субъектив талыг тусгадаг улс төрийн соёлыг онолын үндэс, өнөөгийн монголын нийгэм-улс төрийн амьдралын баримтуудад тулгуурлан ёс суртахуун, ёс зүйн хэмжүүрээр авч үзэхийг зорьсон болно.

Эртний Грекийн гүн ухаантан Аристотель ёс зүй бол улс төрийн онолын удиртгал, оршил болж зайлшгүй шаардагдана гээд хүнийг хүн болгодог гол чанар бол ёс суртахууны ухамсар гэсэн санааг хэлснээс хойш олон зуун жил улиран одсон ч энэ нь судалгааны гол сэдэв хэвээр байна.

Аливаа үндэстний улс төрийн ертөнцийн тухай төсөөлөл, итгэл үнэмшил, үнэт зүйлс, өөрийн улс төрийн систем, төр засагтаа хандах чиг баримжаануудын нийлбэр цогц гэж улс төрийн соёлыг хураангуйлан томъёолж болно. Монгол үндэстэн түүхийн зуун зууны нугачааг туулан өөрийн гэсэн төр засгийг бий

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
НИЙГМИЙН УХААНЫ САЛБАР

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ
ᠰᠢᠨᠵᠢᠯᠡᠬᠡ ᠤᠬᠠᠠᠨ ᠰᠤᠷᠭᠤᠯᠢ
ᠨᠢᠶᠭᠮᠢᠶᠢᠨ ᠤᠬᠠᠠᠨ ᠰᠠᠯᠪᠠᠷ

ПОЛИТОЛОГИ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№16 (489)



МУИС ПРЕСС ХЭВЛЭЛИЙН ГАЗАР

УЛС ТӨРЧИЙН ИМИЖЭЭ БҮРДҮҮЛЭХ ТЕХНОЛОГИ
БА УЛС ТӨРИЙН МЭРГЭЖЛИЙН ОНЦЛОГ

У.БАТЦЭРЭН

Доктор(Ph.D)

Удирдлагын Академи. Төрийн алба, удирдлагын сургууль.

Сургалтын менежер,

Шинжлэх Ухааны Академи. Философийн хүрээлэн.

Улс төр, эрх зүйн салбар. Эрдэм шинжилгээний дэд ажилтан

Ү.БАТБАЯР

Удирдлагын академи. Удирдахуйн ухааны сургууль.

Магистрант

Түлхүүр үгс:Имиж, улс төрч, нэр дэвшигч, сонгуулийн кампани, улс төрийн имижейкер, улс төрийн зөвлөх, улс төрийн технологич, улс төрийн соёл, улс төрийн ёс суртахуун.

Товч утга: Улс төрчийнимижбүрдүүлэх технологи нь тусгай мэргэжлийн улс төрийн ажилтан нарийн хийдэг ажил билээ. Өөрөөр хэлбэл, улс төрийн имижейкер тэргүүтэй улс төрийн мэргэжилтэн нар сонгуульд нэр дэвшигч болон улс төрч нарийн имижийг цаг ямагт бүрдүүлж байдаг. Улс төрийн имижейкер нь улс төрийн субьектийн имижийг бүрдүүлэхдээ улс төрчийн хувийн соёл, зан чанар, ёс суртахуун зэрэг хүчин зүйлийг судлан ажилдаг.

Улс төрчийн соёл, ёс суртахуун зэргээс түүний улс төрийн имиж бүрэлдэх үйл явц ихээхэн шалтгаалдаг. Энэхүү өгүүллээ ШУА-ийн ФХ-ийн Улс төр, эрх зүйн салбарын суурь судалгааны төслийн хүрээнд онцлон онол, практик талаас нь судлан үзэхийг зорив.

Улс төрчийн имижийг бүрдүүлэхдээ түүнд тохирсон зохистой арга, технологийг бий болгох нь улс төрийн мэргэжилтэн нарын хийж хэрэгжүүлэх үндсэн ажил юм. Өөрөөр хэлбэл, улс төрчийн имиж бүрдүүлэх үйл явц нь олон шатлалт бүхий нарийн нийлмэл, төвөгтэй үйл явц юм. 2008 оноос хойших Улсын Их Хурал болон Ерөнхийлөгчийн сонгуулиудад дүн шинжилгээ хийж үзэхэд нэр дэвшигчдийн имижийг бүрдүүлэхдээ улс төрийн мэргэжилтэн нар дараах үндсэн хоёр алхмыг хийж хэрэгжүүлж байна. Үүнд: Нэгдүгээрт: сонгуулийн кампанит ажлын үед олон нийтийн санаа бодол, өрсөлдөгч нам, нэр дэвшигчийг тандан судлах; цуглуулсан мэдээлэлд боловсруулалт хийж, сонгуульд өрсөлдөж



ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛ

Study on Pressing Issues Faced by Neighboring Countries in the Contemporary World

*the 14th China-Mongolia-Russia International Seminar
August 15-20, 2019*



目 录

Encountered Policies and Challenges to the Developing the Economic Corridor in the Three Countries	CHULUUNBAATAR Geleppil 1
On the problem of basic concepts of justice in the light of the theoretical discourse of trans-civilization borrowing of different cultures and traditions	GAN-ULZII Ch. Batyn11
Structural Changes in the population and Domestic Migration of the 'Kazakh ethnics' in the Western Aimags in Mongolia	PUREVSUREN Byambakhishig 13
The problems of ageing population in neighboring countries Russia, Mongolia and China	TSETSENBILEG Tseven 26
the modern Patterns of political cultures in Mongolia:	
At the intersection of East and West	BAASANSUREN Dugarja29
analytical review on the State of Democracy in the modern world order	KHATANBOLD Oidov 32
ANALYSIS OF THE FACTORS IMPACTING ON CONSTRUCTION MATERIALS INDUSTRY	UNDARMAA Z.,42
Increasing employee satisfaction through the attitude of the organizational culture	NASANDELGER 48
Analysis on the Mongolia's Sustainable Development Vision (SDV-2030) and its challenges and opportunities in Mongolia	KHATANBOLD Oidov 59
The formation of the Political culture for the Mongolian youth	KHISHIGDAVAA Ayush 67
ETHICAL ISSUES OF ADVOCATE	DOLGORSUREN Mendbayar 79
К истории «Нового Шелкового пути»: борьба геополитических проекций	Базаров Борис Ванданович90
ЖЕЛЕЗНОДОРОЖНОЕ СТРОИТЕЛЬСТВО КАК ФАКТОР ФОРМИРОВАНИЯ ТРАНСГРАНИЧНОГО ЭКОНОМИЧЕСКОГО ПРОСТРАНСТВА РОССИЯ – МОНГОЛИЯ	Plekhanova Anna Maksimovna 98
Гуманитарное сотрудничество России, Монголии, Китая в современный период	Innokentii G. Aktamov 105
Traditions of Chinese state craft and the Great Silk Road(Based on the materials of the chronicle "Jin shu" and the treatise of Fu Xuan "Fu-zi")	Tsyrenov Chingis Tsybikdorzhievich 113
The socio-political processes in the transboundary area of Russia and Mongolia in the context of globalization and regionalization	Zhalsanova Valentina Gurozhapovna 120
SUBURBAN DEVELOPMENT IN THE POST-SOCIALIST COUNTRIES (CASE OF ULAN-UDE AND ULAANBAATAR)	Anatoliy S. Breslavsky 126
ВОЗМОЖНОСТИ ГИС-ПРОГРАММ В ФОРМИРОВАНИИ ГЕОГРАФИЧЕСКИХ КОМПЕТЕНЦИЙ	A.D. Gombozhapov 139
Монгольский мир в зоне экономического коридора Китая, Монголии и России	Badaraev Damdin 143
Community of Human Destiny Needs Neighbouring Countries to Practice Together	Tsgiltu 149
人类命运共同体需要相邻国家一同践行	朝克吉勒图 149
人类命运共同体视域下新时代理想人格的基本特质	张瑞涛 153
一带一路是联结中蒙俄经济发展的纽带和桥梁	宝音满达胡 163
破解“三大治理难题”的中国智慧: 习近平新时代治国理政内容论纲	张业蕾 夏从亚 167
新时代党的基层组织建设的“变”与“不变”	刘雨晴 张荣华 173
论文化相对主义视阈下发展中国家的国际文化策略	吕前昌 179
论马克思主义的“三大解放”理论	李友仕 高远 183
改变中国近代屡遭侵略历史命运的大决战	宋海徽 189
全球信息化对党内法规文化建设的影响及对策分析	宗 芳 198
生态文明建设与政治发展	赵国营 203

ETHICAL ISSUES OF ADVOCATE

DOLGORSUREN Mendbayar (Ph.D candidate)

Academic researcher from the Department of Political Sciences & Legal Studies,
Institute of Philosophy from Academy of Sciences
angelnice999888@gmail.com
(Mongolia)

Abstract: The report aims to investigate the lawyer's practice, the current state of ethics of lawyers, and study international practice of ethics of attorneys, create and enforce the standards of attorney's services, improve the ethical and professional accountability of lawyers, and propose to improve the legal environment for accountability.

Key word: *Legal values, lawyer's professional ethics, communication culture and friendly relations*

The current state ethics of attorneys

Ethics of attorneys is a component of ethics of lawyers, as well as specific requirements set for "Code of Conduct of Mongolian Advocates" which define the nature of advocacy activities.

Table 1: Demonstrating the laws and regulations governing the ethics of lawyers:

Organization	Year /first rule approved/	Current laws and regulations
Advocacy organization	In Article 13.3.1 of the 1994 Advocacy Law, Article 12.3.1 of the Advocacy Law states that the lawyer should abide by the Code of Ethics of Courts and the disciplinary measures imposed on those laws in violation of the Code of Ethics In 1994 and 2002, the Code of Ethics of Attorney was adopted.	The Constitution of Mongolia, the Law on Legal Status of Lawyers and other relevant laws of Mongolia, the International Treaty, Professional charter of a lawyer

As seen from the table, the Code of Ethics of Attorneys was adopted in accordance with the Advocacy Laws in 1994 and 2002 and the Code of Professional Ethics of Attorneys was adopted and the Association of Mongolian Advocates was established. At present, ethics of lawyers is governed by the Law on Legal Status of Mongolia and the Law on Special Procedures of Lawyers, and is governed by the Code of Ethics of Attorney. Complaint on ethical issues related to lawyers and to conducting ethical obligations within a professional framework are critical issue.

In Supreme Court of Criminal Affairs, some case has not been solved because of lack of professional and ethical knowledge of the lawyers. There are some advocates /attorneys/ lacking of professional knowledge and so that of results criminal offence, excess money and other problems.



**МОНГОЛ
АРДЫН НАМ**

ЁС ЗҮЙ

**ӨНӨӨГИЙН МОНГОЛЫН НИЙГМИЙН УЛС ТӨРИЙН ХАРИУЦЛАГА,
ЁС ЗҮЙН ЗАНГИЛАА АСУУДЛУУД**

эрдэм шинжилгээний бага хурал

“МОНГОЛЧУУДЫН ЁС СУРТАХУУН” – ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСЛЭГЭЭ

Академич, МУИС–ийн эмерит профессор С.НАРАНГЭРЭЛ

I. НЭР ТОМЪЁО

хөтөлбөр, ёс суртахуун, ёс суртахуун заяагдмал, ёс суртахууны өгөгдөл, ёс суртахууны ялзрал, ёс зүй

ХӨТӨЛБӨР	үйл ажиллагааны агуулга ба тодорхой төлөвлөлт.
ЁС СУРТАХУУН	аливаа хүмүүний эрхэм нандин зан чанарын цогц.
ЁС СУРТАХУУН ЗАЯАГДМАЛ	ёс суртахууны өгөгдөл ямар ч хүмүүнд үүсмэл бус түүний төрмөл чанар.
ЁС СУРТАХУУНЫ ӨГӨГДӨЛ	шударга, эрэмгий зориг, ичгүүр, хариуцлага, жудаг, нинжин сэтгэл, нэр төр, үнэн, итгэл, тэсвэр тэвчээр, хайр, хүндлэл, эв эе, өгөөмөр, хамтач, эс шуналдах, эс хонзогнох, эелдэг, найрсаг зан, урвашгүй чанар.
ЁС СУРТАХУУНЫ ЯЛЗРАЛ	шударга бус, аймхай хулчгар, ичгүүр сонжуургүй, хариуцлагагүй, хүний мөсгүй, харгис хэрцгий, нэр төрөө барах, худал хуурмаг, заль мэх, гол гаргах, хэлсэн амандаа хүрэхгүй байх, тэвчээргүй, хайрлах сэтгэлгүй, ах захгүй, талцал хуваагдал хагарал, өглөгч тусч бус, нийтэч бус, шунал, хонзогнол, атаархал, хүйтэн ялдам бус зан, урван тэрслэлт зэрэг шинжүүдийн хурц илрэл.
ЁС ЗҮЙ	тодорхой ажил мэргэжлийн ёс суртахууны цогц.



II. АЛДААГАА ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ НЬ

Монголчуудын гайхамшигт өвөг дээдэс монгол хүний ёс суртахууныг алдууралгүй байлгах, ёс суртахууны ялзралыг газар авахуулалгүй, таслан зогсоож байх талаар агуу ухааныг буй болгон уламжлуулж ирсэн байна. Дэлхийд дахин буй болоогүй хамгийн том эзэнт улс гүрнийг цогцлоож, манай гариг дээр 140 жилийн Монголын амар амгаланг тогтоосон нь нутаг дэвсгэр, баялаг бус харин монголчуудын ёс суртахууны, оюун санааны татах хүч байсан гэдгийг ухаарах цаг болжээ. Чингис хаан, түүнийг шууд залгамжлагчид байлдан дагуулалт, аян дайнаар бус ёс суртахууныхаа татах хүчээр дэлхийн эзэнт гүрнийг буй болгосон ажээ.

Харамсалтай нь уламжлан үргэлжлүүлэх ёстой байсан эл их ухааныг их хаан суурийн төлөө өөр хоорондоо тэмцэлдэж, Чингис хааны хичээнгүйлэн захисан эе эвээ бусниулсны улмаас талцал, хагарал, хуваагдал буй болгосноос хэд хэдэн харийн гүрний хараат болсоор байгаад орхигдуулан мартах болсон алдаагаа хүлээн зөвшөөрөх ёстой болсон байна.

ШУДАРГА ЁСЫГ ТӨЛӨВШҮҮЛЭХЭД ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

Ёс зүйн суурь ойлголт болох шударга ёсыг нийгэмд төлөвшүүлэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн гүйцэтгэж буй үүрэг, ач холбогдол эрс нэмэгдсэнийг судлах шаардлага өнөөдөр зүй ёсоор тавигдаж байна.

Өнөөдөр Монголд 500 шахам хэвлэл мэдээллийн хэрэгсэл үйл ажиллагаа явуулж, 3 сая иргэд маань түүгээр дамжуулж үзэл бодлоо илэрхийлж, үг хэлээ олж байна. Тэдгээрээс 300 шахам нь орон даяар нэвтрүүлгээ цацдагаас зөвхөн Улаанбаатар хотод телевизийн 70 гаруй суваг ажиллаж байна.

Энэ бол монголчууд бидний оюун санааны амьдралд гарсан асар том боломж, давуу тал юм. Шинээр үүсч хөгжсөн мэдээллийн технологийн ачаар манай орны иргэд хот, хөдөө ялгаагүй хаана ч байсан орон зай, цаг хугацаанаас үл хамаарсан харилцааны хэв маягт шилжиж байна. Монголчуудын чөлөөт сэтгэлгээг задалж, олон ургальч үзэл, ил тод байдлыг хангасан энэ түүхэн үйл явц нэлээд бэрхшээлтэй 4 үе шатыг дамжин өрнөж өнөөдөртэй золгожээ гэж дүгнэж болохоор байна.

1. ТӨРИЙН МЭДЭЭЛЛИЙН НОЁРХЛЫН ҮЕ

Энэ нь 1990-1998 оныг хамарч байна. Төр төвтэй улс төрийн тогтолцоо бүрдэж бэхэжсэнтэй холбоотойгоор төр, засгийн төв хэвлэлийн нийтлэлийн бодлого энэ цаг үед ноёрхож, эрх зүйт төрийг дээдэлсэн бүхнийг шударга ёсонд хамруулан ойлгохыг номлож байлаа. Төр, засгийн төв хэвлэл “Ардын эрх”, “Засгийн газрын мэдээ” сонины мэдээллийн агуулгад зах зээлийн харилцааг зохицуулсан шударга ёсны шинэ

*Ёс зүйн хорооны нарийн бичгийн дарга,
доктор/PhD/, профессор Д.БАТМӨНХ*



ойлголт давамгайлж эхэлснээр “нийтийн төлөө, хамт олныхоо төлөө” уламжлалт ойлголт “чи, би”-гээр солигдож өөрчлөгдсөн юм.

2. ШАР ХЭВЛЭЛИЙН НОЁРХЛЫН ҮЕ

1998-2008 оныг хамарна. Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээр хэвлэл мэдээлэлд тавих цензурыг халж, төрийн мэдлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл үгүй болов. Хувийн болон олон нийтийн статустай ХМХ олноор байгуулагдаж, эмх цэгцгүй хаос байдал дэлгэрч, мэдээллийн орон зайд шар хэвлэл ноёрхож эхэлжээ. Энэ үед хэвлэлийн эрх чөлөөг юу хүссэнээ нийтэлж, нэвтрүүлдэг эрх чөлөө хэмээн туйлшран ойлгож, нийгмийн сэтгэл зүй сайн, муугийн хоёр туйлд савлаж, сэтгэл хөөрөлд бүрэн автсан үе байлаа. ХМХ өөрөө шударга ёсны ойлголтод төөрч, цаг үеэ дагасан шинж давамгайлж иржээ. Тухайлбал, ерээд оны сүүл, 2000 оны эхээр гал гаргадаг Өнөрөө, бурхнаар бөөлждөг бүсгүй, алмастай уулзсан сэтгүүлч

ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ БА ОЛОН НИЙТИЙН САНАА БОДОЛ

Б.Пүрэвсүрэн

ШУА-ийн Философийн
хүрээлэнгийн захирал, философийн
ухааны доктор, дэд профессор



Монголын нийгэмд эдүгээ учирч буй оюун санааны ертөнцийн томоохон өөрчлөлт шинэчлэлийн тэргүүн эгнээнд ёс суртахууны өөрчлөлт хамгийн чухал байр суурь эзэлж байгаа талаар олонтоо өгүүлэх болсон бөгөөд уг асуудалд чухам яагаад бидний үнэт зүйлсэд зохистой, зохисгүй элдэв өөрчлөлт гарах болсон талаар цаашид ч цар хүрээтэй судалгаа үгүйлэгдэж буйг үгүйсгэх аргагүй юм.

Бодит байдал дээр зохисгүй бүхэн ёс суртахуунгүй байдлаас бодитой болон эхэлж, зохисгүй бүхэн ёс суртахууны доройтлоос үүдэн бодитой болж буй нийгэмд бид амьдарч буйг олонтоо өгүүлэх болжээ. Энэ бүхэн нэг талаар монголчууд шилжилтийн нийгмийн үед зүй ёсоор тулгарч буй хотжих явц, дотоодын шилжих хөдөлгөөний эрчимтэй урсгал, хөдөлмөрийн хуваарийн өөрчлөлт зэрэг нийгэм-соёлын динамик өөрчлөлтийг дагасан тодорхой шалтгааны улмаас монголчуудын үнэт зүйлсэд гарсан өөрчлөлт ёс

Ё.Ундрал

Философийн хүрээлэнгийн
Социологи, нийгмийн сэтгэл зүйн
салбарын ЭШДЭА, магистр

**Бодит байдал дээр
зохисгүй бүхэн ёс
суртахуунгүй байдлаас
бодитой болон эхэлж,
зохисгүй бүхэн ёс
суртахууны доройтлоос
үүдэн бодитой болж буй
нийгэмд бид амьдарч буйг
олонтоо өгүүлэх болжээ.**

суртахууны өөрчлөлтийг нэгэн адил араасаа дагуулсан байна.

Монголоо хайсан монгол гэдэг шиг монголчууд өөрсдийн үнэт зүйлсийн эрэлд гарсан явдал нь нэртэй социологич Э.Дюркгеймийн хэрэглэсэн нийгмийн аноми байдлаас үүдэлтэй хэмээн үзэж болох биз ээ. Иймд монголчууд ёс суртахууны ямар эерэг хэм хэмжээ, үнэт зүйлсэд хөтлөгдөх, нөгөө талаар хөтлүүлж болох, тэрхүү үнэт зүйлс нь ямар уламжлалд суурилсан байж болох талаар эрдэмтэн судлаачдын хамтын үг санал дутагдаж байгааг онцлон тэмдэглэе.

Асуудлыг үнэлж дүгнэх, тодорхойлохын тулд тухайн агуулгыг илэрхийлэх тохиромжтой нэр томъёо олдтол хүлээхийн хэрэг байж болох ч зонхилох соёлоо дагаж, зохистой болон хэвшсэн байдлыг хэв болгон авч үзвэл үнэт зүйлс хэмээх үгийг нэгэнт хэрэглэн дассан ажгуу.

ᠮᠣᠩᠭᠣᠯᠢ ᠰᠠᠭᠤ ᠶᠡᠳᠡᠮᠲᠦᠳᠦᠨ ᠬᠣᠯᠪᠤᠭ



БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ



ШУТСан
ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН САН



Монголын Залуу
Эрдэмтдийн Холбоо



Нийгмийн Шинжлэх
Уханы Залуу
Эрдэмтдийн Холбоо

ХҮРЭЛТОГООТ-2018 ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРЛЫН ЭМХЭТГЭЛ

Улаанбаатар
2018

Агуулга

Мэндчилгээ	4
Сарьдагийн хийдийн малтлагаар илэрсэн язгуурын таван бурхны дүрслэлд хийсэн дүн шинжилгээ.....	5
Чингисийн алтан ургийн угсаа залгамжилсан засаг ноёдын хувь заяаны асуудал	21
Археологийн дурсгалаас илэрсэн олдворт тулгуурлан монгол нохойн үүлдэрийг тодорхойлох нь	30
Монгол сүсэгтний өнөөгийн зураглал.....	39
Зурагт хуудас монголын соёлын чухал судлагдахуун болох нь.....	49
Эрх зүйн соёлын төлөвшлийн асуудал	58
Оюутны сурах үйл явцын метакогнитив мэдлэгт хийсэн дүн шинжилгээ	70
Оюутны мэргэжлийн ёс зүйн ойлголтыг тандах нь	80
МУ-ын ИДС, МБСБ төгсөгчид (2015/2016)-ийн бүрэн бус хөдөлмөр эрхлэлт, түүнд нөлөөлөгч хүчин зүйлс.....	89
Англи хэлний эерүүлсэн үг, утга зүйн ангилал.....	108
Дундад үеийн монгол хэлний цэг цэглэлийг судлах асуудалд	117
Цагдаагийн ахлагч бүрэлдэхүүний инновацийн чадавхийг үнэлэх хэрэгцээ, шаардлага	131
Тэмүжин, Бэгтэр хоёрын зөрчлийг нягталж авч үзэх нь	140
Болзошгүй гал түймрийн үед хүүхэдэйн театрт учирч болох эрсдэл түүнийг бууруулах арга зам	165
Баримтат гэрэл зураг дахь хүүхдийн эрхийн тухай асуудал хийгээд үзэгчдийн хэт дасал хариу үйлдэл	175
Шашны тухай З.Фрейдийн үзэл баримтлал, түүний онцлог	182
Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний төлөвлөлтийн арга зүйн асуудалд.....	195
Гурван улсын эдийн засгийн коридор хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн дээр Монгол улсын далайд гарах боломжийг өргөжүүлэх нь	203
Их сургуулиудыг үнэлэх асуудалд.....	218
Насанд хүрэгчдийн дундах зүрх судасны өвчний зарим эрсдэлт хүчин зүйлсийн үнэлгээ.....	227

Эрх зүйн соёлын төлөвшлийн асуудал

М.Долгорсүрэн

ШУА, Философийн хүрээлэн

Товч агуулга: Энэхүү өгүүлээр эрх зүйн соёлын үзэл баримтлал, эрх зүйн соёлын өнөөгийн төлөв байдал, өрнөдийн эрх зүйн нийтлэг соёлыг судалж, эрх зүйн соёл нь хууль тогтоомжид огт тусгагдаагүй зүйлийг гаргаж, эрх зүйн шинэ хэм хэмжээ бүрэлдэх, эрх зүйг бүтээх, хэрэглэх мэргэжлийн ур чадвар сайжирч, эрх зүйн шинэчлэл, эрх зүйн хэм хэмжээнд эерэгээр хандаж, хууль тогтоомжийг мэдэж, хүндэлж, дагаж мөрдөх, шударга ёсыг тогтоох, иргэдэд эрх зүйн соёлыг төлөвшүүлэх талаар санал дэвшүүлэхийг зорьсон.

Abstract: The article examines the concept and current state of legal culture and the study of common Western legal culture. Detecting some issues of the legal culture that has not been addressed in legislation. New legal norms, development and utilization of professional skills are important issues. The aim of this article is promoting positive attitudes and legal norms, recognizing and respecting laws, establishing justice, and promoting legal culture for citizens.

Түлхүүр үгс: Эрх зүйн боловсрол, эрх зүйн ухамсар, эрх зүйг бүтээх, хууль тогтоомжийг биелүүлэх, дагаж мөрдөх, эрх зүйн хөгжил

KEY WORDS: Legal education, legal awareness, law enforcement, enforcement, legal development

I. Эрх зүйн соёлын онолын үзэл баримтлал

Эрх зүйн соёл нь нийгмийн хөгжлийн явц дахь өөрчлөлтүүдийн үр дүнд аажмаар бүрэлдэн тогтнох нийгмийн ерөнхий соёлын нэг хэсэг мөн¹¹¹. Соёл судлалын үүднээс авч үзвэл төр болон эрх зүй нь газар тариалан эрхлэх, хот байгуулалт, уран зохиол, театр, шашин гэх мэт соёлын бусад хэлбэрүүдийн нэгэн адил соёлын тодорхой үзэгдэл мөн¹¹². Эрх зүйн соёлын талаар эрдэмтдийн тодорхойлолт, судалгааны агуулгын чиглэл ерөнхийдөө нэг чиглэл байгаа боловч үзэл баримтлалын хувьд өөр өөр тайлбарлаж байна. Тухайлбал, Ч.Нямсүрэн. “Эрх зүйн соёл гэж эрх зүйн бодит байдалд хамаарагдан оюун санааны болон эрхийн үнэт зүйлсийг агуулсан ерөнхий соёлын нэг хэлбэр мөн”. Доктор Н.Гантулга “Эрх зүйн соёлын түвшинг эрх зүйн ухамсараар хэмжих ба эрх зүйн онол шинжлэх ухааны хөгжил, хүн амын боловсролын түвшин болон эрх зүйг практик үйл ажиллагаанд хэрэгжүүлэх үйл явц зэрэг нь түүний түвшинг илэрхийлнэ”. Доктор Э.Авирмэд “Иргэд үйлчилж байгаа хууль тогтоомжийн талаар зохих мэдлэгтэй байх, нийгмийн гишүүдээс өөрсдийн зан байдал, үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн заалтын дагуу хэрэгжих, иргэд, албан тушаалтан эрх зүйн соёлын гол зарчмын үндсэн дээр ажиллаж байхыг эрхэмлэх гэх мэт элементээр илрэн гарна”. Доктор Д.Баярсайхан “Эрх зүйн соёл болон эрх зүйн үнэлэмж нь эрх зүйг мэдрэх, эрх зүйг ойлгох, эрх зүйг сэтгэн мэдэх, эрх зүйг даган биелүүлэх, эрх зүйг эзэмших, эрх зүйн итгэл үнэмшилтэй байх зэрэг тодорхой шалгуур бүхий үе

¹¹¹ Проблемы общей теории права и государства. /Под общ./ Ред. Академика РАН, д.ю.н., проф В.С.Нерсесянц, М., 2002, с.406

¹¹² В.С.Нерсесянц. Общая теория права и государства. М.2000, с.273



Монголын Хуульчдын
холбоо



ШУА-ын Философийн
хүрээлэн



МУИС-ийн Хууль зүйн
сургууль

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ЁС ЗҮЙ

(ТУЛГАМДСАН АСУУДАЛ)

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА
ХУРЛЫН ИЛТГЭЛИЙН ЭМХЭТГЭЛ

Улаанбаатар хот
2019 он

АГУУЛГА

Өмнөх үг	3
Нээлтийн үг	5

ҮНДСЭН ИЛТГЭЛ

Монголын хуульчийн ёс зүйн онол – практикийн зангилаа асуудалд Академич, МУИС-ийн Эмерит профессор С.Нарангэрэл.....	12
---	----

Монголын хуульчдын ёс зүйн нандин өв, уламжлал МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхмийн профессор, доктор (Ph.D), Х.Сэлэнгэ.....	31
--	----

Монголын хуульчдын ёс зүйн талаарх олон нийтийн үнэлэмж ШУА-ийн Философийн хүрээлэнгийн ЭША, доктор (Ph.D), профессор Д.Батмөнх.....	48
--	----

Монголын хуульчдын ёс зүйн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал МУИС-ийн Хууль зүйн сургуулийн профессор, хууль зүйн доктор (Ph.D) О.Мөнхсайхан	58
--	----

ХАВСРАЛТ ИЛТГЭЛ

Нийгмийн ёс суртахуун институци болох нь Философийн ухааны доктор (Ph.D), профессор, ОТИС-ийн багш Б.Галиндэв.....	76
--	----

Монголчуудын өндөр төрийн үзэл ёс суртахууны чухал хэмжүүр болох нь ОТИС-ийн багш, доктор (Ph.D), дэд профессор Г. Жаргалсайхан	89
--	----

Хуульчийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчийн ёс зүйн нийтлэг үндэслэл ДХИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Нийгмийн ухааны тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D), дэд проф. дэд хурандаа Ц.Батбаяр.....	102
--	-----

Төрийн улс төрийн албан хаагчийн ёс зүй: зохицуулалт, хяналт ШУА-ийн Философийн хүрээлэн, Улс төр, эрх зүйн салбарын ЭША, хууль зүйн магистр (LL.M) Ц.Баянмөнх	107
--	-----

Хуульчийн үйлчилгээний соёл ШУА-ийн Философийн хүрээлэн, Улс төр, эрх зүйн салбарын ЭШДЭА, хууль зүйн магистр (LL.M), хуульч, өмгөөлөгч М.Долгорсүрэн.....	116
Их салхин хөдөлбөл нижигнэнхэн хөдөлтүгэй (Номын шүүмж) Доктор (Sc.D), профессор С.Байгалсайхан.....	129
Хуралд хэлсэн үг.....	135

МОНГОЛЫН ХУУЛЬЧИЙН ЁС ЗҮЙН ОНОЛ-ПРАКТИКИЙН ЗАНГИЛАА АСУУДАЛД

Академич, МУИС-ийн Эмерит профессор С.Нарангэрэл

Үндсэн ухагдахуун

Хуульчийн ёс зүйн тухай шинжлэх ухааны үндэстэй мэдлэгийг буй болгоход ёс суртахуун, ёс зүй, зан суртахуун зэрэг нэр томъёоны агуулгыг зөв ухаарах шаардлагатай. Манай гаригийн суут сэтгэгчдийн нэг Күнз одоогоос 2500 жилийн өмнө хэрэв нэр буруу өгөгдөж, бодит байдалд нийцэхгүй байвал үг хэл, ажил хэрэгтэй зөрчилдөнө, ажил хэрэг бүтэхгүй бол дэг ёс хөгжихгүй, дэг ёс хөгжихгүй бол хууль цааз завхарна, хууль цааз завхарваас ард түмэн хөл толгойгоо алдана¹ гэсэн байдаг. Ёс суртахууны тухай асуудал нь дан ганц философийн тухай судлагдахуун бус олон шинжлэх ухааны уулзварт судлагдах хүмүүний мөн чанарын тухай ухаан юм².

Ёс суртахуун³ хэмээх нэр томъёо нь аливаа хүмүүний "ухамсар", "сэтгэл", "хүн чанар", "удамшил", "хүмүүжил", "итгэл үнэмшил", "сүсэг бишрэл", "хэм хэмжээ", "үнэлэмж", "зарчим" зэрэг олон янзын тодорхойлолттой боловч энэ нь хүмүүний сайн амин чанарын цогц юм. Сэтгэцийн хувьд эрүүл аливаа хүмүүний хувьд ёс суртахуун нь үүсмэл бус төрмөл бөгөөд одоогоос 2500 жилийн өмнө манай гаригийн бас нэгэн агуу их сэтгэгч Аристотель "аль ч хүнд зайлшгүй байхаар заяагдсан"⁴, тэгэхдээ ижил биш байдаг гэсэн санаа дэвшүүлсэн нь квантын физик, тархи судлалын шинжлэх ухааны орчин үеийн ололтоор батлагдаж байна. Монголын ард түмний зүйр үгэнд "сайн явах санааных" хэмээн ёс суртахууныг олдмол бус төрмөл болохыг тусган

¹ Күнз Шүүмжлэл, өгүүлэл., Улаанбаатар., 2013, 123 дахь талыг үзнэ үү.

² Ёс суртахууны талаар монгол төрийн хууль зүйн бодлогыг тодорхойлоход нэгэн үе онцгой үүрэг гүйцэтгэж явсан нэгэн эрхэм "Бид нарын хүний ёс, ёс суртахуун, хүн чанар гээд яриад байгаа зүйл чинь юу юм бэ? Хүн бүхэн ёс суртахуунаар бусдыг хэмжих дуртай мөртлөө хэмжээд байгаа зүйлээ эргэцүүлж бодож үздэггүй шүү дээ. Энэ яриад байгаа ойлголт их дотно, эерэг үнэн юм шиг сонсогддог ч гэсэн мөн чанарыг нь илүү ухаалгаар задлаад үзэхээр дундад зуунаас юм уу, урд талаас уламжилж ирсэн амьдралын зарчим л байдаг байхгүй юу. Гэтэл тэр амьдралын хэв маяг нь энд өөрчлөгдсөн байхад тэр зарчмаараа бид нарыг тодорхойлоод яваад байх нь хэр оновчтой вэ? Одоо эргэцүүлж харах ёстой болчихоод байна. Ингээд харахаар шинэ зарчмуудын тухай ярьж байна. Бид нар ёс суртахуун, хүн чанарын тухай ярьдаг зүйлээ авах гээхийн ухаанаар цэгцлэх ёстой юм байна" гэж бичжээ. – Үз. Хууль зүйн сайд Х. Тэмүүжин. Ярилцлага., "Үндэсний шуудан" сонин, 2012.12.17. №295 (1629), 12 дахь нүүрт.

³ Ёс суртахуун гэсэн нэр томъёог латин хэлнээ morality; англи хэлнээ moral; орос хэлнээ мораль хэмээн хөрвүүлнэ.

⁴ Аристотель Улс төр., дөрөв дэх хэвлэл., орчуулсан Б.Даш-Ёндон., Улаанбаатар., 2015, 48 дахь тал.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ЁС ЗҮЙН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН ҮНЭЛЭМЖ

ШУА-ийн Философийн хүрээлэнгийн ЭША,
доктор (Ph.D), профессор Д.Батмөнх

Ёс суртахууны үнэлэмжийн өөрчлөлтийг тандах судалгааны ажил 1990 оноос хойш өнөөг хүртэл бараг хийгдээгүй явж иржээ. Харин ШУА-ийн Философийн хүрээлэнгээс 2010 онд “Монголчуудын зан суртахууны төлөвшил, түүнд нөлөөлж буй нийгмийн хүчин зүйлс” экспертийн судалгаа явуулсан нь олон нийтийн анхаарлыг татсан нийгмийн хурц асуудлыг ил гаргаж тавьсан юм. Энэ бол монголчууд бидний үнэт зүйлс, итгэл үнэмшил үндсээрээ өөрчлөгдөж, нийгмийн бүх давхарга ёс суртахууны хямралд өртсөнийг анх удаа дэлгэн харуулсан явдал байв. Түүнээс 7 жилийн дараа буюу 2017 оноос өнөөдрийг хүртэл Философийн хүрээлэнгийн судалгааны баг “Монголчуудын ёс суртахуун – эрх зүйн хөгжлийг хангах үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагыг иж бүрэн тодорхойлох нь” сэдэвт суурь судалгааны төслийг /төслийн удирдагч академич С.Нарангэрэл/ гурав дахь жилдээ хэрэгжүүлж байгаа аж. Эхний үр дүн ч гарч байна. Энэ удаа **монголын хуульчдын ёс зүйн талаарх олон нийтийн үнэлэмж хэрхэн өөрчлөгдөж буйг** мэдээллийн хэрэгслийн нийтлэл, нэвтрүүлэгт дүн шинжилгээ хийж бичсэн илтгэлийг Та бүхэнд тавьж хэлэлцүүлье.

Монголын хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хороо, Шүүхийн ёс зүйн хороо хамтран **“Хуульчийн ёс зүй ба хариуцлага”** сэдэвт хэлэлцүүлгийг яг нэг жилийн өмнө /2018.04.11/ зохион байгуулж билээ. 2014-2017 оны хооронд Монголын хуульчдын холбоонд 933 хуульчтай холбоотой 791 гомдол, мэдээлэл ирсэний 80.5 хувь нь өмгөөлөгч, 17.4 хувь нь шүүгч, 2.1 хувь нь прокурорт хамаарсан өргөдөл байжээ. Гэхдээ дээрх 933 хуульчаас зөвхөн 52 хуульчид л холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд хариуцлага хүлээлгэжээ. Тэдгээр 52 хуульч бүгд өмгөөлөгч байсан бөгөөд шүүгч, прокурорт хариуцлага хүлээлгэсэн тохиолдол гараагүй хэмээн өнгөрсөн жилийн өдийд хэд хэдэн судлаач онцолж дурдсаныг нэн тод санаж байна.

Гэтэл өнөөдөр, мөнөөх 52 өмгөөлөгчийн ёс зүйн зөрчил нь ганц жилийн дотор монголын хуульчдын алдаа дутагдал болон хувирч, тэдний нэр хүнд олон нийтийн дунд шалдаа унасан тухай хаа сайгүй шүүмжлэн чичлэх болжээ. **Хуульчдын нэр төр, алдар хүнд ийнхүү алга урвуулах төдийд унаж, мэргэжлийн ёс зүйн доройтолд орсон явдлын учир шалтгаан юунд байна. Олон түмэн яагаад ингэж дүгнэх болов?**

ТӨРИЙН УЛС ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙ: ЗОХИЦУУЛАЛТ, ХЯНАЛТ

ШУА-ийн Философийн хүрээлэн, Улс төр, эрх зүйн салбарын ЭША,
хууль зүйн магистр (LL.M) Ц.Баянмөнх

Товч агуулга: Монгол төрд ёс зүйн үүрэг улам өсөн нэмэгдэж байна. Төрийн албаны ёс зүйн төлөвшилд албан хаагчид нь ёс зүйн хэм хэмжээг сахидаг байх нь чухал. Иргэд төрд тэднийг төлөөлж буй буюу төрийн улс төрийн албан тушаалтны ёс зүйд анхаарч илүү хариуцлагатай алба хашиж буй бол илүү ёс зүйн шаардлага нэхэх болсон. Иймд төрийн албан хаагчид ажил үүргээ гүйцэтгэхдээ мөрдөж буй ёс суртахууны зарчим, хэм хэмжээ, түүнд тавигдаж буй хяналтад дүн шинжилгээ хийж, боловсронгуй болгох асуудал ихээхэн ач холбогдолтой. Төрийн албанд ёс зүйн дүрэм, журам мөрдүүлэх нь албан хаагчийн ёс суртахууны зохицуулалтын гол арга мөн юм. Төрийн жинхэнэ албан хаагчийн, түүн дотор төрийн тусгай албанд мөрдөх ёс зүйн хэм хэмжээний дүрэм журмууд илүү тодорхой, хэм хэмжээнүүд нь нарийн зохицуулагдсан байна. Сонгогддог болон уг сонгуулийн үр дүнд томилолтын журмаар ажиллах төрийн улс төрийн албан хаагчдын ёс зүйн зохицуулалт, хяналтыг судлан улам боловсронгуй болгох шаардлагатай байна.

Түлхүүр үгс: ёс зүй, ёс суртахуун, төрийн албан хаагчийн ёс зүй, төрийн улс төрийн албан хаагчийн ёс зүй, ёс зүйн зохицуулалт, хэм хэмжээ, хяналт.

Үндсэн хуулинд тунхагласан хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм байгуулахад нийгмийн ёс суртахууны төлөвшлийн асуудал чухал билээ. Хоёр мянга гаруй жилийн төрт ёсны түүхтэй хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлоохыг зорьж буй Монгол төрийг удирдахад ёс зүйн үүрэг улам бүр өсөн нэмэгдэж байна.

Сүүлийн жилүүдэд нийгмийн сэтгэл зүйд гутранги үзэл газар авч байгааг судлаачид тэмдэглэсэн бөгөөд иргэд итгэл хүлээлгэсэн төрийн удирдлага, улс төрчдөд итгэл алдрах болж үүний уршгаар иргэдийн ирээдүйд итгэх итгэл суларч, өөрт байгаа боломжийг үгүйсгэх, бусдын амжилтыг эс зөвшөөрөх, эрх мэдлийн төлөө улайрч зорилгодоо хүрэхийн тулд хүнлэг бус арга хэрэглэхээс ч буцаагүй зэрэг олон сөрөг тал бий боллоо. Нийгмийн итгэлийг бэхжүүлэхэд төрийн өндөр албан тушаалтнууд, төрийн албан хаагчдын болон мэргэжлийн ёс суртахууны ухамсарыг дээшлүүлэх явдал чухал болж байна.

ХУУЛЬЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛ

ШУА-ийн Философийн хүрээлэн, Улс төр, эрх зүйн салбарын ЭШДЭА,
хууль зүйн магистр (LL.M), хуульч, өмгөөлөгч М.Долгорсүрэн

Товч агуулга: Энэхүү илтгэлээр соёлын онолын үзэл баримтлал, эрх зүйт төрийн үйлчилгээний соёлын шинж, хуульч мэргэжлийн ёс зүй, хуульчийн үйлчилгээний соёлын өнөөгийн төлөв байдлыг судалж, хуульчийн үйлчилгээний соёлын стандартыг бий болгож, мөрдүүлж, нэвтрүүлэн ажиллах, хуульчийн орчин үеийн шинэ үнэт зүйлийг төгөлдөржүүлэх, үйлчилгээний нийгмийг төлөвшүүлэх талаар санал дэвшүүлэхийг зорьсон.

Түлхүүр үг: Хуульчийн үнэт зүйл, хуульч мэргэжлийн ёс зүй, харилцааны соёл, найрсаг харилцаа

I. Соёлын онолын үзэл баримтлал

Соёл гэж юу вэ?. Соёл гэдэг ойлголт өргөн утгатай. Зарим хүмүүс хүнтэй зөв боловсон харьцдаг, өнгө үзэмжтэй хувцас өмссөн хүнийг соёлтой хүн гэж ойлгодог бол энэ нь өрөөсгөл ойлголт юм. Соёл гэдэг нь түүхэн цаг хугацааны туршид уламжлагдаж ирсэн итгэл үнэмшил, зан үйл, бэлгэ тэмдэг болон эрхэмлэн дээдлэх зүйлсийн тухай ойлголт юм. Соёл нь улс орон, үндэс угсаа, арьсны өнгө, шашин шүтлэгт тулгуурласан байж болно. Соёл нь олон жилийн туршид хөгжсөөр ирсэн ямар нэгэн тодорхой байгууллагын үйл ажиллагаанд үндэслэн бий болсон байж болно. Ямарваа мэргэжил болон мэргэшлээр ажилладаг тодорхой бүлэг хүмүүс ямар оронд байгаагаасаа үл шалтгаалан өөрийн гэсэн онцлог соёлыг бий болгох хандлагатай байдаг¹⁵¹.

Соёлын тухай анхны тодорхойлолтыг Английн угсаатны зүйч Эдуард Бернетт Тайлор (1832-1917) анх 1871 онд өгсөн ба тэрээр соёлыг нийгмийн гишүүн болох хүнд байх мэдлэг, урлаг, ёс суртахуун, эрх, зан заншил болон бусад онцлогуудын нийлбэр. Монгол Улсад 1998 онд хэвлэгдсэн "Соёл судлалын үндэс" гарын авлагад "Соёл бол хүмүүний хүмүүнлэг чанар илрэн хэрэгжих түүхэн тасралтгүй үйл явц, түүний үр дүн мөн"¹⁵² гэсэн бол доктор, профессор Ц.Гомбосүрэн өөрийн диссертацидаа "Соёл бол байгалийн зүйлийг нийгмийн зүйл болгодог мөн нэгэнт бий болгосон нийгмийн зүйлийг улам бүр боловсронгуй болгодог зохистой арга

¹⁵¹ Төрийн албаны зөвлөл, УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо, Шихихутуг хууль зүйн дээд сургууль. "Төрийн албаны соёл: Шударга ёс, ил тод байдал, ёс зүй". олон улсын онол-практикийн бага хурал. УБ., 2010. 70 дахь тал

¹⁵² Т.Дорждагва, Н.Сарантуяа, Ж.Долгорсүрэн. Соёл судлалын үндэс. УБ., 1998. 65 дахь тал



- **Үндэсний хөтөлбөрийн төсөл**
- **Зөвлөмж**

“МОНГОЛЧУУДЫН ЁС СУРТАХУУН” – ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСЛЭГЭЭ

Академич, МУИС–ийн эмерит профессор С.НАРАНГЭРЭЛ

I. НЭР ТОМЪЁО

хөтөлбөр, ёс суртахуун, ёс суртахуун заяагдмал, ёс суртахууны өгөгдөл, ёс суртахууны ялзрал, ёс зүй

ХӨТӨЛБӨР үйл ажиллагааны агуулга ба тодорхой төлөвлөлт.

ЁС СУРТАХУУН аливаа хүмүүний эрхэм нандин зан чанарын цогц.

ЁС СУРТАХУУН ЗАЯАГДМАЛ ёс суртахууны өгөгдөл ямар ч хүмүүнд үүсмэл бус түүний төрмөл чанар.

ЁС СУРТАХУУНЫ ӨГӨГДӨЛ шударга, эрэмгий зориг, ичгүүр, хариуцлага, жудаг, нинжин сэтгэл, нэр төр, үнэн, итгэл, тэсвэр тэвчээр, хайр, хүндлэл, эв эе, өгөөмөр, хамтач, эс шуналдах, эс хонзогнох, эелдэг, найрсаг зан, урвашгүй чанар.

ЁС СУРТАХУУНЫ ЯЛЗРАЛ шударга бус, аймхай хулчгар, ичгүүр сонжуургүй, хариуцлагагүй, хүний мөсгүй, харгис хэрцгий, нэр төрөө барах, худал хуурмаг, заль мэх, гол гаргах, хэлсэн амандаа хүрэхгүй байх, тэвчээргүй, хайрлах сэтгэлгүй, ах захгүй, талцал хуваагдал хагарал, өглөгч тусч бус, нийтэч бус, шунал, хонзогнол, атаархал, хүйтэн ялдам бус зан, урван тэрслэлт зэрэг шинжүүдийн хурц илрэл.

ЁС ЗҮЙ тодорхой ажил мэргэжлийн ёс суртахууны цогц.



II. АЛДААГАА ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ НЬ

Монголчуудын гайхамшигт өвөг дээдэс монгол хүний ёс суртахууныг алдууралгүй байлгах, ёс суртахууны ялзалыг газар авахуулалгүй, таслан зогсоож байх талаар агуу ухааныг буй болгон уламжлуулж ирсэн байна. Дэлхийд дахин буй болоогүй хамгийн том эзэнт улс гүрнийг цогцлоож, манай гариг дээр 140 жилийн Монголын амар амгаланг тогтоосон нь нутаг дэвсгэр, баялаг бус харин монголчуудын ёс суртахууны, оюун санааны татах хүч байсан гэдгийг ухаарах цаг болжээ. Чингис хаан, түүнийг шууд залгамжлагчид байлдан дагуулалт, аян дайнаар бус ёс суртахууныхаа татах хүчээр дэлхийн эзэнт гүрнийг буй болгосон ажээ.

Харамсалтай нь уламжлан үргэлжлүүлэх ёстой байсан эл их ухааныг их хаан суурийн төлөө өөр хоорондоо тэмцэлдэж, Чингис хааны хичээнгүйлэн захисан эе эвээ бусниулсны улмаас талцал, хагарал, хуваагдал буй болгосноос хэд хэдэн харийн гүрний хараат болсоор байгаад орхигдуулан мартах болсон алдаагаа хүлээн зөвшөөрөх ёстой болсон байна.

V. ХӨТӨЛБӨРИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

“Монголчуудын ёс суртахуун” үндэсний хөтөлбөр нь гэр бүл, боловсрол, оюун санаа, эдийн засаг, төр засаг, хууль гэсэн нийгмийн амьдралын бүхий л хүрээг хамарна:

1. ГЭР БҮЛЭЭС ТӨРИЙН ЁС ЭХЭЛНЭ

Ёс суртахуунлаг хүмүүн төлөвших нэн чухал анхдагч орчин нь гэр бүл мөн. Үеэс үед уламжлагдан дамжиж ирсэн өвөг дээдсийн алтан сургааль, ёс суртахууны үнэт уламжлалыг хүүхэд багачуудад өвлүүлэх асуудлыг Монгол төрийн бодлогын төвшинд тавина. Үр хүүхдээ өвөг дээдэс ба үндэсний уламжлалынхаа үнэ цэнийг мэдэрдэг, амьдралд ухаалаг ханддаг, үнэнч шударга байдал, нэр төрөө эрхэмлэдэг, бусдыг хайрлан хамгаалж тусалдаг, анд найзаа зөв сонгож, дотно нөхөрлөдөг,

Сүдрын чцүлганд Чингис хаан монголчуудын дүнд хөвгүүн нь монголчууд эцгийнхээ сургаалийг дагадаггүй, дүү нь ахынхаа үгийг тоодоггүй, эр нь эхнэртээ итгэдэггүй, эхнэр нь эрийнхээ хэлснийг дагадаггүй, хадам нь бэрээ хайрладаггүй, бэр нь хадмаа ойшоодоггүй, багачүүл нь томчүүлынхаа сургамжийг хайхардаггүй явдал газар авсныг таслан зогсоосон гэж тэмдэглэн үлдээсэн байдаг.

бусдын итгэлийг даадаг, өгөөмөр сэтгэл гаргадаг, эгэл жирийн амьдралд дасан зохицдог, бусдад

ээлдэг найрсаг ханддаг, хэлсэн амандаа хүрч чаддаг, шунал, хорон муу санааг жигшдэг болгоход тогтвортой (салж сарниагүй) гэр бүл л онцгой үүрэг гүйцэтгэнэ. Хүүхдийн ёс суртахууны төлөвшилд эцэг эхийн хувийн үлгэр дууриалал онцгой чухал гэж үзнэ.

Орчин үеийн шинжлэх ухаан-техникийн зарим хэрэгсэл (телевиз, компьютер, гар утас зэрэг) эцэг эх ба үр хүүхдийн хооронд хөндийрөл буй болгож, үл ойлголцол, хүнийсгэл үүсэхэд хүргэж байгааг анхаарч, түүний сөрөг нөлөөллөөс сэрэмжлэхэд анхаарал хандуулах шаардлага үүссэн байна. Эцэг эхчүүд үр хүүхдүүддээ ёс суртахууны тухай үлгэр, домог, туульс, зүйр цэцэн үгс байнга ярьж өгч, утга учрыг нь тайлбарлан таниулж байх ёстой.

Гэр бүл цуцлалт, хүүхдийн болон гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан нөхцөлийг шинжлэх ухааны үндэстэй тогтоож, тэдгээрээс урьдчилан сэргийлэх асуудлыг Монгол төрийн бодлогын төвшинд авч үзнэ.

2. БОЛОВСРОЛ ЁС СУРТАХУУНЛАГ ХҮН БОЛГОХ ҮЙЛ ЯВЦ

Боловсрол бол элдэв мэдээллийн цуглуулга бус харин монголын эртний уламжлалын дагуу өвөг дээдсийнхээ агуу их ухаанаас суралцаж, түүнд суурилан амьдралаа тодорхойлж, цаашдынхаа хувь заяаныхаа зүг чиг, эрч хүчийг олж авах явдал мөн.

Бүх шатны сургуульд ёс суртахууны талаар заавал үзэх дараах хичээл, түүний хөтөлбөр, сурах бичгийг буй болгоно:

Сургуулийн өмнөх боловсролын шатанд “Ёс суртахууны А үсэг” хичээлийн хөтөлбөр, гарын авлага буй болгоно. Агуулга нь сайн хүн болох анхны мэдэгдэхүүн байна.

Сүргүүлийн өмнөх боловсролын шатанд “Ёс суртахууны А үсэг” хичээлийн хөтөлбөр, гарын авлага буй болгоно.

Ерөнхий боловсролын сургуульд:

Бага ангид “**Ёс суртахууны монгол цагаан толгой**” хичээлийн хөтөлбөр, сурах бичгийг буй болгоно. Агуулга нь ёс суртахууны талаарх монгол ардын зүйр цэцэн үг, үлгэр туульс, домог зэргээс бүрдэнэ.

Дунд ангид “**Ёс суртахууны агуулга**” хичээлийн хөтөлбөр, сурах бичгийг буй болгоно. Агуулга нь ёс суртахууны үндсэн шинжийн хүмүүжил олгоход чиглэгдэнэ.

Ахлах ангид “**Ёс зүйн үндэс**” хичээлийн

хөтөлбөр, сурах бичгийг буй болгоно. Агуулга нь мэргэжлийн ёс зүйн суурь хүмүүжил олгоход чиглэгдэнэ.

Их дээд сургуульд мэргэжлийнх нь чиглэлийн ёс зүйн хичээл, сурах бичгийг буй болгоно.

Ахисан түвшний боловсролын сургалтад мэргэжлийнхээс гадна шинжлэх ухааны ёс зүй, эрдэмтний ёс зүйн судлагдахууныг буй болгоно.


Бүх шатны сургуулийн багш нарын өдөр тутмын үйл ажиллагаанд багшийн ёс зүйг чанд сахиулахад анхаарна (Багшийн ёс зүйн дүрмийг шинэчилнэ).

3. ЁС СУРТАХУУНЫ ТӨЛӨВШИЛД АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙ НЭН ЧУХАЛ

Манай улсад мэргэжлийн ёс зүйн олон дүрэм бий. Тэдгээрийг дараах байдлаар ангилж болохоор байна:



Ёс зүй. 17



Ёс зүйн эдгээр дүрэмд судалгаа хийж үзэхэд мэргэжлийн ёс зүйн үндсэн шаардлагыг хангаагүй, ёс суртахууны нийтлэг эрхэм чанарыг орхигдуулсан, энд тэндээс хэсэг бусгаар хуулбарлаж хэлбэрдсэн байдал ажиглагдав. Монголын нийгэмд зайлшгүй шаардлагатай гэр бүлийн ёс зүй, бизнесийн ёс зүй, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн ёс зүй, эрдэмтний ёс зүй, спортын ёс зүй зэрэг олон ёс зүйн хийдэл гарсан байна. Энэ учраас ёс зүйн дүрмийг бүхэлд нь шинэтгэх, тэдгээрийг амьдралд хэрэгжүүлэх сайтар бодож боловсруулсан хөшүүргийг буй болгох шаардлагатай болжээ.

4. ЁС СУРТАХУУНД ОЮУНЫ ХҮРЭЭНИЙ АЧ ХОЛБОГДОЛ

4.1 Ёс суртахууны төлөвшил төрөлх хэлээс эхэлнэ

Төрөлх монгол хэл, бичиг үсгээ сайтар мэдэхгүй бол Монгол Улсын иргэд оюун ухааны үндэсний ой санамжгүй болох учраас төрийн бодлогын хэмжээнд авч үзнэ.

4.2 Ёс суртахуунд олон нийтийн мэдээллийн хэрэгслийн нөлөөлөл

Ёс суртахуунд туйлаас харш тухайлбал, садар самуун, хүчирхийллийг сурталчилсан, гүтгэлэг тараасан, үндэстэн ястныг хооронд нь үзэн ядан дайсагнуулсан мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тараан түгээхийг хориглох, цагдалт (цензур) нэн даруй тогтоох шаардлагатай. Ингэх эрх зүйн үндэс нь Монгол Улс 1997 онд нэгдэн орсон Утга зохиол, урлагийн бүтээлийг хамгаалах тухай Бернийн конвенцид “Энэхүү конвенцийн дагуу эрх бүхий байгууллага уг эрхийг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн бол аливаа бүтээлийг тараах, тоглох, үзүүлэхэд хууль тогтоомжоор буюу журмаар хяналт тавих, эсхүл хориглоход Холбооны гишүүн аль ч улсын Засгийн газрын эрхийг ямар нэгэн байдлаар хөндөхгүй” гэж заасан явдал юм.

4.3 Ёс суртахуун ба утга зохиол, урлаг

Манай улсын урлаг, соёлын төлөөлөгчид мөнгө олох гэж үхэн хатан зүтгэх болсноор ёс суртахууныг эрхэмлэн дээдлэх бус гагцхүү ашиг олох чиг хандлага нэгэнт тогтсоныг засаж залруулах шаардлагатай болжээ. Ёс суртахууны холбогдолтой уран зохиол, яруу найраг, дуу хөгжим, кино, жүжиг, дүрслэх урлагийн бүтээл,

телевизийн нэвтрүүлэг туурвихад онцгой анхаарч, сайн бүтээлийг төрөөс санхүүжүүлнэ. Монгол ардын ёс суртахууны үлгэр туульс, зүйр цэцэн үгийг эмхтгэл гаргаж нийтийн хүртээл болгоно. Урьд нь хэвлэгдсэн ёс суртахууны холбогдолтой бүтээлүүдийг түүвэрлэн эмхтгэж нийтийн хүртээл болгох арга хэмжээ авна.

Монголчуудын ёс суртахууны талаар олон нийтийн сонирхол анхаарал татахуйц сургамжтай, чансаатай бүтээл туурвих нь Монголын уран бүтээлчдийн нэр төрийн хэрэг мөн.

4.4 Ёс суртахуун ба шажин шүтлэг

Ард түмэн чиг баримжаагаа алдаж, оюун санаа нь мохсон учраас тэд итгэл үнэмшлээ алджээ. Ёс суртахууны уг сурвалж шажинд үргэлж байсаар ирсэн бөгөөд шажнаас өөр юунд ч байхгүй. Түүхэн шажин шүтлэг бол ямар ч уламжлалт улс оршин тогтнохуйн үндэс суурь мөн. Шажин шүтлэгийг ёс суртахууныг тогтоогч, хамгаалагч оюун санааны хүчирхэг хэрэглүүр хэмээн үзнэ. Нэр төр, жудаг, нандин чанар, үүрэг хариуцлагыг дээдэлдэг учраас сүсэг бишрэл хүнийг хөдөлгөгч хүч болдгийг умартаж болохгүй. Харин лам санваартан ёс суртахууны номлогч байх атал шажин шүтлэгийг ёс суртахуунгүй зан үйлийг өөгшүүлэх, мөнгө олох хэрэгсэл болгон ашиглахыг хатуу хориглох шаардлагатай. Талын нэг тарсан сүм дуган үйлдсэн нүгэл хилэнцээ мөнгөөр цайруулах “түшиц” газар болгож байгааг таслан зогсоох ёстой.

5. ЁС СУРТАХУУН Л ТӨРИЙГ ТҮВШИН БОЛГОНО

Төр түвшин байх нь засгийн эрх баригчдын ёс суртахуун, тэдний нэр хүндээс шууд хамааралтай.

Сонгууль мөнгөний өрсөлдөөн болгон хувирч, мөнгийг ёс суртахуунаас дээгүүр тавьдаг хүмүүсийг засгийн эрхэнд гаргаад байвал улс оронд сэтгэл тэнүүн, аз жаргалтай амьдрал авчрахгүй. Ядуурал, ажилгүйдлийг аль болохоор багасгаж, ард олныг соён гэгээрүүлэх ажлыг өрнүүлэх нь сонгогчдыг саналаа худалдахаас сэрэмжлэх нөхцөл болно.

Ёс суртахуунлаг засаг хэдийчинээ нэр хүндтэй байна, засаг нэр хүндтэй байх тусмаа төр тогтвортой түвшин бат байна. Их нэр хүндтэй аваас хүүхэд эцэгтээ хандах лугаа адил ард түмэн засгаа хүндэлнэ. Нэр хүндтэй засаг ёс суртахуунлаг хүмүүсээ хамгаалах үүргээ, тэднийг төрийн албанд татах явдлыг тэргүүн зэрэгт тавина.

Улс төрийн нам бол сонгуульд оролцохын тулд байгуулагдсан бүтэц юм. Хэрэв тухайн нам эх орон, ард түмний төлөө нэгэн үзүүрт сэтгэлээр хүчин зүтгэгсдийг өрсөлдүүлэхээр сонгуульд нэрийг нь дэвшүүлж чадсан тохиолдолд төрийг илааршуулах нэг ёсны эм юм. Эрүүл болсны дараа эмийн хэрэг байхгүй болдогтой нэгэн адил улс төрийн нам засгийн эрхийг авах зорилгоо биелүүлсний дараа үйл ажиллагаагаа зогсоох шаардлагатайг харуулна. Үүний тулд улс төрийн намыг хатуу гишүүнчлэлгүй болгох ёстой. Намыг толгой дээрээ гаргасан нийгэм мөхлөө дуудсантай яг ижил болно. Хэрэв нам тэмцэж байгаа үедээ

дэмжигчдээ зовлон үүрүүлж байдаг бол ялсан үедээ ямба эдлүүлнэ. Хувиа бодсон бэртэгчид ашиг завшаан харж намд ирэх нь бодит зүйл. Ялсан нам руу аялдан дагалдагчид хийгээд албан тушаалтны донтнууд хуйларцгаана. Албан тушаалын төлөө намын дотоодод нанчилдаан зохион байгуулж, хор найруулан эрх тушаалд шунагчид олширсны балгаар нам ёс суртахууны хувьд амархан ялзарна. Дарга нарын өмнө нугасгүй бялдуулагчид ялж, нэр төрөө эрхэмлэгч ёс суртахуунлаг нь ямагт ялагдана. Адгийн этгээд толгой дээр гарч, өөрийгөө хамгаалуулахын тулд өөртэйгөө адилханыг хажуу хавиргандаа татдаг. Ялангуяа салиа нь арилаагүй залуусыг ёс суртахууны хувьд ялзуулна. Ялсан намд ашиг завшаан харсан бүлэглэл үүсдэг нь зүй тогтол. Ингээд намын эгэл жирийн дэмжигчид ба намын дарга нарын хооронд үл ойлголцлын хэрэм босно.

Сонгууль мөнгөний өрсөлдөөн болгон хувирч, мөнгийг ёс суртахуунаас дээгүүр тавьдаг хүмүүсийг засгийн эрхэнд гаргаад байвал улс оронд сэтгэл тэнүүн, аз жаргалтай амьдрал авчрахгүй. Ядуурал, ажилгүйдлийг аль болохоор багасгаж, ард олныг соён гэгээрүүлэх ажлыг өрнүүлэх нь сонгогчдыг саналаа худалдахаас сэрэмжлэх нөхцөл болно.

Төрийн албыг улс төрөөс хараат бус, мэргэжлийн, тогтвортой болгож, төрийн албан хаагчдын ёс зүйг өндөржүүлнэ. Төрийн албан хаагчдыг шат дараалан дэвшүүлэн ажиллуулах журамд шилжинэ.

Ёс суртахуунлаг засаг хэдийчинээ нэр хүндтэй байна, засаг нэр хүндтэй байх тусмаа төр тогтвортой түвшин бат байна.

Монгол төрийн бодлого ямар байх ёстойг бодож боловсруулах гэж, гаднаас хуулбарлах гэж зовох онцын шаардлагагүй бөгөөд энэ нь Чингис хаанаас багшдаа бичсэн захидалд тусгагдсан юм: “Хаан миний бие умар зүгийн их хээр талд аж төрөн сууж, чигч шударгыг эрхэмлэн тогтоогоод, бүрэлгэн сүйтгэхийг хориглон зогсоож, идэх хоол, өмсөх хувцсаа адуучин үхэрчинтэй хуваалцан, ард иргэдийг үр хүүхэдтэйгээ адил үзэж, цэрэг дайчид, эрдэмтэн мэргэдийг ах дүүгээн мэт хүндэлж, эе звийг эрхэмлэж, энэрэл хишгээ түгээмүй” гэж бичсэн байна.

6. ЁС СУРТАХУУНЫГ ЗАХ ЗЭЭЛ МОХООДОГ

Монголын ард түмний сайн сайхны төлөө бус дан ганц ашгийн төлөө чиглэгдсэн зах зээлийн эрхшээлд улс орны эдийн засаг бүхэлдээ орсон нь ёс суртахуун хүмүүний хамгийн үнэт зүйл байхаа больж, мөнгийг бүхнээс дээр гаргав. Асар их мөнгө шударга ёс, ямар ч хуулийг салам цохих болжээ. Ашгийн төлөө эх орны нөөц баялгийг махчин мэт цөлмөж, хэрэглээний үзэл газар авав. Нөгөө талаас оюун санааны хоосрол, хувиа бодсон үзэл, хайхрамжгүй явдал цадигаа алдав. Зах зээл гэр бүл, хувь хүнийг сүйдлэх болов. Монголын хүн амын нэг хэсэг нь өр зээлэнд баригдан сэтгэл санаагаар унаж, заримдаа амьд явахад хэцүү болж, нөгөө хэсгийг нь “хар” мөнгө мансуурал, хэрээс хэтэрсэн тансаглал, аль муу муухай зүйлтэй холбогдуулж байна.

Хүн ам, түүний дотор хөдөлмөрийн чадвар бүхий хэсэг цөөн, хэдхэн төрлийн экспортын бараатай манай улсын хувьд улс орныхоо онцлогт тохирсон ард түмнийхээ эрэлт хэрэгцээг чанартай хангасан эдийн засгийн загварыг буй болгохгүй бол Монгол Улсын цаашид оршин тогтнох эсэх нь эргэлзээтэй болж болзошгүй.

Эдийн засгийг ард түмний сайн сайхны төлөө болгоход хэрэглэгчдийг хуурч мэхэлсэн, гол гаргаж луйвардсан бол худалдаа, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох гол үндэслэл гэж үзэх нь чухал ач холбогдолтой.

**Хүцүлийн дээр ёс
суртахуун тавигдах ёстой.
Хүцүлийн амин сүнс цугтаа
ёс суртахуун юм.**

7. ХУУЛИЙН АМИН СҮНС ЁС СУРТАХУУН

Хуулийн дээр ёс суртахуун тавигдах ёстой. Хуулийн амин сүнс угтаа ёс суртахуун юм.

Хууль тогтоогчдын үндсэн зорилго нь ёс суртахууныг хамгаалах, бэхжүүлэхэд чиглэгдсэн хууль батлахад оршино.

Хуульчдыг сонгон шалгаруулах, тэднийг шилж сонгоход ёс суртахууныг тэргүүн зэргийн шалгуур болгоно.

VI. ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДАХ ЭТГЭЭД

Хөтөлбөрт хамрагдах этгээд нь УИХ, Ерөнхийлөгч, Засгийн газар, орон нутгийн засаг захиргаа, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, хуулийн байгууллага, төрийн бус байгууллага, хуулийн этгээд, аж ахуйн нэгж, иргэд байх бөгөөд тэдгээрийн ёс суртахууны талаар хүлээх үүргийг тодорхой болгоно.

VII. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

Хөтөлбөрийг санхүүжүүлэхэд шаардлагатай зардлыг УИХ улсын төсвөөс гаргана.

VIII. ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН

Монголын нийгэм бүхэлдээ ёс суртахуунжиж, мөнгөний дээр түүнээс илүү үнэ цэнэтэй хүмүүний ёс суртахуун байдгийг ухааруулж, эх орондоо аз жаргалтай, сэтгэл тэнүүн аж төрөх оюун санааны нөхцөл бүрэлдэнэ.

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРЛААС ГАРГАСАН ЗӨВЛӨМЖ

МАН-ын Хяналтын Ерөнхий хорооны дэргэдэх Ёс зүйн хороо, Стратеги академи, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэдэх Удирдлагын академи, ШУА-ийн Философийн хүрээлэн хамтран зохион байгуулсан “Өнөөгийн монголын нийгмийн улс төрийн хариуцлага, ёс зүйн зангилаа асуудлууд” сэдэвт эрдэм шинжилгээний бага хуралд тавьсан илтгэлүүд, хуралд оролцож үг хэлсэн эрдэмтэн судлаачид, төр засгийн ажилтнууд, нам, иргэний нийгмийн төлөөллийн дэвшүүлсэн санааг үндэс болгон тус бага хуралд ОРОЛЦОГСОД энэхүү зөвлөмжийг санал нэгдэж сайшаан дэмжив.

Монголын нийгэм өөдрөг үзэл санаанд тулгуурлаж, ёс зүйн соёлыг нийгэмд төлөвшүүлж, өөрийгөө ариусгаснаар ёс зүйн доройтлыг арилгаж, учирсан бэрхшээлийг амжилттай даван туулж чадах тул хуралд оролцогсод:

Өндөр соёлтой, ёс суртахууны хариуцлага сайтай нийгмийг цогцлоохын үүднээс төр, засгийн удирдах байгууллагууд, улстөрийн бүх хүчнүүд, төрийн бус байгууллагууд, сонирхсон хувь хүмүүс дараах зорилтуудыг ойрын үед хэрэгжүүлэхийн

төлөө хамтран ажиллахыг зөвлөн уриалж байна:

1. Монголын нийгмийн улс төрийн харилцаа, төрийн албаны тогтолцоог бүхэлд нь эрүүлжүүлэх, эрин цагийн шаардлагад нийцсэн шинэ дэг журмыг тогтооход чиглэсэн улс төрийн болон төрийн албаны хариуцлага, ёс зүйн цогц бодлогыг боловсруулан үе шаттай хэрэгжүүлэх;
2. Монголчуудын эртнээс уламжилж ирсэн шударга ёс, ичих нүүр, жудаг, нинжин сэтгэл, нэр төр, ах захаа хүндлэх ёсон, эелдэг зочломтгой нийтэч зан, тэсвэр тэвчээр, ам ажил нь зөрдөггүй чанар зэргийг багтаасан “Би монгол хүн” хэмээх бахархлыг сэргээхэд чиглэсэн “МОНГОЛЧУУДЫН ЁС СУРТАХУУН” Үндэсний хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;
3. Ёс суртахууныг хамгаалж бэхжүүлэхэд чиглэсэн эрх зүйн шинэчлэлийг цаг алдалгүй дэс дараатай зохион байгуулах, энэ хүрээнд ажиллаж амьдрах соёлыг төлөвшүүлж хэвших.

**“ӨНӨӨГИЙН МОНГОЛЫН НИЙГМИЙН
УЛС ТӨРИЙН ХАРИУЦЛАГА, ЁС ЗҮЙН
ЗАНГИЛАА АСУУДЛУУД” сэдэвт
эрдэм шинжилгээний бага хуралд
оролцогсод**


Улаанбаатар хот

*2016 оны 10 дугаар сарын 16-ны өдөр
Тусгаар тогтнолын ордон*



СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ФИЛОСОФИЙН ХҮРЭЭЛЭН



ЁС СУРТАХУУНЫ БОЛОВСРОЛ

Судалгааны тайлан

УЛААНБААТАР
2020

НЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

1.1. Экспертийн судалгааны зорилго, зорилт

Шинжлэх ухааны академийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбараас “Монголчуудын ёс суртахуун – эрх зүйн хөгжлийг хангах үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагыг иж бүрэн тодорхойлох нь” сэдэвт суурь судалгааны төслийн ажлыг 2017-2019 онд хэрэгжүүлж байна. Тухайн төслийн хүрээнд 2019 оны 9, 10 дугаар сард “Ёс суртахууны боловсрол” сэдэвт социологийн судалгаа хэрэгжүүлсэн.

“Монгол Улсын боловсролын зорилго нь иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхитай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино.”¹ гэж заагдсан. Тиймээс боловсролын нэг зорилго нь сурагчдыг ёс суртахуунтай болгох юм. Ёс суртахуун бол юуны өмнө хувь хүний хүмүүжил ба төлөвшлийн гол чиг ноён нурууг илэрхийлнэ. Ёс суртахуунгүй гэдэг нь хүмүүжилгүй гэсэн үг. Ёс суртахуун бол хүний мөн чанар бөгөөд ёс зүйн судлагдахуун юм. Ёс суртахуун бол хүнийг сайн, муу гэж хэмжих шалгуур болдог. Ёс суртахуун гэдэг нь хүний мөн чанарыг, хүнлэг ёс, ертөнцийн юмсад хандах хэм хэмжээ. Бусдад өөрийгөө танин мэдүүлэх, илэрхийлэх, бусдын эрх ашгийг хүндэтгэх нийтээр тогтоосон хэм хэмжээ.

Тиймээс ёс суртахууны боловсрол Монголын өнөөгийн нийгэмд судлах нэн шаардлагатай, тулгамдсан чухал асуудал болоод олон жил болсон. Түүний гол шалтгаан нь Монгол Улс 1990-ээд оны эхээр эдийн засгийн систем руу шилжих явцад хүмүүс хоорондын харилцааны шинж чанар өөрчлөгдөж өнөө үед сурагчид ямар нийгмийн хэм хэмжээг баримталж чадаж байгаа эсэхийг тодорхойлох шаардлагатай юм.

Ёс зүйн ухааныг дан ганц философичид өмчилж ярьдаг байсан бол өнөөдөр хуульчид, багш, сэтгүүлчид, эмч гээд мэргэжлийн бүх салбарынхны ярьдаг амин чухал асуудал болжээ. Учир нь ёс суртахууны хариуцлага хүлээхэд хөөн хэлэлцэх хугацаа огт үйлчилдэггүй, өндөр зан суртахуунтай иргэдийн хувьд тийм ойлголт ч байхгүй. Үр дагавар нь гэм буруутанд маш хатуу тусч, он удаан жил үргэлжилж, муу нэрийг хусч хаяхыг оролдовч салдаггүй. Ялангуяа зудгаа алдсан, ёс зүйгүй этгээдийн нэгэнт сэвтсэн нэр төр, алдар хүнд нь хэдэн үеийг дамждаг, сайн нэрийг хүсч тэмүүлэвч үл олдох, хуулиас хатуу дэг журамтай, хэнээс ч үл хамаарч хэнд ч үл захирагдах, тийм л ёс журам үйлчилдэгийг их дээдэст түгээх шаардлагатай байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ёс суртахууны төлөвшилд сөрөг нөлөө үзүүлж буй агуулгатай мэдээ, мэдээлэл, кино, дүрс бичлэг хяналтгүй гаргадаг бөгөөд сэтгэлийн гэгээрэл, хүн чанар, ариун ёс журмыг өгүүлсэн зүйл бага оруулах хандлага ажиглагдсан. Энэ нь нийгмийн сүлжээний буруу хэрэглээ болон эцэг, эхчүүд хүүхдүүддээ хяналт тавьдаггүйгээс шалтгаалж байгаа. Энэ нь иргэдэд зан суртахууны хэм хэмжээ, зарчмыг харилцаа, үйлдэлдээ хэвшүүлэх нийгмийн орчин үгүйлэгдэж байгааг илэрхийлж байгаа юм.

Экспертийн судалгааны хүрээнд ЕБС дахь ёс суртахууны боловсролын байдал, түүнд нөлөөлж буй нийгмийн хүчин зүйлсийг тоймлон гаргах, сайжруулах арга замыг судлах судалгааны зорилго оршино.

Дэвшүүлж буй судалгааны зорилт

¹ Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 4 дүгээр зүйл.

1. ЕБС-ийн багш нарын ёс суртахууны талаарх ойлголтыг тоймлон гаргах,
2. ЕБС-ийн орчин дахь ёс суртахууны боловсролд нөлөөлж буй нийгмийн хүчин зүйлсийг тодруулах,
3. Ёс суртахууны доголдол, доройтлыг арилгах арга замын талаар экспертийн саналыг авах.

Судалгааны арга зүй, аргачлал

Судалгааг тоон арга зүйгээр хэрэгжүүлнэ. Анкет, баримт бичиг аргаар мэдээлэл цуглуулна.

Анкетын арга

- ❖ Асуулгын арга – Улаанбаатар хот болон орон нутгийн ЕБС-ийн 100 гаруй багшийг онлайнаар болон цаасан хэлбэрээр анкетын аргыг ашиглаж тоон мэдээлэл цуглуулна.
- ❖ Статистик болон судалгааны тоон мэдээлэлд анализ шинжилгээ хийнэ.

Судалгааны аргачлал

Тоон судалгааны асуулгыг урьдчилан бэлтгэсэн асуулгын дагуу явуулж, мэдээллийг онлайнаар болон цаасан хэлбэрээр авах болно. SPSS багц программаар нэгтгэн, мэдээллийг харьцаа, дундаж бодох, хэв маягчлал үүсгэх, харьцуулах зэргээр анхдагч шинжилгээ хийсний үндсэн дээр судалгааны тайлан бичнэ.

Боловсролын салбарын ёс суртахууны байдлыг судлахад баримт бичгийн шинжилгээ хийсний үр дүнд тоон мэдээлэл цуглуулах шаардлагатай гэж үзэж судалгааны хэрэглэгдэхүүн боловсруулсан байгаа.

Гол асуудал нь ёс суртахууны хүмүүжилд ямар нийгмийн институт нөлөөлж байгаа, ямар саад бэрхшээл учирж байгааг судлахад баримт бичгийн судалгаа болон тоон мэдээллийг ашиглана.

а. Судалгааны объект, зохион байгуулалт

Судалгааны объектоор Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн зарим аймгийг сонгож нийт 119 хүнийг хамруулж судалгааны мэдээлэл цуглуулсан.

ШУА-ийн ФХ-ийн судалгааны баг анкет хэрэглэгдэхүүнийг боловсруулж, судалгааны мэдээлэл цуглуулах, боловсруулах, нэгтгэн дүгнэх, тайлан зөвлөмж бичих бүхий л үйл шатанд судалгааны багийн үндсэн гишүүд биечлэн гүйцэтгэлээ.

б. Судалгааны түүвэр

Судалгаанд Улаанбаатар хотын ЕБС-ийн багш нарын ажилласан хугацаа, сургуулийн төрөл зэрэг үзүүлэлтийг харгалзан 119 багш нарыг судалгаанд хамруулав. Судалгаанд оролцогчдын ажилласан жил, туршлага зэргийг шалгуур үзүүлэлт болгон сонгосон түүврийн олонлог эх түүврийг бүрэн төлөөлж чадна гэж үзэж байна.

с. Судалгааны арга

Тоон аргыг хэрэглэж анкетын аргаар мэдээлэл цуглууллаа.

Анкетын арга

Судалгааны зорилго, зорилттой уялдуулан, багш нарын ажилласан жил, ажлын туршлага, хувийн болон улсын сургууль зэрэг үзүүлэлтүүдийг харгалзан ёс суртахууны боловсролын өнөөгийн байдлыг тодорхойлох үндсэн зорилгын хүрээнд 3 багц үзүүлэлтээр үнэлгээ авч, таван утга бүхий (1. Огт нөлөөлдөггүй, 2. Бараг нөлөөлдөггүй, 3. Ер нь нөлөөлдөг, 4. Маш их нөлөөлдөг, 5. Хэлж мэдэхгүй) эрэмбийн шкалаар хэмжсэн. Багш нар ёс суртахууны боловсролын түвшинг тодорхойлж, өөрийн болон сурагчдын түвшинг мөн үнэлсэн.

Судалгаанд Улаанбаатар хотын 6 дүүрэг болон орон нутгийн сургуулийн багш нарыг хамруулан анкетын аргаар 119 респондентоос мэдээлэл авав.

Мэдээлэл боловсруулах арга

Анкетын аргаар цуглуулсан мэдээллийг статистик боловсруулалт хийх “SPSS-20” орчин үеийн багц программыг хэрэглэн боловсруулж, нэг ба хоёр хэмжээт тархалт байгуулан, тархалтын зарим параметрууд болон хамаарах, үл хамаарах хувьсагчдын холбоо хамаарлыг тооцоолж шинжилгээ хийлээ.

d. Судалгаанд оролцогчдын нийгэм-хүн ам зүйн байдал

“Ёс суртахууны боловсрол” сэдэвт судалгааны хүрээнд Улаанбаатар хотын ЕБС-ийн багш нараас голчлон мэдээлэл цуглуулж түлхүү Сүхбаатар, Баянзүрх, Чингэлтэй, Хан-Уул дүүрэгт байршилдаг улсын болон хувийн ЕБС-ийн багш нараас мэдээлэл цуглуулав. Улаанбаатар хотод Монгол Улсын оршин суугчдын бараг тал хувь нь амьдарч, багш нарын ачаалал нь ч мөн бусад аймаг, сумуудыг авч үзвэл илүү их болдог.

Үүнээс гадна Дундговь, Дорнод, Увс, Говьсүмбэр аймгийн нийт 5 сумын ЕБС-ийн багш нарыг хамруулж нийт оролцогчдын 4.1 хувийг эзэлсэн.

Багш нарын насны бүтцийг авч үзвэл гол төлөв 25-44 насны хүмүүс эзэлж байгаа бөгөөд 55-аас дээш настай багш нар хамгийн бага хувийг /3,4%/ эзэлсэн боловч тэтгэвэрт гарсан ч цаашлаад багшлах боломжтойг харуулж байна. Хүйсийн хувьд дийлэнхийг (81.5%) эмэгтэйчүүд эзэлж байгаа нь илт юм. Статистикийн мэдээллийн дагуу 2018/2019 оны хичээлийн жилд нийт ерөнхий боловсролын сургуульд 30.4 мянган багш ажиллаж байгаагийн 81.8 хувийг эмэгтэй багш эзэлсэн гэжээ².

Хүснэгт 1. Таны нас (хувиар)

№		Тоо	Хувь
1	24 нас хүртэл	6	5.0
2	25-34	47	39.5
3	35-44	37	31.1
4	45-54	25	21.0
5	55-аас дээш	4	3.4
	Нийт	119	100.0

ЕБС-ийн багш нарын нас болон багшилсан жилийг харьцуулж үзвэл 28.6 хувийг 1-5 жил, 19.3 хувийг 6-10 жил багшилсан багш нар эзлэж байгаа нь Монгол Улсын багш нарын

² ҮСХ. Боловсрол, шинжлэх ухааны салбарын танилцуулга 2018. УБ., 2019. Электрон эх сурвалж: www.1212.mn

нийт ажилласан жилийн хандлагатай дүцэж байна. Тухайлбал, 2018/2019 оны хичээлийн жилд 1-5 жил ажилласан багш 32.6 хувь, 6-10 ажилласан нь 18.9 хувь эзэлсэн³.

Хүснэгт 2. Нас, багшилсан жил (хувиар)

№	Нас Багшилсан хугацаа	1 жил хүртэл	1-5 жил	6-10 жил	11-15 жил	16-20 жил	21-25 жил	25- аас дээш
1	24 нас хүртэл	16.7	83.3	-	-	-	-	-
2	25-34	2.1	53.2	38.3	6.4	-	-	-
3	35-44	-	10.8	13.5	27.0	24.3	21.6	2.7
4	45-54	-	-	-	-	16.0	48.0	36.0
5	55-аас дээш	-	-	-	-	-	-	100.0
Нийт		1.7	28.6	19.3	10.9	10.9	16.8	11.8

Хүснэгт 2-ыг үзэхэд 25-34 настай багш нарын ажилласан жил хоорондоо ялгаатай байна. Зарим багш зөвхөн 1 жил хүртэл ажилласан бол зарим нь багшлаад 11-15 жил болж байгаа нь урд нь өөр ажил эрхэлж байсан аль эсвэл боловсрол эзэмших хугацаа нь ялгаатай гэж дүгнэж болох юм. Харин 45-аас 54 насны багш нар голчлон 20 жил ажилласан, нэлээн туршлагатай, тогтвортой хэсэг бүлэг юм. Улсын сургуулийн багш нарын ажилласан жилийг авч үзвэл 1 жил хүртэл ажилласан багш нар хамгийн цөөн хэсгийг бүрдүүлж, 1-5 жил ажиллаж байгаа багш нар олонх хэсгийг бүрдүүлж байна. Харин хувийн сургуульд 1-10 жил ажилласан хамгийн өндөр хувийг эзэлж байна. Хувийн сургуулиудад 1 жил хүртэл багшилсан багш манай судалгаанд хамрагдаагүй байгаа бөгөөд 11-15 жил ажилласан багш нар хамгийн бага хувийг эзэлж байна.

Хүснэгт 3. Ажилласан жил болон сургуулийн төрөл.

№	Ажилласан жил	Улсын	Хувийн
1	1 жил хүртэл	2.6	-
2	1-5 жил	27.6	30.2
3	6-10 жил	13.2	30.2
4	11-15 жил	15.8	2.3
5	16-20 жил	10.5	11.6
6	21-25 жил	13.2	23.3
7	26-аас дээш	17.1	2.3
Нийт		100.0	100.0

³ Мөн гэнд.

ХОЁР. СУРАГЧДЫН ЁС СУРТАХУУНЫ ТӨЛӨШИЛД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС

Манай судалгааны нэг зорилт бол хувь хүний төлөвшил, ёс суртахуунт байдалд ямар хүчин зүйл хэр их нөлөөтэй байгааг судлахад оршино. Респондентууд сурагчдын зан суртахуу, ёс суртахууны төлөвшилд хамгийн их нөлөөлдөг хүчин зүйлсээр гэр бүлийн хүмүүжил (92.4), хувь хүний ухамсар (90.6), амьдарч буй орчины нөлөө (84.9) болон боловсролын байдлыг (84.9) нэрлэсэн байна. Хүн болж төлөвших үйл явцад тухайн хүний өөрийн төрмөл зан суртахууны өгөгдлийг боловсролын байгууллагаас өгч буй мэдлэг, ур чадвар илүү хөгжүүлж өгөх чухал нөлөө үзүүлдэг байна. Тиймээс сурагчдад **боловсролоор дамжуулан ёс суртахууны төлөвшил олгох** нь хүний өөрийн төрмөл зан суртахуун, гэр бүлийн болон амьдарч буй орчны нөлөөлөөр олж авч буй ёс суртахууны төлөвшилтэй адил чухал гэдэг нь харагдаж байна. Хувь хүний ёс суртахууны байдалд гэр бүлийн зүгээс бүрдүүлж буй орчин, хүмүүжил, ямар орчинд амьдарч байгаа нь шууд нөлөөлдөг байна. Харин судалгааны дүнгээр хүн болж төлөвших, хувь хүний хүмүүжил, ёс суртахуунд шашин шүтлэг, улс төрийн нөхцөл байдлын үзүүлэх нөлөө харьцангуй бага байдаг гэжээ.

Хүснэгт 4. Хувь хүний хүмүүжил, ёс суртахуун төлөвших үйл явцад дараах хүчин зүйлс хэрхэн нөлөөлдөг вэ? /хувиар/

№		Нөлөө бага	Нөлөө их	Хэлж мэдэхгүй
1	Удам угсаа, гарал үүсэл	24.4	71.5	4.2
2	Гэр бүлийн хүмүүжил	6.7	92.4	0.8
3	Амьдарч буй орчин	12.6	84.9	2.5
4	Материаллаг байдал	33.6	59.7	6.7
5	Боловсрол	14.3	84.9	0.8
6	Хувь хүний ухамсар	7.5	90.6	0.8
7	Үндэсний уламжлал, ёс заншил	21.8	75.6	2.5
8	Шашин шүтлэг	44.5	42.9	12.6
9	Улс төрийн нөхцөл байдал	55.5	28.6	16.0
10	Гадаад соёл	37	56.3	6.7

Сурагчид хэнийг үлгэр дуурайл болгодог вэ?

Ямар ч хүн өөрийн үлгэр дуурайлыг хамгийн ойр харилцдаг, дотно хүмүүсээс авдаг бөгөөд оролцогчдын 66.4 хувь нь (давхардсан тоогоор) хүүхэд эцэг эхээ өдөр бүр харж үлгэр жишээ авдаг гэж хариулсан байна. Мөн хамгийн дотны хүрээ болох гэр бүлийн гишүүд болон багш, сурган хүмүүжүүлэгчдээ үлгэр жишээ болгон тэднийг чухалчлан үздэг байна. Мэдээллийн эрин үед амьдарч буйн хувьд өсвөр насныхан нийгмийн сүлжээн дэх нэр хүнд бүхий хүмүүсийг үлгэр дуурайл болгодог нь хүснэгтээс харагдаж байна.

Хүснэгт 5. Сурагчид хэнийг илүүтэй үлгэр дуурайл болгодог вэ?

№		Тоо	Тохиолдлын хувь
1	Эцэг, эх	79	66.4
2	Гэр бүлийн гишүүд	49	41.2
3	Найз нөхөд	31	26.1
4	Ахмад үе	5	4.2
5	Багш, сурган хүмүүжүүлэгч	46	38.7
6	Улс төрч	1	0.8
7	Бизнесмен	1	0.8
8	Жүжигчин, дуучин	10	8.4
9	Нийгмийн сүлжээн дэх нэр хүнд бүхий хүн	20	16.8
Нийт		242	203.4

Эцэг, эх, гэр бүлийн гишүүдийн дараах үлгэр жишээ авдаг хүмүүс нь багш, сурган хүмүүжүүлэгч (38.7%) орж байна. Тиймээс багш нар өөрснөө нэр хүндээ өндөрт өргөх, багшийн ёс зүгээ ягштал баримтлах, нийгмийн үүргээ өдөр тутам ухамсарлах хэрэгтэй байна.

Өнөөдөр багш нарын дийлэнх нь хууль, ёс журмаа баримталж багшийн нэр хүндийг унагаахгүй явж байна. Гэтэл бүгд багш тийм биш юм. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр багш нарыг дараах байдлаар нэрлэсэн: “Багш нар авилгачид”, “багш нар мөнгөний төлөө ажиллаж, боловсролыг бизнес болгож буй”.⁴ Энэ нь нийгмийн болон ёс суртахууны доройтлын шинж тэмдэг бөгөөд мэргэжлийн ёс зүйн зхэм хэмжээг шинэчлэх, шинэ шаардлага тавихыг шаардаж байгаа. БСШУЯ-аас 2019 онд багшлах эрх олгох, хасах журмыг батлан гарсан билээ. Тухайн журмын зорилго нь “багшийн ёс зүй, нэр хүндийг өргөх, тэдний үүрэг, хариуцлагыг дээшлүүлэхэд оршино” гэжээ.⁵ Багш хүн өөрөө үлгэр жишээ болж чадаж байна уу гэдэг асуулт тавигдаж байна. Нөгөө талаар сурагчдын гэр бүлийн гишүүд, ойр дотны хүмүүс ёс суртахуунт байдлаас хүүхдийн хүмүүжлийн асуудал урган гарч ирж байна.


Сурагчдын ёс суртахууны төлөвшил ямар байна вэ?

Судалгаанд оролцсон багш, сурган хүмүүжүүлэгдээс сурагчдын ёс суртахуунт байдлыг төлөвшиж буй, ёс суртахууны төлөвшил өндөр гэсэн 1-10 баллаар үнэлүүлсэн бөгөөд 23.7 хувь нь дундаж гэж хариулсан байна. Энэ нь нэг талаар сурагчдын ёс суртахууны төлөвшлийг илэрхийлэхээс гадна багшийн үнэлэмж эргэлзээтэй байгааг харуулж байна. Сурагчдын ёс суртахууны төлөвшлийг үнэлэх үнэлгээний үр дүнд ажиглагдсан нэг зүйл нь бага ангийн багш нар сурагчдаа эергээр үнэлсэн бол ахлах, дунд ангийн багш нар сөрөг утгатай ойр үнэлсэн байдал юм. Энэ нь сурагчдын насны байдал, сэтгэл зүйн онцлогтой хамааралтайгаас гадна багшид сурагчдаас ирж буй ачаалалтай холбогдох юм. Мөн багш өөрийн ёс суртахуунт байдлыг хэрхэн үнэлж байгаа нь сурагчдыг үнэлэх үнэлэмж шууд хамааралтай байсан болно.

⁴ Мэргэжлийн ба хэрэглээний ёс зүй. УБ., 2012. 95 дахь тал.

⁵ БСШУСЯ. Багшлах эрх олгох, хасах журам. 2019. <https://mecss.gov.mn/news/1810/>

Зураг 1. Та сурагчдын ёс суртахуунт байдлыг хэрхэн үнэлэх вэ?



Сурагчдын зан суртахуунд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлс

Хүүхэд эхийн хэвлийд бүрэлдэн буй болоход амьдарч буй орчин, нийгмийн бүлэг, хүрээлэл зэргээс шалтгаалан зан суртахууны тодорхой төлөвтэй төрдөг бөгөөд өсөж торних явцдаа өөрийн үнэт зүйл, ёс суртахууны хэм хэмжээг төлөвшүүлэн бий болгодог. Тухайн хэм хэмжээ, өөрийн гэсэн үзэл бодлыг төлөвшүүлэн бий болгоход орчны нөлөө эерэг болон сөргөөр нөлөөлж байдаг нь тодорхой юм. Хүүхэд хүн болж төлөвших, нийгмийн иргэн болж амьдрахад тэдний зан суртахуунд ямар зүйлс сөрөг байдлаар нөлөөлдөг болохыг судалгаанд ороцогсад дараах байдлаар тодорхойлжээ.

Хүснэгт 6. Ямар хүчин зүйлс сурагчдын зан суртахуунд сөргөөр нөлөөлж байна гэж Та үзэж байна вэ? (хувиар)

№		Маш их нөлөөтэй	Ер нь нөлөөлдөг	Бараг нөлөөлдөггүй	Огт нөлөөлдөггүй	Хэлж мэдэхгүй
1	Нийгмийн сүлжээ	63.0	28.6	3.4	1.7	3.4
2	Онлайн тоглоом	71.4	21.0	2.5	0.8	4.2
3	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис	46.2	30.3	3.4	0.8	19.3
4	Гэр бүлийн хүчирхийлэл	68.9	26.1	1.7	-	3.4
5	Гэр бүл салалт	77.3	18.5	0.8	0.8	2.5
6	Эцэг, эхийн хараа хяналтгүй байдал	73.1	21.8	0.8	0.8	3.4
7	Нийгмийн тэгш бус байдал	27.7	57.1	5.9	-	9.2
8	Үерхэл, хайр сэтгэл	29.4	49.6	10.1	1.7	9.2
9	Мөнгө, санхүүгийн байдал	23.5	49.6	19.3	0.8	6.7
10	Сургуулийн орчин	27.7	57.1	5.9	2.5	6.7

Бид хувь хүний хувьд үр хүүхдээ өсгөж хүмүүжүүлэх, тэдэнд ээлтэй аюулгүй орчныг бүрдүүлэх, ажил мэргэжлийн хувьд тэдэнд мэдлэг, боловсрол олгох зэрэг үүргийг хүлээж хойч үеэ ирээдүйд бэлддэг. Сурагчдын зан суртахуунд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийн тоонд тэдний өсөж торниж буй орчны сөрөг нөлөө болох гэр бүл салалт (77.3%), гэр бүлийн хүчирхийлэл (68.9%), хараа хяналтгүй байдал (73.1%) хамгийн өндөр хувьтай байна. Эдгээр хүчин зүйлс нь нэг нь нэгнээсээ урган гарч байдаг нягт холбоотой хүчин зүйлс байх бөгөөд гэр бүлийн орчны нөлөөлөл юм. Дээрх хүчин зүйлсээс буюу хараа хяналтгүй, халамж анхааралгүй байдлаас улбаалан гарч буй зан суртахуунд сөргөөр нөлөөлж хүчин зүйлс нь онлайн тоглоом (71.4%), нийгмийн сүлжээнд (63.0%) донтох, амьд харилцааны дутмаг байдал байна.

Сурагчдын зан суртахуунд нийгмийн тэгш бус байдал, үерхэл, мөнгө санхүүгийн байдал, сургуулийн орчин тодорхой хэмжээнд нөлөөтэй байгааг дээрх хүснэгтээс харж болно. Хувийн сургуулийн багш нарын 65.1 хувь нь нийгмийн тэгш бус байдал болон мөнгө санхүүгийн байдал сурагчдын зан суртахуунд ер нь сөргөөр нөлөөлж байна гэж үзсэн бол улсын сургуулийн багш нарын 58.2 хувь нь сөргөөр нөлөөлдөг гэж үзжээ. Хувь хүний нийгэмд эзлэх байр суурь тэгш бус байх нь сурагчдын зан төлөв, хоорондын харилцаа, өөрийн үнэлэмж, нөхөрлөлийн харилцаанд ч тэгш буй байдал үүсгэж байгааг дээрх дүнгээс харж болно.

Сургуулийн орчин

Гэр бүлийн орчноос гадна хүүхдүүдийн ихэнх цагаа өнгөрөөдөг, бусадтай харилцаж өөрийн гэсэн үнэ цэгийг мэдэрч, бүрдүүлдэг орчин бол сургуулийн орчин байдаг. Сургуулийн орчины ойлгомжгүй, сөрөг нөлөөлөл ёс суртахууны төлөвшилд тодорхой хэмжээний сөрөг нөлөө, дарамтыг үзүүлдэг байна.

Хүснэгт 7. Сургуулийн орчинд дараах асуудал хэр их гардаг вэ? (хувиар)

№		Огт гардаггүй	Бараг гардаггүй	Ер нь гардаг	Тогтмол гардаг	Хэлж мэдэхгүй
1	Ашиг сонирхлын зөрчил	16.8	26.1	35.3	8.4	13.4
2	Хүүхдийг гэр бүлийн байдал, хөгжил, суралцах чадвараар ялгаварлан гадуурхах	18.5	37.0	31.9	5.9	6.7
3	Сурагчдын гэр бүлээс бэлэг сэлт өгөх	16.8	39.5	35.3	2.5	5.9
4	Хүүхдийн бие махбодь, сэтгэл санааны шийтгэл үзүүлэх аливаа үйлдэл	17.6	46.2	23.5	1.7	10.9
5	Багш сурагч хоорондын харилцаанд үл ойлголцол гарах	5.9	37.8	43.7	6.7	5.9
6	Ном, сургалтын хэрэглэгдэхүүнийг тулган борлуулах	36.1	35.3	19.3	1.7	7.6
7	Сурагчид бие биенээ ялгаварлан гадуурхах	10.1	22.7	52.1	8.4	6.7

Сургуулийн орчинд сурагчид бие биеэ ялгаварлан гадуурхах (52.1%), багш сурагч хоорондын харилцаанд үл ойлголцол (43.7%) гарах зэрэг сөрөг асуудал зонхилон гардаг гэж судалгаанд оролцогчид хариулжээ. Дээрх хоёр сөрөг асуудал нь ёс суртахууны төлөвшилтэй шууд хамаарал бүхий асуудал байгаа нь сургуулийн орчин дахь ёс суртахууны төлөвшил цаашлаад хувь хүний ёс суртахуунт байдалыг анхааран үзэх хэрэгтэй болсныг харуулж байна. Материаллаг хэрэгцээтэй холбоотой зөрчлөөс илүү сурагч – сурагч, багш – сурагч, багш – захиргаа хоорондын харилцааны асуудал дээр “ёс суртахууны” шинжтэй зөрчлүүд гарч байгаа нь хүснэгт 7-ийн мөр бүрт байгаа дүнгээс тодорхой харагдаж байна.

ГУРАВ. ЁС СУРТАХУУНЫ БОЛОВСРОЛ ОЛГОЖ БУЙ БАЙДАЛ, ХЭРЭГЦЭЭ БА ХЭЛБЭР

Ёс суртахууны боловсролыг олгоход тусгай сурах бичиг ашиглах хэрэгцээ байгаа юу гэсэн асуултанд нийт судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 53.8 хувь нь “Маш их шаардлагатай. Тусгайлсан сурах бичиг хэрэгтэй байна” гэж хариулсан. Мөн 34.5 хувь нь “Зарим талаар шаардлагатай. Агуулга төрлөөс шалтгаална” гэж үзсэн байна. Зөвхөн 5 хувь нь “Шаардлага байхгүй. Ёс суртахууны боловсрол нь сурах бичгээр олгох зүйл биш” гэж хариулсан байгаа.

Хүснэгт 8. Багшилдаг анги болох тусгай сурах бичиг ашиглах шаардлага /хувиар/

№	Анги	Маш их шаардлагатай	Зарим талаар шаардлагатай	Тийм ч шаардлагатай биш	Шаардлага байхгүй	Хэлж мэдэхгүй	Нийт
1	Бага	50.8	40.0	4.6	1.5	3.1	100.0
2	Дунд	52.9	32.4	2.9	8.8	2.9	100.0
3	Ахлах	65.0	20.0	5.0	10.0	0.0	100.0
	Бүгд	53.8	34.5	4.2	5.0	2.5	100.0

Хүснэгт 8-аас үзэхэд бага ангид заадаг багш нарын 50.8 хувь нь ёс суртахууны боловсрол, мэдлэг олгоход “маш их шаардлагатай. Тусгайлсан сурах бичиг хэрэгтэй байна” гэж үзсэн. Дунд болон ахлах ангид заадаг багш нарын 52.9% болон 65.0% нь буюу талаас илүү хувь нь маш их шаардлагатай гэж хариулсан. Нийтдээ судалгаанд оролцогчдын 88.3 хувь нь ерөнхийдөө шаардлага байгааг хүлээн зөвшөөрч сурагчдын ёс суртахууны сурах бичгийг хичээлдээ ашиглах хэрэгцээтэй гэж үзэв.

Хүснэгт 9. Ёс суртахууны боловсрол, мэдлэгийг ямар төрлийн бүтээл, үйл ажиллагаагаар олгох нь зохистой вэ?

№		Тоо	Тохиолдлын хувь
1	Үлгэр, домог, сургамжит өгүүлэмж	46	23,4
2	Кино контент	28	14,2
3	Кейс сургалт	43	21,8
4	Соёлын арга хэмжээ (Музей, театр, үзэсгэлэн)	34	17,3
5	Нийтэд тустай сайн дурын үйл ажиллагаа	46	23,4
	Нийт	197	166,9

Ерөнхийдөө сурагчдын ёс суртахууны боловсролыг ямар байдлаар олгосон дээр вэ гэж асуухад давхар тоогоор 23.4 хувь нь “үлгэр, домог, сургамжит өгүүллэг” болон “нийтэд тустай сайн дурын үйл ажиллагаа” гэж хариулсан байна. Түүнчлэн 21.8 хувь нь кейс сургалтаар олгосон нь зүйтэй гэж хариулсан. Кейс сургалтаар ёс суртахууны боловсролыг олгох нь хувь хүн практик буюу бодит байдал дээр ямар тохиолдолд ямар шийдвэр гаргаж үйлдэл хийх, зөв бурууг ухамсарлах, өөрийн хэм хэмжээг бусад хүний хэм хэмжээтэй харьцуулж үзэхэд том хувь нэмэр оруулдаг болно. Мөн үлгэр, домог, сургамжит өгүүлэмж ч бодит жишээн дээр яаж зөв, ёс суртахуунлаг сонголт хийх, буруу сонголт хийхэд ямар сөрөг үр дагавар дагуулдагийг харуулж өгдөг. Харин судалгаанд оролцогчдын 14.2 хувь нь кино контент хэлбэрээр ёс суртахууныг олговол зөв арга гэж

үзсэн байна. Энэ нь мөн л сургамж өгөх, бодит жишээ харуулах, үлгэр дууриалал болох кино баатруудыг оруулсан байна. Мөн зөвхөн жишээнээс суралцах төдийгүй өөрөө нийтэд тустай сайн дурын үйл ажиллагаа явуулах нь ёс суртахууны боловсрол олгох нь хамгийн зохистой гэж үзсэн байна. Мөн тоон мэдээлэлд шинжилгээ хийж үзэхэд бага ангийн багш нар сурагчдад ёс суртахууны боловсролыг үлгэр домог, сургамжит өгүүллэгээр болон кэйс сургалтаар олгох нь үр дүнтэй гэж үзсэн бол, дунд, ахлах ангийн багш нар сайн дурын ажилд ороцуулах, кэйс сургалтаар олгох нь илүү үр дүнтэй гэж үзжээ. Бага ангийн сурагчид буюу бага насны хүүхдүүдэд тэдний зан суртахуун болон ёс суртахууны төлөвшилд “багш төвтэй” сургалтын арга барил илүү тохиромжтой болох нь харагдаж байгаа бол дунд, ахлах ангийн сурагчид буюу өсвөр насны хүүхдэд “сурагч төвтэй” сургалт тохиромжтой болох нь харагдаж байна.

Хүснэгт 10-ыг харахад ЕБС-ийн багш нар ёс суртахууны боловсролыг эцэг, эхчүүд өөрснөө үлгэр дууриалал болох (давхардсан тоогоор 57.1 хувь), хичээлийн хөтөлбөрт тусгайлан ёс суртахууны хичээл оруулах (давхардсан тоогоор 45.4 хувь) гэсэн арга хэлбэр нь илүү зохимжтой гэж үзсэн байна. Гэр бүлийн боловсролд нөлөөлөх, Монголын түүх, соёл, уламжлалтай холбоотой ном, сурах бичиг ашиглах нь тийм ч үр дүнтэй биш гэж багш нарын ихэнх нь үзсэн байна.

Хүснэгт 10. Та ЕБС-ийн сурагчдад ёс суртахууны боловсрол, төлөвшлийг ямар байдлаар олгох нь үр дүнтэй гэж бодож байна вэ?

№		Тоо	Тохиолдлын хувь
1	Эцэг эхчүүд үлгэр, дууриалал болох	68	57.1
2	Хичээлийн хөтөлбөрт ёс суртахууны хичээл оруулах	54	45.4
3	Хүүхдийн эрхийг хүндэтгэн, тэдний үзэл бодлыг сонсох, өөрийгөө хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	9	7.6
4	Багшийн мэргэжлийн нэр хүндийг өндөрт өргөх	20	16.8
5	Үе тэнгийнхний болон гадаад сөрөг нөлөөнд автахгүй байхыг анхааруулах	12	10.1
6	Аливаа зүйлд бодитой, шүүмжлэлтэй хандахыг зааж өгөх	15	12.6
7	Гэр бүлийн боловсролд нөлөөлөх	2	1.7
8	Монголын түүх, соёл, уламжлалтай холбон тайлбарласан ном, сурах бичгээр	1	0.8
9	Хэлж мэдэхгүй	1	0.8
	Нийт	182	152.9

Мөн дээрх хүснэгтийг үзэхэд багш нарын нэр хүндийг дээшлүүлэх хэрэгтэй гэж зөвхөн 16.8 хувь нь (давхардсан тоогоор) хариулсан нь анхаарал татаж байна. “Багш мэргэжлийн ёс зүйн мэдлэгийг нэмэгдүүлснээр багш нар болон боловсролын салбарын ажилтнууд ажилдаа сэтгэл хангалуун байх явдлыг нэмэгдүүлэж тэдний сатутсыг дээшлүүлэх, өөрийгөө хүндэтгэх үзлийг нэмэгдүүлэх, нийгэм дэх мэргэжлийн нэр хүндийг өргөхөд хувь нэмэр оруулна”⁶ гэсэн байдаг. Тиймээс манай судалгаанд оролцсон респондентууд багшийн нэр хүндийг өндөрт өргөх нь сурагчдын ёс суртахууны төлөвшилд тийм ч хүчтэй нөлөөлөхгүй гэж хариулсан байна. Гэвч багш хүн сурагчдад үлгэр дууриалал болох чухал хүн мөн билээ. Тиймэрхүү ойлголтыг багш нар өөрснөө

⁶ Олон Улсын боловсролын байгууллагаас гаргасан багшийн ёс зүйн тунхаглал. Боловсрол судлал. Сэтгүүл. УБ., 2005, 02.29 дэх тал. Дам ишлэв.

ухамсарлахгүй, зөвхөн эцэг эхчүүд нь хүүхдийн хумүүжил, ёс суртахууны төлөвшилд нөлөөлж чадна гэдэг итгэл нь анхаарал ихээхэн татаж байна.

Хүснэгт 11. Багшилж буй анги болон ёс суртахууны агуулгатай сурах бичгийн үнэлгээ. /хувиар/

№	Анги	Үнэлгээ										Хэлж мэдэхгүй
		1	2	3	4	5	6	7	8	9	10	
1	Бага	3.1	4.6	7.7	9.2	15.4	29.2	9.2	12.3	3.1	4.6	1.5
2	Дунд	14.7	8.8	2.9	11.8	23.5	8.8	14.7	5.9	0.0	2.9	5.9
3	Ахлах	5.0	15.0	25.0	10.0	15.0	5.0	5.0	15.0	5.0	0.0	0.0
	Бүгд	6.7	7.6	9.2	10.1	17.6	19.3	10.1	10.9	2.5	3.4	2.5


Бидний судалгаанд оролцсон багш нарын нийт 54.6 хувь нь баги анги, 28.6 хувь нь дунд анги болон 16.8 хувь нь ахлах ангид багшилдаг. Бага ангид багшилдаг багш нарын 29.2 хувь нь ёс суртахууны агуулгатай сурах бичгийн үнэлгээнд “6” буюу дундаж үнэлгээ өгсөн байхад дунд ангид багшилдаг нь багш нарын 23.5 хувь нь арай доогуур буюу “5” үнэлгээ өгөв. Хамгийн доогуур үнэлгээг ахлах ангийн багш нарын 25.0 хувь буюу 4 хүний тутам нэг нь өгсөн байна. Нийтдээ 19.3 хувь нь “6” гэсэн үнэлгээ өгсөн нь багш нарын бодлоор ёс суртахууны агуулгатай сурах бичиг тийм ч сайн биш байгааг илтгэж байна. Үүнийг ялангуяа ахлах (зарим багш нар дунд болон ахлах ангид зэрэг багшилдаг билээ) ангид багшилдаг үнэлгээнээс харж болно. Тэдний зөвхөн тус тус 5.0 хувь нь “5”-аас дээгүүр үнэлгээ өгч байгаа нь анхаарлыг татав.

ДӨРӨВ. ЁС СУРТАХУУНТ БАЙДАЛ

Академич С.Нарангэрэл “ёс суртахуун бол төрмөл” хэмээн тодорхойлсон байдаг. Хүн угаас бүрэлдэн буй болохдоо амьдарч буй орчин, нийгмийн бүлэг, хүрээлэл зэргээс шалтгаалан зан суртахууны тодорхой төлөвтэй төрдөг бөгөөд өсөж торних явцдаа өөрийн үнэт зүйл, ёс суртахууны байдал, хэм хэмжээг төлөвшүүлэн бий болгодог. Хүн бүр нийгмийн эд эс болохын хувьд нийгмээс тогтоосон хэм хэмжээнд захирагдахаас гадна, өөрийн төрмөл ёс суртахууны хэм хэмжээнд захирагдан амьдарч байдаг билээ.

Өөрийн зан суртахуун, биеэ авч явах байдал, харилцаа зэрэг нь сурагчидад үлгэр жишээ болж байдаг багш, сурган хүмүүжүүлэгчдийн ёс суртахуунт байдал судалгаад ихээхэн чухал билээ. Тиймээс багш нар өөрийн, хамтран ажиллагсад болон сурагчдын ёс суртахуунт байдлыг хэрхэн үнэлэж байгааг тодруулахыг зорьсон юм.

Зураг 2. Ёс суртахуунт байдлын үнэлгээ



Судалгаанд оролцогсад өөрийн ёс суртахуунт байдлыг 44.1 хувь нь дундаас дээш буюу 7 баллаар үнэлсэн бол өөрийн хамт ажиллагсадыг 31.4 хувь нь өөрийн үнэлгээнээс нэгээр илүү буюу 8 баллаар үнэлсэн байна. Харин сурагчдын ёс суртахуунт байдлыг 23.7 хувь нь дундаж буюу 5 балаар үнэлжээ.

ТАВ. ДҮГНЭЛТ

Академич С.Нарангэрэл нэгэнтээ “*ёс суртахуун бол төрмөл*” хэмээн тодорхойлсон байдаг. Хүн угаас бүрэлдэн буй болохдоо амьдарч буй орчин, нийгмийн бүлэг, хүрээлэл зэргээс шалтгаалан зан суртахууны тодорхой төлвийг өвлөн төрдөг бөгөөд өсөж торних явцдаа өөрийн үнэт зүйл, ёс суртахууны байдал, хэм хэмжээг төлөвшүүлэн бий болгодог. Хүн бүр нийгмийн эд эс болохын хувьд нийгмээс тогтоосон хэм хэмжээнд захирагдахаас гадна, өөрийн төрмөл ёс суртахууны хэм хэмжээнд захирагдан амьдарч байдаг билээ.

Судалгааны баг энэхүү судалгаагаар өнөөгийн боловсролын тогтолцоон дахь ёс суртахуунт байдал ямар байгаа, энэхүү байдал нь сурагчдын ёс суртахууны төлөвшилд хэрхэн нөлөөлж байгааг мөн ёс суртахууны боловсрол, төлөвшил олгоход материаллаг бааз, ном хэрэглэгдэхүүний чанар, хүртээмж ямар байгааг тодруулан гаргахыг зорьсон болно.

Ёс суртахууныг боловсролын байгууллагаар, хичээлийн агуулгаар дамжуулан олгоход тулгарч буй бэрхшээл, боловсролын байгууллагын ёс суртахуунт байдал ямар түвшинд байгаа, ёс суртахууны төлөвшлийг хэрхэн үнэлэх зэргийг цаашид нарийвчлан судлах шаардлагатай байна.

Ёс суртахуун нь хүний аливаа зүйлд хандах хандлага, асуудлыг шийдвэрлэх, бэрхшээлийг давж гарах, бусадтай харилцах, тэдэнд туслах зэрэг үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэн гарч байдаг. Ёс суртахууны боловсрол олгох гэдэг нь бие хүн болж төлөвшихөд эергээр нөлөөлөх сэтгэлийн боловсрол олгож буй байдал гэж ойлгож болох юм. Ёс суртахууны төлөвшил тасралтгүй хөгжиж, өөрчлөгдөн хувьсаж, шинэчлэгдэж байдаг динамик шинжтэй байдаг. Хүүхдэд ёс суртахууны боловсрол, төлөвшлийг бие хүний эрхийг нь хүндлэн, өөрийг нь хөгжих, өөрийгөө олж нээхэд туслах замаар зохистой байдлаар олгох нь чухал байгаагаас гадна эцэг, эх, сурган хүмүүжүүлж буй багш, олон нийтийн ёс суртахуунт байдлыг хэрхэн төлөвшүүлэх асуудал мөн чухал байна.

ЁС СУРТАХУУНЫ БОЛОВСРОЛ
Судалгааны үр дүнгийн хүснэгт

1. Таны нас

<i>№</i>		<i>Тоо</i>	<i>Хувь</i>
1	24 нас хүртэл	6	5.0
2	25-34	47	39.5
3	35-44	37	31.1
4	45-54	25	21.0
5	55-аас дээш	4	3.4
	Нийт	119	100.0

2. Хүйс

<i>№</i>		<i>Тоо</i>	<i>Хувь</i>
1	Эрэгтэй	22	18.5
2	Эмэгтэй	97	81.5
	Нийт	119	100.0

3. Та хэдэн жил багшилж байгаа вэ?

<i>№</i>		<i>Тоо</i>	<i>Хувь</i>
1	10 жил хүртэл	59	49.6
2	11-20 жил	26	21.8
3	21-30 жил	26	21.8
4	31-50 жил	8	6.7
	Нийт	119	100.0

4. Та ямар ангид хичээл заадаг вэ?

<i>№</i>		<i>Тоо</i>	<i>Хувь</i>
1	Бага анги	65	54.6
2	Дунд анги	34	28.6
3	Ахлах анги	20	16.8
	Нийт	119	100.0

5. Та анги дааж авсан уу?

<i>№</i>		<i>Тоо</i>	<i>Хувь</i>
1	Тийм	83	69.7
2	Үгүй	36	30.3
	Нийт	119	100.0

6. Таны ажиллаж буй сургууль:

<i>№</i>		<i>Тоо</i>	<i>Хувь</i>
1	Улсын сургууль	76	63.9
2	Хувийн сургууль	43	36.1
	Нийт	119	100.0

7. Таны ажиллаж буй сургууль /хот, аймаг/

<i>№</i>		<i>Тоо</i>	<i>Хувь</i>
1	Улаанбаатар	107	89.9
2	Дундговь	8	6.7
3	Дорнод	1	0.8
4	Увс	1	0.8
5	Говьсүмбэр	2	1.7
	Нийт	119	100.0

8. Таны ажиллаж буй сургууль /сум, дүүрэг/

<i>№</i>		<i>Тоо</i>	<i>Хувь</i>
1	Сүхбаатар дүүрэг	33	27.7
2	Чингэлтэй дүүрэг	28	23.5
3	Сонгинохайрхан дүүрэг	1	0.8
4	Баянгол дүүрэг	11	9.2
5	Баянзүрх дүүрэг	22	18.5
6	Хан-Уул дүүрэг	11	9.2
7	Налайх дүүрэг	1	0.8
8	Сайнцагаан сум	7	5.9
9	Мандал сум	1	0.8
10	Хэрлэн сум	1	0.8
11	Тариалан сум	1	0.8
12	Шивээговь сум	2	1.7
	Нийт	119	100.0

9. Хувь хүний хүмүүжил, ёс суртахуун төлөвших үйл явцад дараах хүчин зүйлс (хувиар)

<i>№</i>		<i>Огт нөлөөлд өггүй</i>	<i>Бараг нөлөөлд өггүй</i>	<i>Ер нь нөлөөлд өг</i>	<i>Маш их нөлөөлд өг</i>	<i>Хэлж мэдэхгүй</i>
1	Удам угсаа, гарал үүсэл	8.4	16.0	38.7	32.8	4.2
2	Гэр бүлийн хүмүүжил	2.5	4.2	4.2	88.2	0.8
3	Амьдарч буй орчин	3.4	9.2	42.9	42.0	2.5
4	Материаллаг байдал	5.9	27.7	49.6	10.1	6.7
5	Боловсрол	4.2	10.1	41.2	43.7	0.8
6	Хувь хүний ухамсар	2.5	5.0	17.6	73.0	0.8
7	Үндэсний уламжлал, ёс заншил	4.2	17.6	52.9	22.7	2.5
8	Шашин шүтлэг	10.9	33.6	38.7	4.2	12.6
9	Улс төрийн нөхцөл байдал	21.0	34.5	25.2	3.4	16.0
10	Гадаад соёл	7.6	29.4	45.4	10.9	6.7

10. Та ЕБС-ийн сурагчдад ёс суртахууны боловсрол, төлөвшлийг ямар байдлаар олгох нь үр дүнтэй гэж бодож байна вэ?

<i>№</i>		<i>Тоо</i>	<i>Тохиолдлын хувь</i>
1	Эцэг эхчүүд хүүхдэд ес суртахууны үлгэр, дууриалал болох	68	57.1
2	Хичээлийн хөтөлбөрт ёс суртахууны хичээл оруулах	54	45.4
3	Хүүхдийн эрхийг хүндэтгэн, тэдний үзэл бодлыг сонсох, өөрийгөө хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	9	7.6
4	Багшийн мэргэжлийн нэр хүндийг өндөрт өргөх	20	16.8
5	Үе тэнгийнхний болон гадаад сөрөг нөлөөнд автахгүй байхыг анхааруулах	12	10.1
6	Аливаа зүйлд бодитой, шүүмжлэлтэй хандахыг зааж өгөх	15	12.6
7	Гэр бүлийн боловсролд нөлөөлөх	2	1.7
8	Монголын түүх, соёл, уламжлалтай холбон тайлбарласан ном, сурах бичгээр	1	0.8
9	Хэлж мэдэхгүй	1	0.8
	Нийт	182	152.9

11. Ёс суртахууны чиглэлээр ЕБС-ийн хичээлийн хөтөлбөрт ашиглагдаж буй сурах бичгийн агуулгыг үнэлнэ үү

<i>№</i>	<i>Үнэлгээ</i>	<i>Тоо</i>	<i>Хувь</i>
1	1	8	6.7
2	2	9	7.6
3	3	11	9.2
4	4	12	10.1
5	5	21	17.6
6	6	23	19.3
7	7	12	10.1
8	8	13	10.9
9	9	3	2.5
10	10	4	3.4
11	Хэлж мэдэхгүй	3	2.5
	Нийт	119	100.0

12. Сурагчдад ёс суртахууны боловсрол, мэдлэг олгоход тусгайлсан сурах бичиг ашиглах шаардлага бий юу?

<i>№</i>		<i>Тоо</i>	<i>Хувь</i>
1	Маш их шаардлагатай. Тусгайлсан сурах бичиг хэрэгтэй байна	64	53.8
2	Зарим талаар шаардлагатай. Агуулга, төрлөөс шалтгаална	41	34.5
3	Тийм ч шаардлагатай биш. Одоо байгаа сурах бичгийн агуулга хангалттай	5	4.2
4	Шаардлага байхгүй. Ёс суртахууны боловсрол нь сурах бичгээр олгох зүйл биш	6	5.0
5	Хэлж мэдэхгүй	3	2.5
	Нийт	119	100.0

13. Ёс суртахууны боловсрол, мэдлэгийг ямар төрлийн бүтээл, үйл ажиллагаагаар олгох нь зохистой вэ?

<i>№</i>		<i>Тоо</i>	<i>Тохиолдлын хувь</i>
1	Үлгэр, домог, сургамжит өгүүлэмж	46	23.4
2	Кино контент	28	14.2
3	Кейс сургалт	43	21.8
4	Соёлын арга хэмжээ (Музей, театр, үзэсгэлэн)	34	17.3
5	Нийтэд тустай сайн дурын үйл ажиллагаа	46	23.4
	Нийт	197	166.9

14. Сурагчид хэнийг илүүтэй үлгэр дуурайл болгодог вэ?

<i>№</i>		<i>Тоо</i>	<i>Тохиолдлын хувь</i>
1	Эцэг, эх	79	66.4
2	Гэр бүлийн гишүүд	49	41.2
3	Найз нөхөд	31	26.1
4	Ахмад үе	5	4.2
5	Багш, сурган хүмүүжүүлэгч	46	38.7
6	Улс төрч	1	0.8
7	Бизнесмен	1	0.8
8	Жүжигчин, дуучин	10	8.4
9	Нийгмийн сүлжээн дэх нэр хүнд бүхий хүн	20	16.8
	Нийт	242	203.4

15. Ямар хүчин зүйлс сурагчдын зан суртахуунд сөргөөр нөлөөлж байна гэж Та үзэж байна вэ? (хувиар)

<i>№</i>		<i>Маш их нөлөөтэй</i>	<i>Ер нь нөлөөлөх дөг</i>	<i>Бараг нөлөөлөх дөггүй</i>	<i>Огт нөлөөлөх дөггүй</i>	<i>Хэлж мэдэхгүй</i>
1	Нийгмийн сүлжээ	63.0	28.6	3.4	1.7	3.4
2	Онлайн тоглоом	71.4	21.0	2.5	0.8	4.2
3	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис	46.2	30.3	3.4	0.8	19.3
4	Гэр бүлийн хүчирхийлэл	68.9	26.1	1.7	-	3.4
5	Гэр бүл салалт	77.3	18.5	0.8	0.8	2.5
6	Эцэг, эхийн хараа хяналтгүй байдал	73.1	21.8	0.8	0.8	3.4
7	Нийгмийн тэгш бус байдал	27.7	57.1	5.9	-	9.2
8	Үерхэл, хайр сэтгэл	29.4	49.6	10.1	1.7	9.2
9	Мөнгө, санхүүгийн байдал	23.5	49.6	19.3	0.8	6.7
10	Сургуулийн орчин	27.7	57.1	5.9	2.5	6.7

16. Сургуулийн орчинд дараах асуудал хэр их гардаг вэ?

№		Огт гардаггүй	Бараг гардаггүй	Ер нь гардаг	Тогтм ол гардаг	Хэлж мэдэхгүй
1	Ашиг сонирхлын зөрчил	16.8	26.1	35.3	8.4	13.4
2	Хүүхдийг гэр бүлийн байдал, хөгжил, суралцах чадвараар ялгаварлан гадуурхах	18.5	37.0	31.9	5.9	6.7
3	Сурагчдын гэр бүлээс бэлэг сэлт өгөх	16.8	39.5	35.3	2.5	5.9
4	Хүүхдийн бие махбод, сэтгэл санааны шийтгэл үзүүлэх аливаа үйлдэл	17.6	46.2	23.5	1.7	10.9
5	Багш сурагч хоорондын харилцаанд үл ойлголцол гарах	5.9	37.8	43.7	6.7	5.9
6	Ном, сургалтын хэрэглэгдэхүүнийг тулган борлуулах	36.1	35.3	19.3	1.7	7.6
7	Сурагчид бие биенээ ялгаварлан гадуурхах	10.1	22.7	52.1	8.4	6.7

17. Та өөрийн ёс суртахуунт байдлыг хэрхэн үнэлэх вэ?

№	Үнэлгээ	Тоо	Хувь
1	2	1	0.8
2	3	1	0.8
3	4	5	4.2
4	5	7	5.9
5	6	16	13.6
6	7	52	44.1
7	8	21	17.8
8	9	21	17.8
9	10	11	9.3
10	Хэлж мэдэхгүй	1	0.8
	Нийт	119	100.0

18. Та өөрийн хамт ажиллагсадын ёс суртахуунт байдлыг хэрхэн үнэлэх вэ?

№	Үнэлгээ	Тоо	Хувь
1	1	1	0.8
2	2	1	0.8
3	3	2	1.7
4	4	9	7.6
5	5	9	7.6
6	6	20	16.9
7	7	13	11.0
8	8	37	31.4
9	9	23	19.5

10	10	3	2.5
11	Хэлж мэдэхгүй	1	0.8
	Нийт	119	100.0

19. Та сурагчдын ёс суртахуунт байдлыг хэрхэн үнэлэх вэ?

<i>№</i>	<i>Үнэлгээ</i>	<i>Тоо</i>	<i>Хувь</i>
1	1	1	0.8
2	2	5	4.2
3	3	12	10.2
4	4	15	12.7
5	5	28	23.7
6	6	21	17.8
7	7	16	13.6
8	8	17	14.4
9	9	3	2.5
10	Хэлж мэдэхгүй	1	0.8
	Нийт	119	100.0



ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ,
ОЛОН НИЙТИЙН АЖИЛ

С.НАРАНГЭРЭЛ: УЛС ОРНЫ ХӨДӨЛГӨГЧ ХҮЧ НЬ АЛТ, ЗЭС, НҮҮРС БИШ, ӨНДӨР ЁС СУРТАХУУН ЮМ

🕒 2019-04-15

📄 Үзэл бодол

👁 555

📱 Share

🐦 Tweet




Хуульч, академич С.Нарангэрэл өнгөрсөн бямба гаригт Эрдмийн их сургуулийн магистр, докторантуудад “Ёс зүйг дээдлэхүй” сэдвээр талаар лекц уншсан юм. Түүний лекцээс зарим улс орнуудын ёс суртахууны талаар ярьсан хэсгийг тоймлон хүргэе.

-Тэрээр “Япончууд дэлхийн шинжлэх ухаан, технологийн салбарт ноёлж, сонгодог ард түмэн болоход тухайн улсын үндэсний ёс суртахуун, аливааг шийдвэрлэх үйл явц нь чухал нөлөөтэй байсан. Япон эрт үеэс Бушидо үзлийг ёс суртахууны гол соёл

docx ^

С.Нарангэрэл: Монголыг ёс суртахуун л аварна

□ 2018-11-10 / Уранчимэг / □ 36 сэтгэгдэл



Монголд хуульчдын нэр хүнд унаж байгаа энэ үед салбараа өнгөлж, амьдралаараа ёс суртахууны үлгэр дуурайлал болж яваа хүн бол хуульч, Эмирет профессор С.Нарангэрэл юм. Түүнтэй хийсэн ярилцлагаа хүргэж байна.



-Өнгөрсөн долоо хоногт таны хүртсэн Эмирет профессор хэмээх эрхэм хүндтэй цолыг танаас өмнө МУИС-ийн хоёрхон багш л авч байсан юм билээ. Энэхүү шагналаар энгэрээ мялаалгах үедээ та хамгийн түрүүнд багш нараа дурсаж, талархлаа илэрхийлж байсан. Та сэтгэгдлээ хуваалцахын зэрэгцээ багш нарыгаа дахин дурсахгүй юу?

-МУИС-д 43 жил ажиллаж, Хууль зүйн тэнхимийг арав гаруй жил удирдсан миний хөдөлмөр зүтгэлийг үнэлэж энэхүү нэр хүндтэй шагналыг өгсөнд мэдээж талархалгүй яах вэ. Би Монголын хууль зүйн салбарын ноён оргилууд болсон Г.Совд, Б.Чимэд, Д.Лувсаншарав зэрэг мундаг сайн багш нараар ном заалгаж байлаа. Мөн Физикч Н.Содном, хэл шинжээч Чой.Лувсанжав багш нарынхаа номын дуг сонсож явсандаа өдий зэрэгт хүрсэн. Багш нараараа ном эрдэм заалгаад эцсийн дүндээ би юу ойлгож авсан бэ гэхээр хууль гэдэг бол хууль тогтоогчдын баталж гаргасан хэм хэмжээний цогц биш юм байна. Хууль гэдэг хүний эрхэм дээд зан чанар юм. Тухайлбал, шударга, нинжин нигүүлсэнгүй зан чанар, жудаг, нэр төр, тэсвэр тэвчээр, өгөөмөр зан, урвашгүй зан гэх мэтчилэн ёс суртахууны эрхэм өгөгдлүүдийг агуулдаг. Ёс суртахуун бол хуулийн амин сүнс юм. Хэрэв ёс суртахууныг ноцтой зөрчсөн бол хуулийн цээрлэлийг гүйцэлдүүлдэг. Энэ талаар миний хийсэн судалгааны ажлыг МУИС үнэлж, энэхүү шагналыг олгосон байх.



-Сүүлийн үед хуульчдын нэр хүнд маш их унаж байна. Хөрөнгө орлогын мэдүүлгээрээ зарим хуульчид зард гарч байна. Та залуу үедээ юу хэлэх вэ?

-Хуульчийн мэргэжлийн гол онцлог бол шударга ёсыг тогтооход л оршино. Гэтэл сүүлийн жилүүдэд мөнгөний хуульчид олширсон. Одоо хуульчдыг хайрлаж хүндэтгэдэг ард түмний төлөөлөл маш цөөхөн болжээ. Шүүгчдийг шүүмжилж байгаа нь ч аргагүй юм. Монголын хуульчид нэр төрөө

6 минутын өмнө



Баянбүрдийн тойргийг энэ амралтын өдрүүдэд хэсэгчилж хаана

36 минутын өмнө



А.Амбасэлмаа: Нийт 194 хүнд шинжилгээ хийхэд коронавирус илрээгүй, хоёр иргэн эдгэрлээ

41 минутын өмнө



Д.Нарангэрэл: Өчигдөр шинээр 541 хүн ажиглалтад орж, 274 гэрийн тусгаарлалтад шилжлээ

51 минутын өмнө



Хөвсгөл аймагт ойн түймэр гарчээ

56 минутын өмнө



ОХУ-ын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг дэмжив

цагайн өмнө



Хоол үйлдвэрлэлийн газруудын 59.6 хувь нь стандарт, чанарын шаардлага хангахгүй байна

цагайн өмнө



Хуулийн байгууллагад гаргасан гомдлоо цахимаар хянах боломжтой

цагайн өмнө

ip.ac.mn/c/1013593?content=991307

YouTube Translate

ДИНАМИК ПЛАТФОРМ ЦАХИМ ШУУДАН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН САН ШИЛЭН ДАНС ХОЛБОО БАРИХ

МОНГОЛУСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ФИЛОСОФИЙН ХҮРЭЭЛЭН

Эхлэл Бидний тухай Эрдэмтэд Эрдэм шинжилгээ Салбарууд Мэдээ, мэдээлэл Тайлан, төлөвлөгөө Цахим сан

“НИЙГЭМД ЁС СУРТАХУУНЛАГ ИРГЭН ОЛОН БОЛОХООР ТУХАЙН УЛС ОРОН ХӨГЖДӨГ, ДЭВЖДЭГ”

Буцах Н.НАЦАГНИМ 8 сарын өмнө



- Уулзалт, ярилцлага
- Эрдэм шинжилгээний хурал
- Семинар
- Мэдээ мэдээлэл
- Шинэ номын мэдээ
- Аудио, Видео
- Зарлал
- Уулзалт, ярилцлага

<https://chandmani.space/archives/2807>

f t e p

ikon.mn/n/1jzz

Apps Gmail YouTube Translate

7 сарын 3, Баасан

ДАРХАН 26°C | EUR 3188

С.Нарангэрэл: Монголчууд энэ дэлхийн хамгийн жудаггүй ард түмэн болсон

С.ОТГОНБАЯР, ӨДРИЙН СОНИН
2019 ОНЫ 4 САРЫН 22

ЖИРГЭХ 19025

ӨДРИЙН СОНИН



Гэрэл зургийг Mpa.mn

“Монголчуудын үнэт зүйл” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал боллоо. Хуралд Монголын нэр нөлөө бүхий эрдэмтэн шинжээчид, судлаачид бүгд ирсэн байв. Тус хурлаас “Монголчуудын ёс суртахууны үнэт зүйл” сэдвээр Академич, МУИС-ийн эмирет профессор С.Нарангэрэл илтгэл тавьсан юм. Түүний илтгэлийг онцлон хүргэж байна.

ХҮН ТӨРӨЛХТНИЙ ХАМГИЙН ҮНЭ ЦЭНЭТЭЙ МӨНХИЙН ЗҮЙЛ ЁС СУРТАХУУН БОЛОХ НЬ

Хуулийн амин сүнс гэж байх ёстой. Хуулийн амин сүнс нь тэгэхээр юу байдаг, хаана байдаг вэ гэдгийг судалж гаргахгүйгээр үүнийг ойлгох боломжгүй. Энэ судалгаа нь маш олон талтай.

://ikon.mn/n/1xhe физик, тархи судлал, түүх, сэтгэл судлал, хэл шинжлэл, урлаг, утга зохиол, соёл, мөн

ЗӨВЛӨГӨӨ: Цар тахлын үед шүдний эмнэлгүүд хэрхэн ажиллах вэ?

6 | 23 минут

Токиод шинээр бүртгэгдсэн 107 тохиолдлын дийлэнх нь шөнийн клубүүдээр үйлчлүүлсэн 20-30 насныхан байна”

11 | 29 минут

Хүнд даацын тоног төхөөрөмжийн танилцуулгыг анх удаа онлайнаар дамжууллаа

2 | 39 минут

А Амбасэлмаа: Хоёр хүн эдгэрч ХӨСҮТ-өөс гаран, дараагийн ажиглалт руу шилжиж байна

243 | 52 минут

SAMSUNG Galaxy S20 Serie



ГДААГИЙН ЕР ГАЗАР

Д.Будзаан: Энэ оны эхний хагас жилд гэхэд 26 хүүхэд зам тээврийн ослын улмаас нас барсан байна





С.Нарангэрэл: Монголын хөгжлийн хамгийн том тээг нь бидний ёс суртахууны доройтол

2017-08-29 | Уншсан: 1325



Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, академич Содовсүрэнгийн Нарангэрэлийг "Хоймор"-тоо урилаа. "Үйлийн үр, ёс суртахууны хариуцлага хуулийн хариуцлагаас ч хатуу" гэдэг үгийг тэрбээр нэг бус удаа хэлсэн нь бий. Хичээл заалгасан, заалгаагүй маш олон хүн түүнийг "Нарангэрэл багш" хэмээн хүндэтгэдгийн цаад шалтгаан магадгүй энэ байж ч болох. 46 жилийн тэртээ нэрт хуульч аавынхаа хүслийг гүйцээн, мэргэжлийг нь өвлөсөн хүү өдгөө ард түмнийхээ өмнө хэлэх үгтэй, хийсэн гавьяатай эрхэм нэгэн болжээ.

-Та сүүлийн үеийн судалгааны бүтээлүүддээ ёс суртахууны тухай нэлээд бичсэн байна лээ. Ёс суртахуун гэж чухам юу юм бэ. Энэ нь аливаа хүнд байгалиас заяагддаг юм уу, эсвэл үүсмэл зүйл үү?

ГИШҮҮН НЭВТРЭХ

Нэвтрэх нэр:

Регистрийн дугаар эсвэл Э-мэйл хэ

Нууц үг:

НУУЦ ҮГ ШИНЭЭР АВАХ

НЭВТРЭХ

ШИНЭ МЭДЭЭ

ИХ УНШСАН

АЗИ, НОМХОН ДАЛАЙН БУС НУТГИЙН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ 33 ДАХЬ УДААГИЙН ЧУУЛГА УУЛЗАЛТ ЦУЦЛАГДЛАА
2020-07-01

ХУУЛЬЧДЫГ "ХҮНДЭТ ТЭМДЭГ"-ЭЭР ШАГНАЛАА
2020-06-29

ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ХОРООНООС ЗОХИОН БАЙГУУЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛГҮҮДИЙН ИЛТГЭЛИЙГ ЭМХЭТГЭН ХЭВЛҮҮЛЭЭ
2020-06-26

МЭНДЧИЛГЭЭ

2020-06-26

ХУУЛЬЧИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА



С.Нарангэрэл: Ёс суртахууны хариуцлага хуулийн хариуцлагаас ч хатуу

Сөмбө
2018-06-28 15:30



Сэтгэгдэл (10)

Шэйрлэх

Жиргэх

Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, академич Содовсүрэнгийн Нарангэрэлийг редакцийнхаа хойморьт урилаа. Тэрээр олон мянган шавьдаа эрх зүйн мэдлэг олгохоос гадна ёс суртахуунтай байх, эрхэм чанараа гээдэггүй байхыг үргэлж захиж явдаг багш хүн. Тэр миний ч гэсэн багш. "Үйлийн үр, ёс суртахууны хариуцлага нь хуулийн хариуцлагаас ч хатуу. Хэн ч энэ хариуцлагаас тойрдоггүй" гэсэн түүний хэлэх дуртай үгээр нь ярилцлагаа эхлүүлье.

-Багш аа, би таньтай хоёр сэдвийн хүрээнд ярилцъя. Нэг нь таны ярих дуртай ёс суртахууны тухай. Хоёр дахь нь Батлан хамгаалах салбарын эрх зүйн орчны тухай?

-Болно, болно.

-“Ёс суртахууныг шинжлэх ухаанаар тайлбарлавал” хэмээх оюутан залууст зориулсан илтгэлийг тань сая сонслоо. Ёс суртахуунлаг иргэн байхыг шинжлэх ухааны өнцгөөс тайлбарлалаа гэж бодлоо?

-Одоогоос хэдэн зуун жилийн өмнө монголчууд ёс суртахууныхаа эрхэм нандин